

Улсын Их Хурлын хэлэлцүүлэгт

1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2016-2017 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
2. МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
4. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
5. ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
6. НИЙСЛЭЛ ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

2014 оны 12 дугаар сар

Улаанбаатар хот

НЭГ. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2016-2017 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

- 1.1. Хуулийн төслийн үзэл баримтлал
- 1.2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- 1.3. Хуулийн төслийн танилцуулга
- 1.4. Хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төслүүд
 - 1.4.1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга
 - 1.4.2. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

- 2.1. Хуулийн төслийн үзэл баримтлал
- 2.2. Хуулийн төсөл
- 2.3. Хуулийн төслийн 1-р хавсралт. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт
- 2.4. Хуулийн төслийн 2-р хавсралт. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
- 2.5. Хуулийн төслийн танилцуулга
- 2.6. Хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төслүүд
 - 2.6.1. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
 - 2.6.2. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
 - 2.6.3. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
 - 2.6.4. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
 - 2.6.5. Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
 - 2.6.6. Тахрын албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
 - 2.6.7. Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
 - 2.6.8. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
 - 2.6.9. Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
 - 2.6.10. Орон сууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

- 2.6.11. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 2.6.12. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 2.6.13. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 2.6.14. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 2.6.15. Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- 2.6.16. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 2.6.17. Нийгмийн даатгалын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай
- 2.6.18. Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 2.6.19. УИХ-ын тогтоол (Тогтоолын заалт хүчингүй болгох тухай)
- 2.6.20. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 2.6.21. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай
- 2.6.22. Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай
- 2.6.23. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 2.6.24. Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 2.6.25. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 2.6.26. Өрсөлдөөний тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай

ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

- 3.1. Хуулийн төслийн үзэл баримтлал
- 3.2. Хуулийн төсөл
- 3.3. Хуулийн төслийн танилцуулга

ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

- 4.1. Хуулийн төслийн үзэл баримтлал
- 4.2. Хуулийн төсөл
- 4.3. Хуулийн төслийн танилцуулга

- 4.4. Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулга
- 4.5. Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулга

ТАВ. МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТООЦООЛЛЫН ХАВСРАЛТУУД

ЗУРГАА. ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- 6.1. Хуулийн төслийн үзэл баримтлал
- 6.2. Хуулийн төсөл
- 6.3. Хуулийн төслийн танилцуулга
- 6.4. Дагалдах хуулийн төслүүд
 - 6.4.1. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
 - 6.4.2. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
 - 6.4.3. Бууны албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай
 - 6.4.4. Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийг хүчингүй болсонд тооцох тухай
 - 6.4.5. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай
 - 6.4.6. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай
 - 6.4.7. Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

ДОЛОО. НИЙСЛЭЛ ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

- 7.1. Хуулийн төслийн үзэл баримтлал
- 7.2. Хуулийн төсөл
- 7.3. Хуулийн төслийн танилцуулга

**НЭГ. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН
ТӨСВИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2016-2017 ОНЫ
ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ**



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2016-2017 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “Төсөв” гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг;” гэж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-т “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичгийг гэж, 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэж тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль эрх зүйн үндэслэл болж байна.

Дэлхийн эдийн засагт гарч байгаа өөрчлөлтийн улмаас экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ буурах хандлагатай байгаа төдийгүй Оюутолгойн ордын үйлдвэрлэлийн хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс буурч, нүүрсний олборлолт багассанаар 2014 онд дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрэхээргүй байгаа нь 2015 оны дотоодын нийт бүтээгдэхүүнд мөн нөлөөлөхөөр байна. Түүнчлэн, манай улсын уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох зэсийн баяжмалын олборлолт, баяжуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт гарч, бүтээгдэхүүний агуулга, гарц багассан ба дэлхийн зах зээлийн үнэ буурснаас жоншны борлуулалт багасахаар тооцогдож байна.

Дээрх өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах үед тооцсон эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ, хэмжээ, төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, ялангуяа ДНБ-ий хэмжээ буурахаар байна. Өөрөөр хэлбэл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн орлого, нийт зарлага болон нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-нд эзлэх хувь хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг эдийн засгийн үндсэн болон тоон үзүүлэлтүүдийг хүснэгтээр батлах тухай, хууль хүчин төгөлдөр болох хугацаа гэсэн хоёр зүйлтэй байна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар макро эдийн засгийн суурь үзүүлэлт түүний дотор Монгол Улсын төсвийн ихэнх хувийг бүрдүүлдэг уул уурхайн салбараас төвлөрүүлэх орлогыг зөв тооцож улсын төсвийг үр нөлөөтэй зөв төлөвлөх, хуваарилах асуудал бодитой болох юм.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох хуулийн талаархи санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... сар ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ,
2016-2017 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 1 дүгээр зүйл:

“1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг дор дурдсанаар баталсугай:

	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2015 он	2016 он	2017 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	7.1	9.1	10.8
2	Хэрэглээний үнийн индексийн дундаж түвшин	7.0	7.0	7.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	6,254.3	6,504.5	6,894.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	26.1	23.7	21.9
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	7,413.2	7,601.2	7,849.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	30.9	27.6	24.9
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	60.5	188.0	247.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	0.3	0.7	0.8

6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,158.8	-1,096.7	-954.3
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-4.8	-4.0	-3.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,898.2	1,763.8	1,590.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	7.9	6.4	5.0
8	Улсын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	16,792.0	17,871.9	18,920.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	70.0	65.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	254.8	267.5	280.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.1	1.0	0.9

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2016-2017 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлын 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай” хуулийг баталсан. Тус хуулийн зорилт нь дунд хугацаанд Монгол Улсын нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бөгөөд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үндсэн үзүүлэлтүүдийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг **7,201.1 тэрбум төгрөг** буюу ДНБ-ий **29.4 хувь**, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг **7,690.9 тэрбум төгрөг** буюу **ДНБ-ий 31.4 хувь**, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 489.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувьтай байхаар тус тус баталсан.

Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас Монгол Улсын 2014 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 1.0 их наяд гаруй төгрөгөөр буурахаар байгаа бөгөөд ирэх 2015 онд ч эдийн засгийн нөхцөл байдал энэ оныхоос сайжрах төлөв байдал ажиглагдахгүй байгаа тул ирэх 2015 оны төсвийн орлогыг бодитойгоор тооцох, батлагдсан хэмжээг бууруулах шаардлагатай байгаа нь “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны Төсвийн төсөөллийн тухай” хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Мөн Хөгжлийн банк болон бусдаар дамжин хэрэгжүүлэх төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсөвт тусгах болон улсын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттайгаар бууруулж ДНБ-ий 40 хувьд хүргэх шаардлага байна.

Иймд 2015 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр батлагдсан төсвийн орлогыг бодитойгоор дахин төлөвлөх, урсгал болон хөрөнгийн зардлыг орлоготойгоо уялдуулан дахин тооцох, Хөгжлийн банкаар дамжин хэрэгжүүлэх төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсөвт тусгах, улсын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттайгаар бууруулах зорилгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2015 ОНЫ
ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2016-2017 ОНЫ
ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАХ
ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга
2. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.6, 19.7 дахь хэсэг нэмсүгэй:

“19.6.Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлыг 2015 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувь, 2016 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувь, 2017 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувь, 2018 оны төсвийн жилээс эхлэн тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас тус тус хэтрэхгүй байна.

19.7.Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн улсын нийт өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 онд 70 хувь, 2016 онд 65 хувь, 2017 онд 60 хувь, 2018 онд 50 хувь, 2019 оны төсвийн жилээс эхлэн 40 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна.”

2 дугаар зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“19.1.Энэ хуулийн 6.1.2-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2018 оны төсвийн жилээс, 6.1.3-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2013 оны төсвийн жилээс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “2014 оны” гэснийг “2019 оны” гэж, мөн зүйлийн 19.6 дахь хэсгийн дугаарыг “19.8” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Амжилттай хөгжсөн, хөгжиж буй улсуудын хувьд хөгжлийн эхэн үедээ тусгайлсан хөгжлийн хөрөнгө оруулалтыг хийх үүрэгтэй санхүүгийн институцийг байгуулж, түүгээрээ дамжуулан хөгжлийн хөрөнгө оруулалт хийдэг нийтлэг туршлагад үндэслэн манай улс 2010 оноос эхлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хийх ерөнхий механизмыг тусган, улмаар Хөгжлийн банкныг 2012 онд байгуулсан.

Өнөөгийн байдлаар Хөгжлийн банкаар хийгдэх санхүүжилт нь зөвхөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн өрийн тусгай шаардлагаар хязгаарлагдаж байгаа бөгөөд Хөгжлийн банкаар дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний зарцуулалтыг төсөвт тусгахгүйгээр зарцуулж байна.

Хөгжлийн банк болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсөвт тусгах тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлыг 2015 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувь, 2016 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувь, 2017 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувь, 2018 оны төсвийн жилээс эхлэн тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас тус тус хэтрэхгүй байхаар хуулийн төсөл боловсрууллаа. Дээрх хугацаанд үндсэн төсвийн хувьд алдагдал 2 хувийн тусгай шаардлагыг хангах бөгөөд зөвхөн Хөгжлийн банк болон бусдаар дамжин хэрэгжүүлэх төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийг төсөвт тусгахтай холбоотой зардлаар төсвийн тэнцэл өөрчлөгдөх юм.

Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан өрийн тусгай шаардлагын дагуу өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн улсын өрийн хэмжээ 2014 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр ДНБ-ий 55 орчим хувьд гарахаар байгаа тул өрийн тусгай шаардлагыг хуульд заасан ДНБ-ий 40 хувьд хүргэх шилжилтийн зохицуулалтыг хуульд тусгах зайлшгүй шаардлагатай байна. Өрийн тусгай шаардлагыг хангахын тулд улсын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттайгаар бууруулан 2019 оны төсвийн жилд хуульд заасан ДНБ-ий 40 хувьд хүргэн бууруулахаар холбогдох өөрчлөлтийг боловсрууллаа.

-----oOo-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.2.8 дахь заалт нэмсүгэй:

“33.2.8.төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хэмжээг нийт дүнгээр.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

Амжилттай хөгжсөн, хөгжиж буй улсуудын хувьд хөгжлийн эхэн үедээ тусгайлсан хөгжлийн хөрөнгө оруулалтыг хийх үүрэгтэй санхүүгийн институцийг байгуулж, түүгээрээ дамжуулан хөгжлийн хөрөнгө оруулалт хийдэг нийтлэг туршлагад үндэслэн манай улс 2010 оноос эхлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хийх ерөнхий механизмыг тусган, улмаар Хөгжлийн банкныг 2012 онд байгуулсан.

Өнөөгийн байдлаар Хөгжлийн банкаар хийгдэх санхүүжилт нь зөвхөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн өрийн тусгай шаардлагаар хязгаарлагдаж байгаа бөгөөд Хөгжлийн банкаар дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний зарцуулалтыг төсөвт тусгахгүйгээр зарцуулж байна.


Хөгжлийн банк болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсөвт тусгах зорилгоор Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулаад байна. Үүнд:

1/ УИХ-аар төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хэмжээг нийт дүнгээр батлахаар холбогдох хуулийн өөрчлөлтийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар төсвөөс гадуурх зарцуулалтыг төсөвт тусган батлах боломж бүрдэх юм.

-----oOo-----

**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ**



МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан. Ингэснээр 2015 оны төсвийн хуулийг батлахад үндэслэсэн Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөн нь төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Төсвийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтад төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их хуралд өргөн мэдүүлнэ гэж, 6.2.3-т урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлнэ гэж тус тус заасан нь Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 6 зүйлтэй байна.

1 дүгээр зүйл: Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хэмжээг тогтооно;

2 дугаар зүйл: Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн 3, 5, 11, 12, 13 дугаар зүйлүүдийг өөрчлөн найруулсантай холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын орлого, зарлагын хэмжээ, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн Нэгдсэн санд төвлөрүүлэх орлогын хэмжээ, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг өөрчлөх;

3 дугаар зүйл: Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд тусгагдсан тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, 6 дугаар зүйлд тусгагдсан улсын төсвийн зарлагын хэмжээ, 7 дугаар зүйлд тусгагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ, 10 дугаар зүйлд тусгагдсан Шинээр гаргах болон дахин санхүүжүүлэх Засгийн газрын он дамжих үнэт цаасны хэмжээг тус тус өөрчлөх;

4 дүгээр зүйл: Хуулийн 14 дүгээр зүйлийн "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт" хавсралтад өөрчлөлт оруулах;

5 дугаар зүйл: Хуулийн 15 дугаар зүйлийн “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт” хавсралтад өөрчлөлт оруулах;

6 дугаар зүйл: Хууль дагаж мөрдөх хугацааг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Засгийн газрын бүтцийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт орох өөрчлөлтийг тусгаснаар төсвийн харилцаа, санхүүжилт, гүйцэтгэлийг саадгүй зохион байгуулах боломжтой болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох хуулийн талаархи санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хилийн боомтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Мөнгөн тусламжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай” УИХ-ын 2010 оны 54 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай, “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2011 оны 11 дүгээр тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслүүдийг тус тус боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... сарын ... ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Монгол улсын 2015 оны төсвийн тухай хуульд доор дурдсан зүйл нэмсүгэй.

1/8". Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хэмжээг 719,655.0 тэрбум төгрөгөөр баталсугай.

2 дугаар зүйл. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн 3, 5, 11, 12, 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/3 дугаар зүйл:

"3 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2015 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Үндэсний аюулгүй байдлын нарийн бичгийн дарга Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	20.0 20.0
2	Монгол Улсын Их Хурлын дарга Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	2,152.6 2,152.6
3	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	10.0 10.0
4	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,903.4 1,103.4 800.0
5	Монгол Улсын Ерөнхий аудитор Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4.1 4.1
6	Үндэсний статистикийн хорооны дарга Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	14.4 14.4
7	Монгол Улсын Ерөнхий сайд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан Төрийн өмчийн хороо Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	183,327.2 3,500.0 177,491.1 2,336.1
8	Монгол Улсын Шадар сайд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	11,674.1 1,008.0

	Оюуны өмчийн газар	850.0
	Стандартчилал, хэмжил зүйн газар	2,100.0
	Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар	1,260.0
	Хилийн мэргэжлийн хяналтын алба	500.0
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	1,065.6
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4,890.4
9	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	390.3
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	390.3
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0
10	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд	13,075.9
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	12,832.6
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	243.3
11	Гадаад хэргийн сайд	11,153.8
	Дипломат төлөөлөгчийн газрууд	4,708.8
	Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар улсын төсөвт үйлдвэрийн газар	4,050.0
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	35.0
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2,360.0
12	Сангийн сайд	3,196,418.0
	Татварын ерөнхий газар	1,336,517.6
	үүнээс: Төсвийн тогтворжуулалтын сан	29,858.5
	Гаалийн ерөнхий газар	1,635,400.1
	Сангийн яам	152,689.7
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	59,732.5
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	6,893.0
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	5,185.2
13	Хууль зүйн сайд	55,539.7
	Улсын бүртгэлийн ерөнхий газар	14,000.0
	Цагдаагийн ерөнхий газар	2,875.0
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	22,177.1
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	962.3
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	15,525.3
14	Батлан хамгаалахын сайд	42,988.1
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	4,960.4
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	38,027.8
15	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	4,024.9
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4,024.9
16	Зам тээврийн сайд	108,187.0
	Иргэний нисэхийн ерөнхий газар	88,478.4
	"Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компани	904.0

	Монгол Улсын далайн захиргаа	100.0
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	7,741.8
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	10,962.8
17	Барилга, хот байгуулалтын сайд	9,819.9
	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	2,550.0
	Барилга хот байгуулалтын яам	1,200.0
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	6,069.9
18	Эрчим хүчний сайд	9,938.9
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	9,938.9
19	Уул уурхайн сайд	334,934.9
	Ашигт малтмалын газар	47,011.3
	Газрын тосны газар	286,509.0
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,414.6
20	Хүнс, хөдөө аж ахуйн сайд	57,258.2
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	24,000.0
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	7,754.4
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	25,503.7
21	Хөдөлмөрийн сайд	82,012.5
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	82,012.5
22	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	4,115.7
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	576.8
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	3,538.9
23	Эрүүл мэнд, спортын сайд	161,618.2
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	142,107.9
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	1,623.9
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	17,886.5
24	Аж үйлдвэрийн сайд	63,959.7
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	52,000.0
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	11,959.7

2/5 дугаар зүйл:

5 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2015 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарт доор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Урсгал зардал	7,203.4 7,203.4
2	Монгол Улсын Их Хурлын дарга Урсгал зардал	27,327.9 25,175.3

	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	2,152.6
3	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Урсгал зардал	722.2 722.2
4	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Урсгал зардал	3,902.7 3,902.7
5	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Урсгал зардал	54,779.9 54,779.9
6	Хүний эрхийн үндэсний комиссын дарга Урсгал зардал	849.5 849.5
7	Улсын ерөнхий прокурор Урсгал зардал Хөрөнгийн зардал	19,285.1 17,445.0 1,840.1
8	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Урсгал зардал	2,531.6 2,531.6
9	Монгол Улсын Ерөнхий аудитор Урсгал зардал	10,022.5 10,022.5
10	Авлигатай тэмцэх газрын дарга Урсгал зардал	9,927.7 9,927.7
11	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Урсгал зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	3,654.2 2,550.8 1,103.4
12	Төрийн албаны зөвлөлийн дарга Урсгал зардал	630.7 630.7
13	Үндэсний статистикийн хорооны дарга Урсгал зардал	8,224.3 8,224.3
14	Сонгуулийн ерөнхий хорооны дарга Урсгал зардал	950.2 950.2
15	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Урсгал зардал	683.4 683.4
16	Монгол Улсын Ерөнхий Сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	74,865.1 68,762.9 1,133.2 4,969.0
17	Монгол Улсын Шадар сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	110,690.7 88,481.8 17,668.9 4,540.0
18	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	16,995.8 11,740.1 4,037.0 1,218.8
19	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	80,285.8 59,883.7 6,989.5 13,412.6
20	Гадаад хэргийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	54,022.1 50,437.1 3,550.0

	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	35.0
21	Сангийн сайд Урсгал зардал Дотоод эх үүсвэрээс олгох зээл Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөрт Засгийн газрын гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт Засгийн газрын дотоод зээлийн үндсэн төлбөрт	3,069,624.9 1,041,208.6 63,471.8 61,935.3 28,736.6 1,727,548.8 141,400.6 5,323.3
22	Хууль зүйн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	394,645.2 366,502.9 28,142.3
23	Зам тээврийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	214,153.7 10,072.7 75,779.2 128,301.8
24	Батлан хамгаалахын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	197,533.5 184,955.2 5,037.1 7,541.2
25	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Урсгал зардал Үүнээс: Сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг Соёлын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг Дотоод эх үүсвэрээс олгох зээл Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	1,102,275.1 966,288.0 246,795.3 522,666.7 42,335.6 20,837.2 105,603.9 9,546.0
26	Уул уурхайн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	18,350.8 8,957.2 9,393.6
27	Хүнс, хөдөө аж ахуйн сайд Урсгал зардал Дотоод эх үүсвэрээс олгох зээл Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	140,320.3 93,073.6 2,100.0 18,877.9 26,268.8
28	Хөдөлмөрийн сайд Урсгал зардал Дотоод эх үүсвэрээс олгох зээл Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	159,614.8 140,687.8 13,000.0 5,347.0 580.0
29	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд Урсгал зардал Үүнээс: Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	370,905.4 361,173.5 6,554.1

	Хөрөнгийн зардал	7,312.3
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	2,419.6
30	Эрүүл мэнд, спортын сайд	624,080.9
	Урсгал зардал	508,257.1
	Үүнээс: Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	101,970.6
	Нийтийн биеийн тамирын тусгай зориулалтын шилжүүлэг	10,257.8
	Хөрөнгийн зардал	52,184.7
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	63,639.2
31	Эрчим хүчний сайд	57,687.7
	Урсгал зардал	25,242.0
	Хөрөнгийн зардал	16,543.4
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	15,902.4
32	Аж үйлдвэрийн сайд	18,114.9
	Урсгал зардал	5,013.4
	Хөрөнгийн зардал	2,101.5
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	11,000.0
33	Барилга, хот байгуулалтын сайд	69,720.0
	Урсгал зардал	12,373.5
	Үүнээс: Газрын харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг	7,014.7
	Хөрөнгийн зардал	32,651.3
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	24,695.3

3/11 дүгээр зүйл:

11 дүгээр зүйл. Монгол Улсын 2015 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	13,181.0
2	Баян-Өлгий	13,404.6
3	Баянхонгор	13,388.5
4	Булган	659.3
5	Говь-Алтай	10,036.1
6	Дорнод	6,181.7
7	Дундговь	8,048.3
8	Завхан	11,865.2
9	Өвөрхангай	14,879.1
10	Сүхбаатар	7,084.5
11	Сэлэнгэ	5,508.4
12	Төв	9,821.7
13	Увс	12,397.1
14	Ховд	9,270.4
15	Хөвсгөл	18,548.7
16	Хэнтий	10,364.8
17	Дархан-Уул	1,274.2
18	Говь-Сүмбэр	369.5

Нийт дүн	166,283.0
-----------------	------------------

4/12 дугаар зүйл:

"12 дугаар зүйл: 2015 оны төсвийн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Өмнөговь	18,514.2
2	Орхон	3,035.7
Нийт дүн		21,549.8

5/13 дугаар зүйл:

"13 дугаар зүйл: 2015 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг доор дурдсанаар тус тус баталсугай:

д/д	Аймаг	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	5,042.7
2	Баян-Өлгий	4,582.9
3	Баянхонгор	5,910.8
4	Булган	4,332.9
5	Говь-Алтай	5,725.9
6	Дорноговь	4,749.5
7	Дорнод	5,166.3
8	Дундговь	4,575.1
9	Завхан	4,834.6
10	Өвөрхангай	5,550.4
11	Өмнөговь	5,641.8
12	Сүхбаатар	4,849.8
13	Сэлэнгэ	4,444.7
14	Төв	4,588.4
15	Увс	4,687.0
16	Ховд	5,228.3
17	Хөвсгөл	5,486.1
18	Хэнтий	4,939.6
19	Дархан-Уул	4,236.4
20	Улаанбаатар	24,555.4
21	Орхон	4,571.6
22	Говь-Сүмбэр	3,304.1
Нийт дүн		127,004.3

3 дугаар зүйл. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "4,708,510.1" гэснийг " 4,079,396.3 " гэж, 6 дугаар зүйлийн "5,603,277.4" гэснийг " 5,612,054.6" гэж, 7 дугаар зүйлийн "655,417.5" гэснийг " 342,546.0" гэж, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "1,815,740.1" гэснийг " 2,100,000.0" гэж тус тус өөрчилсүгэй.

БУСАД ЗҮЙЛ

4 дүгээр зүйл. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт"-ийг 1 дүгээр хавсралтаар өөрчлөн баталсугай.

5 дугаар зүйл: Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг 2 дугаар хавсралтаар өөрчлөн баталсугай.

6 дугаар зүйл: Энэ хуулийг 2015 оны ... дугаар сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2015 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ
ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЧАНАРЫН БОЛОН ТОО
ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2015 оны зорилтот түвшин
1	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА		
1.1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа		
	1.1.1	Эрх зүй, аюулгүй байдал, төр болон улс төрийн салбарт тулгамдаж байгаа шинэтгэлийн бодлогыг үргэлжлүүлэх	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх
	1.1.2	Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах эрхийг хангасан эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх
	1.1.3	Монгол Улсын аюулгүй, тусгаар, бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, санал санаачлагыг дэмжих	тухай бүрд дэмжиж ажиллах
2	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА		
2.1	Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих		
	2.1.1	Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлыг хэлэлцүүлэх хувь	85.0
	2.1.2	Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцсэн асуудлыг шийдвэрлэх хувь	100.0
	2.1.3	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан, мэдээллийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх тоо	4-өөс доошгүй удаа
	2.1.4	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн болон Улсын Их Хуралд үйл ажиллагаагаа тайлагнадаг байгууллагын тайланг Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх	байгууллага тус бүр 1-ээс доошгүй удаа
	2.1.5	Техник хэрэгсэл, хуралдааны танхим болон ажлын өрөө, бусад ажиллах нөхцөл хангагдсан байх	хуульд заасны дагуу хангагдсан байх
3	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА		
3.1	Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих		
	3.1.1	Өргөдөл, мэдээлэл, гомдол, хүсэлтийн барагдуулалт /хувиар/	85.0
	3.1.2	Бага суудлын хуралдаанаар шийдвэрлэсэн өргөдлийн барагдуулалт /хувиар/	85.0
	3.1.3	Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн дунд, их суудлын хуралдаанаар шийдвэрлэсэн өргөдлийн барагдуулалт /хувиар/	85.0
4	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ		
4.1	Хяналтын шатны шүүн таслах ажиллагаа		
	4.1.1	Хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд шийдвэрлэх эрүүгийн хэргийн тоо	642
	4.1.2	Хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд шийдвэрлэх иргэний хэргийн тоо	910

		4.1.3	Хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд шийдвэрлэх захиргааны хэргийн тоо	294
5	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА			
	5.1	Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах		
	5.1.1	Хуулийн хугацаанд шийдвэрлэх хэргийн хувь		93.0
6	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА			
	6.1	Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих		
	6.1.1	Хүний эрхийн асуудлаарх судалгаа, мониторинг, хяналт шалгалт хийх		15
	6.1.2	Хууль тогтоомжийн дүн шинжилгээ, санал гаргах		20
	6.1.3	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх өргөдөл, гомдол шийдвэрлэх		700
	6.1.4	Иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх асуудлаар шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах, шаардлага хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл бий болсон шалтгаан нөхцөлийг арилгуулах асуудлаар зөвлөмж хүргүүлэх		34
	6.1.5	Хүний эрхийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа		45
7	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР			
	7.1	Прокурорын хяналт		
	7.1.1	Хэрэг бүртгэлийн ажиллагаанд тавих хяналт /хувиар/		100.0
	7.1.2	Ялтны хувийн хэрэгт хийх шалгалтын тоо		800
	7.1.3	Хорих анги, цагдан хорих байрны үйл ажиллагаатай биечлэн танилцах /тоогоор/		6015
8	ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА			
	8.1	Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах		
	8.1.1	Бодлогын зөвлөмжийн тоо		75
	8.1.2	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тоо		87
9	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР			
	9.1	Төрийн аудитын үйлчилгээ		
	9.1.1	Санхүүгийн аудит хийх байгууллагын тоо /мянгаар/		4.4
	9.1.2	Гүйцэтгэлийн аудит хийх байгууллагын тоо		10
	9.1.3	Нийцлийн аудит хийх тоо		14
10	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА			
	10.1	Авлигатай тэмцэх		
	10.1.1	Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтаар хянагдсан хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн тоо		5200
	10.1.2	Авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгааны тоо		30
	10.1.3	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тухай сургалтад хамрагдах хүний тоо /мянган хүн/		50.0
	10.1.4	Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа		1
	10.1.5	Хүүхдийн шударга байдлын судалгаа		1
	10.1.6	Авлигын индексийг тодорхойлох судалгааны тоо		1
	10.1.7	Байгууллага, иргэдийн гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх хувь		95.0
11	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА			
	11.1	Санхүүгийн зах зээлийн зохицуулалт		
	11.1.1	Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох /шинээр боловсруулах хууль, журмын төсөл/		1 хууль 10 журам
	11.1.2	Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарт эрсдэлд суурилсан		93

		хяналт, шалгалт хийх /хамрагдах аж ахуйн нэгж байгууллагын тоо/	
	11.1.3	Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах /хөтөлбөрийн тоо/	1
12	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА		
	12.1	Төрийн албаны ерөнхий удирдлага, зохицуулалт	
	12.1.1	Салбар зөвлөл тус бүрийг мэдээлэл, хяналт-шинжилгээ үнэлгээний бодлого, хүний нөөцийн хөгжлийн бодлого, стандартын удирдлагаар хангах	3-аас доошгүй удаа
	12.1.2	Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалт зохион байгуулах	50 удаа
13	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА		
	13.1	Албан ёсны статистикийг хөгжүүлэх	
	13.1.1	Албан ёсоор гаргах статистикийн мэдээ, тайлангийн нэр төрөл	290
	13.1.2	Албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн тоо /мянгаар/	112.1
	13.1.3	Албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн тархаалт	45
	13.1.4	Шинээр болон шинэчлэн сайжруулсан аргачлал, ангилал, статистикийн мэдээллийн санд суурилсан эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтээр хийх судалгааны тоо	20
	13.1.5	Хүн ам, орон сууцын завсрын тооллогыг 21 аймгийн хүн амд хийх	Үр дүнг тархаасан байх
	13.1.6	Статистикийн тухай хуулийн дагуу хийвэл зохих улсын хэмжээний статистик судалгааны тоо	21
14	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА		
	14.1	Бүх шатны сонгууль зохион байгуулах	
	14.1.1	Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой боловсруулах журам, заавар, маягт	журам, заавар 40
	14.1.2	Сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах сургалт, семинарын тоо	2
	14.1.3	Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх /өмнөх оны суурь үзүүлэлтээс өсөх хувь/	2
	14.1.4	Тойрог болон нутаг дэвсгэрийн хорооны үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтын тоо	10
	14.1.5	Сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн ашиглах, хэвийн үйл ажиллагаа, санал хураах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах /төхөөрөмжийн тоо/	5000
	14.1.6	Програм хангамжийн аюулгүй ажиллагааг хангах	бүрэн хамгаалагдсан байх
15	ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА		
	15.1	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах үйл ажиллагаа	
	15.1.1	Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгал “Цагаан ном”-ын цуврал боть	боть 4
	15.1.2	Тагнуулын ерөнхий газарт шалгагдаж буй 6000 гаруй эрүүгийн хавтаст хэргээс нягтлан шалгах хавтаст хэргийн тоо	3000
	15.1.3	Өөрөө хэлмэгдсэн болон хэлмэгдэгчийн эхнэр /нөхөр/-т орон сууцын дэмжлэг үзүүлэх	15
	15.1.4	Улс төрийн хэлмэгдэгчийн намтрын товчоо, баримт бичгийн товчоон цуврал ном гаргах	3
	15.1.5	Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах	2
16	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД		
	16.1	Харилцаа холбооны зохицуулалт	
	16.1.1	Телевизийн нэвтрүүлгийн цацалтын чанарыг сайжруулах /өмнөх оны дундажтай харьцуулсан хувь/	12.0
	16.1.2	Мэдээлэл шифрлэж дамжуулах төрийн байгууллагын тоо	45

	16.1.3	Төрийн байгууллагад олгосон цахим хуудас байршуулах үйлчилгээний тоо	900
	16.1.4	Төрийн байгууллагад олгосон цахим нэрийн тоо	1250
	16.1.5	Цахим үйлчилгээний багтаамж /гига байт/	2400
	16.1.6	Төрийн мэдээллийн санд мэдээллээ төвлөрүүлэн, шилжүүлэх байгууллагын тоо	15
	16.1.7	Төрийн мэдээллийн санг ашигласан байгууллагын тоо	15
	16.1.8	Шинээр үүрэн холбооны үйлчилгээг хүргэх багийн тоо	10
	16.1.9	Шуудангийн хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлэх сумын тоо	60
	16.1.10	Улсын болон олон улсын чанартай авто зам дагуу үүрэн холбооны дэд бүтэц байгуулах цэгийн тоо	3
	16.1.11	Харилцаа, холбооны чиглэлээр хийгдэх судалгааны тоо	1
	16.2	Төрийн тусгай хамгаалалт	
	16.2.1	Хамгаалуулагчийн санал, хүсэлтийг барагдуулах /хувь/	100.0
	16.2.2	Хамгаалуулагчийн аюулгүй байдал хангагдсан байх	хангагдсан байх
	16.2.3	Үйлчлүүлэгчийн санал, хүсэлтийг барагдуулах /хувь/	100.0
	16.2.4	Үйлчилгээний стандартыг хангах	MNS 4588:2008, MNS 4946:2005 стандартуудыг хангасан байх
	16.3	Эрчим хүч, уул уурхайн судалгаа, шинжилгээ	
	16.3.1	Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын нэгдсэн тайланг гаргах /Тайланд хамрагдах аж, ахуйн нэгж байгууллагын тоо/	250
	16.4	Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн эрчим хүч	
	16.4.1	Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн эрчим хүчний бодлогын үйл ажиллагаа	хэрэгжилтээр
	16.5	Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа	
	16.5.1	Дотоод үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /мянгаар/	233.4
	16.5.2	Гадаад үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /мянгаар/	199.4
	16.5.3	Хэвлэмэл бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх /хувиар/	3.0
	16.5.4	Хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх /хувиар/	5.0
17	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД		
	17.1	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаа	
	17.1.1	Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдлийн үнэлгээ хийх /гамшгийн тохиолдлын буурах хувиар/	10.0
	17.1.2	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах хяналт шалгалт /хүн өдөр/	28968
	17.1.3	Гамшгийн хор уршгийг арилгах аврах ажлын зориулалттай тусгай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах /хувиар/	60.0
	17.1.4	Цацраг идэвхт, химийн хорт бодисын болон тэсэрч дэлбэрэх бодисын аюулаас хамгаалах, хүн, мал, амьтны гоц халдварт, халдварт өвчин, ой хээрийн түймэртэй тэмцэх, объектын гал түймэртэй тэмцэх /хувиар/	90.0
	17.2	Мэргэжлийн хяналт	
	17.2.1	Хяналт шалгалтад хамрагдсан эрсдэлтэй объектын тоо /мянгаар/	20.0
	17.2.2	Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах /хувиар/	94.5
	17.2.3	Эрсдэлтэй объектын эрсдлийн түвшний өөрчлөлт /тоо мянгаар/	50.0
	17.2.4	Улсын байцаагчын гаргасан акт, шийдвэрийн биелэлт /хувиар/	100.0

	17.2.5	Лабораторийн шинжилгээний итгэмжлэгдсэн үзүүлэлт /тоогоор/	2210
17.3	Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчийн эрхийг хамгаалах		
	17.3.1	Хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт хийх тоо	1050
	17.3.2	Хууль, тогтоомжийн хүрээнд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах тоо	85
	17.3.3	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт /хувиар/	100.0
	17.3.4	Зах зээлийн өрсөлдөөний байдалд хийгдэх судалгааны ажил	35
17.4	Стандартчилал, хэмжил зүй		
	17.4.1	Шалгалт тохируулга /калибровка/-д хамруулах хэмжих хэрэгслийн тоо /мянган нэгж/	4500.0
	17.4.2	Загварын туршилтад хамруулан улсын бүртгэлд бүртгэх хэмжих хэрэгслийн тоо	25
	17.4.3	Ээлжит баталгаажуулалтад заавал хамруулах хэмжих хэрэгслийн тоо /мянган нэгж/	220.0
	17.4.4	Чанарын удирдлагын тогтолцооны баталгаажуулалтад хамруулах байгууллага, аж ахуйн нэгжийн тоо	25
	17.4.5	Итгэмжлэлд хамруулах сорилтын лабораторийн тоо	142
	17.4.6	Ур чадварын сорилтод хамруулах лабораторийн тоо	80
	17.4.7	Үндэсний стандартад олон улс, бүс нутгийн дэвшилтэт стандартын эзлэх хувь	43.0
17.5	Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт		
	17.5.1	Оюуны өмчийн бүтээлийн сан бүрдүүлэлт /аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрх, түүнд хамаарах эрх, оюуны өмчийн гэрээ хэлэлцээрийн баталгаажилт/	3376
	17.5.2	Оюуны өмчийн мэдээлэл, сургалт хийх, лавлагаа гаргах	1060
	17.5.3	Оюуны өмчийн зөрчилд хяналт тавьж шийдвэрлэх	260
17.6	Худалдан авах ажиллагаа		
	17.6.1	Мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах худалдан авалт /төсөл, арга хэмжээ/-ын тоо	129
	17.6.2	Зохион байгуулах нийт худалдан авалтад цахим хэлбэрээр явуулах худалдан авалтын эзлэх хувь	80.0
	17.6.3	Иргэн, аж ахуйн нэгжид цахим худалдан авах ажиллагааны талаар цахим болон танхимын сургалт явуулах	92
18	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА		
18.1	Гүйцэтгэх засаглалын удирдлага, түүний ажлын алба		
	18.1.1	Засгийн газрын бодлого, шийдвэрийг боловсруулах, хуралдаанд бэлтгэх болон яам, Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх	хууль тогтоомжид нийцсэн байх
X.1.1.2	Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 62.2 км хатуу хучилттай авто зам /Дорноговь/	2007	2015	3,592.8	400.0
X.1.1.3	Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Өргөн сум хүртэлх 18.25 км хатуу хучилттай авто зам /Дорноговь/	2007	2016	2,301.2	750.0

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
Х.1.1.4	Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам төсөл"-ийн 110.8 км хатуу хучилттай авто зам /Ховд/	2008	2016	26,460.0	7,424.4
Х.1.1.5	Германы сэргээн босголт банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Нийслэл хотын хүнсний найдвартай байдлыг хангах орон нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл"-ийн 78.8 км хатуу хучилттай авто зам /Төв, Борнуур, Жаргалант, Партизан, Батсүмбэр сумд/	2010	2016	14,772.1	1,269.6
Х.1.1.6	Кувейтийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх Уньт-Тариалан чиглэлийн 88 км хатуу хучилттай авто зам /Булган/	2010	2016	20,526.2	2,899.6
Х.1.1.7	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам төсөл"-ийн 103.3 км хатуу хучилттай авто зам /Ховд/	2012	2016	31,460.0	6,000.0
Х.1.1.8	Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл" /Дорноговь/	2011	2016	16,335.0	2,807.5
Х.1.1.9	Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 131.2 км хатуу хучилттай авто зам /Дорноговь/	2006	2015	3,609.0	363.5
Х.1.1.10	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Баруун бүсийн авто замыг хөгжүүлэх төсөл". Манхан-Ховдын 85.3 км, Өлгий-Хашаатын даваа 60 км /Ховд, Баян-Өлгий/	2010	2016	12,477.2	894.4
Х.1.1.11	Мянгадын гүүрээс Сархайран чиглэлд барих 20 км хатуу хучилттай авто замын ажил /Ховд/	2012	2016	8,388.7	3,194.4
Х.1.1.12	Элсэн тасархай-Арвайхээр чиглэлийн 40 км замын хэсэгчилсэн шинэчлэл /Өвөрхангай/	2012	2016	13,272.6	2,391.2
Х.1.1.13	Сумын доторх хатуу хучилттай авто зам, 3 км /Завхан, Тосонцэнгэл сум/	2014	2016	1,782.0	391.0
Х.1.1.14	Сумын доторх хатуу хучилттай авто зам, 3 км /Ховд, Зэрэг сум/	2014	2016	1,785.0	279.2
Х.1.1.15	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5 км /Ховд, Жаргалант сум/	2014	2016	2,900.0	725.0
Х.1.1.16	1.5 км авто замын шинэчлэлийн ажлын дуусгал /Төв, Зуунмод сум, Баянхошуу баг/	2013	2015	311.3	244.2
Х.1.1.17	Аймгийн төвийн 2 км авто зам /Баянхонгор/	2012	2015	910.3	228.0
Х.1.1.18	Хэрлэн голын төмөр бетон гүүр /Хэнтий, Баянмөнх сум/	2011	2016	3,800.0	1,000.0
Х.1.1.19	Хэрлэн голын төмөр бетон гүүр /Дорнод, Хөлөнбуйр сум/	2012	2016	5,089.5	1,290.8

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
X.1.1.20	Тэсийн голын 127 у/м төмөр бетон гүүр /Увс, Тэс сум/	2012	2016	3,000.0	2,498.7
X.1.1.21	Хүдэрийн голын төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Хүдэр сум/	2012	2016	2,989.3	1,955.0
X.1.1.22	Идэрийн голын 169.08 у/м төмөр бетон гүүр /Завхан, Их -Уул сум/	2011	2015	2,089.5	380.0
X.1.1.23	Шивэрийн голын модон гүүр /Увс, Ховд сум/	2012	2016	1,200.0	600.0
X.1.2	2. Их засвар			25,000.0	25,000.0
X.1.2.1	Улсын чанартай авто зам, гүүрний засвар, арчлалт, шинэчлэлт	2015	2015	25,000.0	25,000.0
X.2	Тээвэр			27,001.2	2,292.7
X.2.1	I.Хөрөнгө оруулалт			27,001.2	2,292.7
	<i>Шилжих</i>			<i>27,001.2</i>	<i>2,292.7</i>
X.2.1.1	MASCOM-VSAT сансрын холбооны төв станц болон 11 алсын станцын хамт IDU төхөөрөмжүүдийг нийлүүлж суурилуулах 11 ком /Баян-Өлгий, Ховд, Ховдын Булган, Завхан Доной, Хөвсгөл Хатгал, Баянхонгор, Хархорин, Мандалговь, Даланзадгад, Хатгал, Баруун-Туруун, Улаанбаатар/	2013	2015	1,200.0	284.5
X.2.1.2	Зай хэмжих төхөөрөмж (DME) нийлүүлж суурилуулах /10 ком/	2013	2015	2,000.0	398.9
X.2.1.3	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Говь-Алтай/	2008	2016	7,385.3	492.1
X.2.1.4	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Завхан/	2008	2015	8,651.5	344.9
X.2.1.5	Бүсийн нислэг хөдөлгөөний удирдлагын төвийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа/	2011	2016	6,759.5	321.5
X.2.1.6	Бүсийн нислэг хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын дэд өртөө, гадна цахилгаан холбооны ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа/	2012	2015	1,004.9	450.7
XI	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД			208,108.3	32,651.3
XI.1	I.Хөрөнгө оруулалт			208,108.3	32,651.3
	<i>Шилжих</i>			<i>208,108.3</i>	<i>32,651.3</i>
XI.1.1	Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Өмнөговь, Дорноговь аймгуудын хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжил" төсөл /монголын талын хөрөнгө/	2010	2016	12,803.0	3,674.0
XI.1.2	Улаанбаатар хотын бүсчлэлийн төлөвлөлт, инженер-геологийн судалгаа, газар хөдлөлийн мужлалын болон газар дээрх болон доорх зураглал хийж, мэдээллийн сан үүсгэх /Улаанбаатар/	2012	2016	9,100.0	1,875.0

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
XI.1.3	Аймаг, сум, суурингийн нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил /Архангай, Баян-Өлгий, Увс, Дорнод, Дорноговь, Сүхбаатар, Хэнтий, Өвөрхангай, Говь-Алтай, Орхон, Дархан, Баянхонгор/	2012	2016	3,000.0	500.0
XI.1.4	Барилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл судлалын сорил шинжилгээний төв лабораторийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2011	2016	3,458.6	699.7
XI.1.5	Япон Улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх Улаанбаатар хотын ус хангамжийг сайжруулах төсөл /монголын талын хөрөнгө/ /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Гачуурт тосгон/	2013	2016	5,063.0	1,111.5
XI.1.6	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Орон сууцны хороолол" төсөл /монголын талын хөрөнгө/ /Улаанбаатар/	2010	2016	25,326.8	301.3
XI.1.7	Франц Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төсөл /монголын талын хөрөнгө/ /Орхон, Баян-Өндөр сум/	2013	2016	9,224.8	1,414.0
XI.1.8	Хаягийн мэдээллийн систем байгуулах /улсын хэмжээнд/	2013	2015	3,000.0	500.0
XI.1.9	Нийслэл, аймгийн төв, улсын чанартай авто замын дагуух Монгол Улсын иргэнд өмчлүүлэх боломжтой газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байр зүйн зураглал, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	2013	2016	5,000.0	1,438.8
XI.1.10	Орчны тохижилт /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2012	2015	500.0	125.0
XI.1.11	Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох /Архангай, Эрдэнэбулган сум/	2013	2016	3,970.0	399.0
XI.1.12	Газрын кадастрын мэдээллийн санг геодезийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх /улсын хэмжээнд/	2013	2016	9,000.0	1,293.5
XI.1.13	Хөтөл хотын доторх инженерийн шугам сүлжээ /Сэлэнгэ, Сайхан сум/	2013	2015	1,474.4	499.9
XI.1.14	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатны шинэчлэл, засварын цех /Улаанбаатар/	2013	2016	13,000.0	2,000.0
XI.1.15	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хөвсгөл, Мөрөн сум/	2013	2016	5,000.0	1,500.0
XI.1.16	Аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх /Баян-Өлгий/	2013	2016	801.0	286.3
XI.1.17	Цэвэр, бохир усны шугам /Дорноговь/	2012	2015	392.0	98.0

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
XI.1.18	Шинээр барилгын материалын лаборатори байгуулах /Ховд/	2013	2015	1,002.9	78.4
XI.1.19	Үйлчилгээний төвийн барилга /Сэлэнгэ, Түшиг сум/	2012	2015	250.0	63.0
XI.1.20	Үйлчилгээний төвийн барилга /Сэлэнгэ, Ерөө сум/	2012	2015	250.0	63.0
XI.1.21	Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа "Хот байгуулалтын салбар" төсөл /монголын талын хөрөнгө/ /Өвөрхангай, Дундговь, Төв, Булган, Говь-Алтай, Баянхонгор/	2008	2016	2,668.1	500.0
XI.1.22	Бүгд Найрамдах Чех Улсын хөрөнгө оруулалтаар эргэн төлөгдөх нөхцөлөөр хэрэгжүүлэх "Евро Эко Төгөл" төсөл /Орхон/	2013	2016	8,926.2	1,500.0
XI.1.23	Аймаг, нийслэлийн бүсийн тулгуур төвүүдэд барилгын материалын жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж барилгын материалын иж бүрэн лаборатори байгуулах /Хөвсгөл, Мөрөн сум/	2013	2015	652.9	180.0
XI.1.24	Аймаг, нийслэлийн бүсийн тулгуур төвүүдэд барилгын материалын жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж барилгын материалын иж бүрэн лаборатори байгуулах /Хэнтий, Хэрлэн сум/	2013	2015	625.0	170.0
XI.1.25	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, 100 ортой эмнэлэг /Дорноговь, Замын-Үүд сум/	2013	2015	4,056.0	385.2
XI.1.26	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургуулийн барилга, 960 суудал /Дорноговь, Замын-Үүд сум/	2013	2015	3,578.3	268.4
XI.1.27	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, соёлын төвийн барилга /Дорноговь, Замын-Үүд сум/	2013	2016	5,844.1	1,506.8
XI.1.28	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Өндөрхангай, Зүүнхангай, Давст, Тэс, Хяргас, Малчин, Өмнөговь, Өлгий, Баруунтуруун, Цагаанхайрхан сумд/	2014	2016	2,000.0	500.0
XI.1.29	Хотын зам, тохижилт, ногоон байгууламж /Өвөрхангай, Арвайхээр сум/	2014	2016	2,000.0	500.0
XI.1.30	Дэд бүтцийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2014	2016	5,629.0	1,414.5
XI.1.31	Нэгдсэн цэвэрлэх байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/	2014	2016	8,000.0	1,750.0
XI.1.32	Бохир усны шугамын шинэчлэл, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэл /Хөвсгөл, Мөрөн сум/	2011	2016	1,937.8	468.9
XI.1.33	Баянцагаан сумын халуун усны барилга, төвийн гал командын урдах бохир усны шугам /Баянхонгор, Гурванбулаг сумын усан сан/	2012	2015	496.0	199.1
XI.1.34	Талын хашааны цэвэр, бохир усны шугам, сүлжээний өргөтгөл, их засвар /Ховд, Жаргалант сум/	2012	2015	1,500.0	412.0

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
XI.1.35	Төв талбайн шинэчлэл /Ховд, Жаргалант сум/	2012	2016	1,219.9	347.4
XI.1.36	Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2013	2016	5,000.0	450.0
XI.1.37	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол хийх /улсын хэмжээнд/	2012	2015	650.0	163.0
XI.1.38	Шинээр тавихаар төлөвлөж байгаа төмөр замын дагуу GPS-ийн сүлжээ байгуулах, 1:25000 масштабтай байр зүйн зураглал хийх /11 аймагт/	2011	2016	14,140.2	1,500.0
XI.1.39	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх /Баянхонгор, Баянлиг, Бууцагаан сум/	2013	2016	20,000.0	765.6
XI.1.40	Барилгын лабораторийн барилга, байгууламж /Дорнод, Төв/	2014	2016	7,568.3	1,750.0
XII	УУЛ УУРХАЙН САЙД			1,705.0	852.5
XII.1	I. Хөрөнгө оруулалт			1,705.0	852.5
	<i>Шинэ</i>			<i>1,705.0</i>	<i>852.5</i>
XII.1.1	Замын-Үүд дэх шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн автоматжуулалт /Дорноговь, Замын-Үүд сум/	2015	2016	1,705.0	852.5
XIII	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД			155,257.3	16,543.4
XIII.1	I.Хөрөнгө оруулалт			155,257.3	16,543.4
	Цахилгаан дамжуулах шугам, дэд станц			35,071.1	9,757.2
	<i>Шилжих</i>			<i>35,071.1</i>	<i>9,757.2</i>
XIII.1.1	Төвийн бүсийн эрчим хүчний системийн тоолуурын нэгдсэн системийн өргөтгөл /Улаанбаатар/	2013	2016	1,598.3	280.0
XIII.1.2	Тамсаг-Халх голын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорнод/	2014	2016	4,450.0	895.7
XIII.1.3	Умард дэд станцаас кабель шугам татаж 6 дугаар бичил хороололд шинээр 10 кВ-ын хуваарилах байгууламж барих /Улаанбаатар/	2014	2016	2,420.4	710.2
XIII.1.4	1 дүгээр хорооллын ХТП5-ын дэргэд 10 кВ-ын хуваарилах байгууламж шинээр барих /Улаанбаатар/	2014	2015	921.1	405.6
XIII.1.5	Амгалан дэд станцаас кабель шугам татаж ХТП208-ын дэргэд шинээр 10 кВ-ын хуваарилах байгууламж барих /Улаанбаатар/	2014	2015	908.6	408.6
XIII.1.6	35/6 кВ-ын Баянхошуу 2х10 МВА чадалтай шинэ дэд станц барьж, 35 кВ-ын 7.2 км 2 хэлхээ ЦДАШ татах /Улаанбаатар/	2014	2016	2,021.1	610.6
XIII.1.7	35/10 кВ-ын Дашчойнхор 2х6.3 МВА чадалтай шинэ дэд станц барих /Улаанбаатар/	2014	2016	1,816.5	459.8
XIII.1.8	Улаанбаатар хотын төвийн 6, 10 кВ-ын кабель шугамын шинэчлэлт /Улаанбаатар/	2014	2016	6,000.0	1,874.6

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
XIII.1.9	Үйлдвэрийн районы 35 кВ-ын 35/6 кВ-ын 2х6300 кВА дэд станц, 35кВ-ын хуурай салгуурын пунктын өргөтгөл /Дархан-Уул/	2014	2016	3,997.8	998.9
XIII.1.10	Хөтөл хорооны 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 6/0.4 кВ-ын дэд станц, 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татах /Дархан-Уул, Дархан сум, Хөтөл хороо/	2014	2016	1,499.8	338.7
XIII.1.11	Байдлаг дэд станцыг 35/10кВ-ын дэд станц болгон өргөтгөх, 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татах /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2014	2016	1,499.7	350.0
XIII.1.12	Айраг-Даланжаргалан 35 кВ-ын 25.2 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорноговь, Даланжаргалан сум/	2014	2015	1,200.0	510.0
XIII.1.13	Төв аймгийн шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах /Төв/	2014	2016	3,940.0	1,061.5
XIII.1.14	35 кВ-ын 25 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Баян-Өлгий Сагсай, Улаанхус сумд/	2014	2016	1,889.7	444.9
XIII.1.15	10/0.4 кВ-ын 24.3 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорноговь, Эрдэнэ сум, "Бүрдэнэбулаг" бөөрний сувилал/	2014	2015	908.0	408.0
	Дулааны цахилгаан станц, дулааны шугам			120,186.2	6,786.2
	<i>Шилжих</i>			<i>120,186.2</i>	<i>6,786.2</i>
XIII.1.16	Сумдын төвлөрсөн дулаан хангамж /улсын хэмжээнд/	2014	2016	84,000.0	1,500.0
XIII.1.17	Дулааны станцын КВТС-10/150 зуух барих /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2013	2016	2,981.0	453.3
XIII.1.18	Дулааны станцын дулаан хангамжийн нэгдсэн системийг үл хамаарах схемд шилжүүлэх, үндсэн магистрал шугам сүлжээг шинэчлэх /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2013	2016	3,538.3	773.8
XIII.1.19	Төвлөрсөн дулаан хангамжийн шугамын шинэчлэл /Хөвсгөл, Мөрөн сум/	2013	2016	15,253.9	362.6
XIII.1.20	5В магистраль Тк-1893-с Континенталь зочид буудлын баруун талын уулзвар хүртэлх 2100 метр 2х500 мм-ийн шугамыг 2х800 мм болгон өргөтгөх /Улаанбаатар/	2014	2016	5,385.5	1,432.7
XIII.1.21	1в магистралын Тк-1893-с Тк-117 цэг хүртэлх 1500 метр 2х500 мм-ийн шугамыг 2х700 мм шугам болгон өргөтгөх /Улаанбаатар/	2014	2016	2,998.6	749.3
XIII.1.22	Багануурын дулааны станцын сүлжээний усны зарцуулалт хувьсах насосны горимд шилжих /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2014	2016	3,100.0	800.0
XIII.1.23	Дулааны цахилгаан станц 2-ын Р-4 /АК-6/ турбины шинэчлэлийн ажил /Улаанбаатар/	2014	2016	2,928.9	714.5
XIV	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД			21,847.1	3,477.9
XIV.1	I.Хөрөнгө оруулалт			20,847.1	2,971.9
	<i>Шилжих</i>			<i>20,847.1</i>	<i>2,971.9</i>

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
XIV.1.1	Малын удмын сангийн үндэсний цогцолбор /Дархан-Уул, Хонгор сум/	2012	2016	12,271.0	1,000.0
XIV.1.2	Буянт голын услалтын систем /Ховд/	2013	2015	2,224.8	371.3
XIV.1.3	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд/	2012	2016	5,000.0	1,250.0
XIV.1.4	Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2013	2016	1,351.3	350.6
XIV.5	V.Хөрөнгийн шилжүүлэг, дэмжлэг			1,000.0	506.0
	<i>Шилжих</i>			<i>1,000.0</i>	<i>506.0</i>
XIV.5.1	Хүнсний ногооны хүлэмжийн аж ахуй байгуулах	2012	2015	1,000.0	506.0
ХҮ	ХӨДӨЛМӨРИЙН САЙД			27,081.0	5,347.0
ХҮ.1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэл			27,081.0	5,347.0
ХҮ.1.1	I.Хөрөнгө оруулалт			27,081.0	5,347.0
	<i>Шилжих</i>			<i>27,081.0</i>	<i>5,347.0</i>
ХҮ.1.1.1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр, 120 ор /Дорноговь/	2013	2016	1,439.7	359.9
ХҮ.1.1.2	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Дорнод, Хэрлэн сум/	2013	2016	4,149.0	1,037.3
ХҮ.1.1.3	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр /Орхон/	2013	2016	2,247.2	561.8
ХҮ.1.1.4	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр, дадлагын байр, спорт заал, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум/	2012	2016	6,738.0	497.4
ХҮ.1.1.5	Хөдөө аж ахуйн их сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон/	2013	2016	2,162.0	540.5
ХҮ.1.1.6	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрын барилга, 200 ор /Дундговь, Сайнцагаан сум/	2012	2016	2,281.8	570.4
ХҮ.1.1.7	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн биеийн тамирын заалын барилга /Өмнөговь/	2013	2015	654.0	500.0
ХҮ.1.1.8	Политехникийн коллежийн хотхон /Дорнод, Хэрлэн сум/	2014	2016	2,000.0	500.0
ХҮ.1.1.9	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр, спорт заалын барилга, 320 суудал /Завхан, Тосонцэнгэл сум/	2014	2016	5,409.3	779.7
ХҮI	ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД			27,549.6	7,312.3
ХҮI.1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам			13,649.6	3,787.3
ХҮI.1.1	I.Хөрөнгө оруулалт			13,649.6	3,787.3
	<i>Шилжих</i>			<i>13,649.6</i>	<i>3,787.3</i>
ХҮI.1.1.1	Батсүмбэрийн Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн нөхөн сэргээх сувиллын барилга /Төв, Батсүмбэр сум/	2014	2016	5,591.1	1,500.0
ХҮI.1.1.2	Батсүмбэрийн Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн байрын өргөтгөл /Төв, Батсүмбэр сум/	2014	2016	3,398.5	849.6

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
ХҮI.1.1.3	Нийслэлийн нийгмийн даатгалын газар, нийслэлийн нийгмийн халамж, үйлчилгээний газрын барилга, тохижилт, тоног төхөөрөмжийн хамт /Нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрээс хамтран санхүүжүүлэх /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2014	2016	2,000.0	500.0
ХҮI.1.1.4	Ахмадын ордны барилга /Орхон, Баян-Өндөр сум/	2014	2015	750.0	350.0
ХҮI.1.1.5	Ахмадын болон амьдрах ухааны ордон /Завхан, Улиастай сум/	2014	2016	1,200.0	300.0
ХҮI.1.1.6	Ахмадын сувиллын газрын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2010	2015	710.0	287.7
ХҮI.2	Хүүхдийн төлөө үндэсний газар			13,900.0	3,525.0
ХҮI.2.1	I.Хөрөнгө оруулалт			13,900.0	3,525.0
	<i>Шилжих</i>			<i>13,900.0</i>	<i>3,525.0</i>
ХҮI.2.1.1	Усан спорт цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, Найрамдал зуслан/	2014	2016	9,600.0	2,050.0
ХҮI.2.1.2	Баянгол хүүхдийн зуслангийн цогцолбор /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2013	2016	4,300.0	1,475.0
ХҮII	ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД			224,823.0	52,184.7
ХҮII.1	Эрүүл мэнд			132,518.6	30,329.5
ХҮII.1.1	I.Хөрөнгө оруулалт			106,683.7	18,912.0
	<i>Шилжих</i>			<i>106,683.7</i>	<i>18,912.0</i>
ХҮII.1.1.1	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2016	20,000.0	3,375.0
ХҮII.1.1.2	Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн харьяа түлэнхийн төвийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2013	2017	26,000.0	2,757.2
ХҮII.1.1.3	Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2012	2016	12,450.9	2,113.2
ХҮII.1.1.4	Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2010	2016	5,597.4	1,554.3
ХҮII.1.1.5	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа "Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр-5"	2013	2018	4,613.1	500.0
ХҮII.1.1.6	Улсын клиникийн төв эмнэлгийн өргөтгөлийн Б блокын барилгын зураг, төслийн санхүүжилт /Улаанбаатар/	2012	2015	492.2	492.2
ХҮII.1.1.7	Бельгийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа "Баруун бүсийн эмчилгээ, оношилогооны төвийг сайжруулах" төсөл	2013	2017	8,700.0	500.0
ХҮII.1.1.8	Эрүүл мэндийг дэмжих төв /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2012	2016	1,379.1	390.4
ХҮII.1.1.9	Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн барилга /Улаанбаатар/	2013	2016	2,949.9	300.0
ХҮII.1.1.10	Эмнэлгийн барилга, 10 ор /Завхан, Асгат сум/	2013	2016	1,014.6	300.0
ХҮII.1.1.11	Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Баянхонгор, Шаргалжуут сум/	2014	2015	1,112.7	532.7
ХҮII.1.1.12	Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	2014	2015	1,112.7	512.7

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
ХҮИ.1.1.13	Эмнэлгийн барилга, 10 ор /Дундговь, Адаацаг сум/	2013	2015	861.1	500.0
ХҮИ.1.1.14	Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2013	2015	618.5	500.0
ХҮИ.1.1.15	Сувиллын барилга, тоног төхөөрөмжийн шинэчлэл /Дорноговь, Эрдэнэ сум, "Бүрдэнэбулаг" бөөрний сувилал/	2014	2015	1,000.0	467.4
ХҮИ.1.1.16	Эрүүл мэндийн төв /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/	2014	2016	1,315.8	382.9
ХҮИ.1.1.17	Төрөх эмнэлгийн барилга, 50 ор /Дорнод, Хэрлэн сум/	2012	2015	2,774.0	450.0
ХҮИ.1.1.18	Эрүүл мэндийг дэмжих төв /Архангай, Эрдэнэбулган сум/	2012	2015	895.1	384.0
ХҮИ.1.1.19	Хүн эмнэлгийн барилга, 20 ор /Архангай, Тариат сум/	2013	2015	1,174.7	16.5
ХҮИ.1.1.20	Эмнэлгийн барилга /Дорнод, Хэрлэн сум, 4 дүгээр баг/	2014	2015	705.0	355.0
ХҮИ.1.1.21	Эмнэлгийн барилга, 10 ор /Өвөрхангай, Бүрд сум/	2012	2015	798.0	350.2
ХҮИ.1.1.22	Төрөх эмнэлэг, 50 ор /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2011	2016	2,898.9	504.9
ХҮИ.1.1.23	Халдвартын эмнэлгийн барилга, 30 ор /Завхан, Улиастай сум/	2011	2015	1,759.3	313.3
ХҮИ.1.1.24	Эрүүл мэндийг дэмжих төв /Дундговь, Сайнцагаан сум/	2012	2015	759.2	307.8
ХҮИ.1.1.25	Өрхийн эмнэлгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, Энх-Алтай өрхийн эмнэлэг/	2014	2015	544.9	94.9
ХҮИ.1.1.26	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн халдвартын эмнэлгийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2014	2015	2,133.0	233.0
ХҮИ.1.1.27	Эмнэлгийн барилга, 15 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Хонхор тосгон/	2012	2015	773.2	196.0
ХҮИ.1.1.28	Эмнэлгийн барилга, 10 ор /Архангай, Өгийнуур сум/	2011	2015	399.2	62.8
ХҮИ.1.1.29	Уламжлалт анагаах ухааны эмнэлгийн барилга, 20 ор /Дорнод, Хэрлэн сум/	2011	2015	637.2	131.0
ХҮИ.1.1.30	Эмнэлгийн амбулаторийн барилга /Булган, Хутаг-Өндөр сум/	2012	2015	1,214.0	334.6
ХҮИ.1.2	II.Их засвар			7,334.1	3,667.0
	<i>Шинэ</i>			<i>7,334.1</i>	<i>3,667.0</i>
ХҮИ.1.2.1	Харьяа газрын засвар /улсын хэмжээнд/	2015	2016	2,966.7	1,483.3
ХҮИ.1.2.2	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын их засвар /Улаанбаатар/	2015	2016	846.2	423.1
ХҮИ.1.2.3	Аймаг, сумын эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагуудын их засвар /улсын хэмжээнд/	2015	2016	3,521.2	1,760.6
ХҮИ.1.3	III.Тоног төхөөрөмж			18,500.7	7,750.4
	<i>Шилжих</i>			<i>3,651.5</i>	<i>630.0</i>
ХҮИ.1.3.1	Аймгуудын эрүүл мэндийн газрын түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмж, засвар /Дархан-Уул, сумд; Сэлэнгэ, Баянгол сум/	2014	2016	1,000.0	350.0

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
ХҮИ.1.3.2	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ <i>Шинэ</i>	2014	2016	2,651.5	280.0
	Аймаг, нийслэл			14,849.2	7,120.4
ХҮИ.1.3.3	Аймгуудын Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	2015	2016	1,050.0	525.0
ХҮИ.1.3.4	Аймгуудын Зооноз өвчин судлалын төв, Уламжлалт анагаах ухааны төвийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	2015	2015	406.0	406.0
ХҮИ.1.3.5	Аймгуудын сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	2015	2016	1,045.3	522.6
ХҮИ.1.3.6	Нийслэл, дүүргүүдийн эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2015	2016	840.0	420.0
ХҮИ.1.3.7	Аймаг, дүүрэг, сум, өрхийн эмнэлгүүдийг телемедицины сүлжээнд холбох /улсын хэмжээнд/	2015	2015	350.0	350.0
ХҮИ.1.3.8	Аймаг, дүүргийн эмнэлгүүдийн эмчилгээний ор хэрэгсэл, шинэчлэл /улсын хэмжээнд/	2015	2016	1,050.0	525.0
	Харьяа байгууллага			10,107.9	4,371.8
ХҮИ.1.3.9	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2015	2016	700.0	350.0
ХҮИ.1.3.10	Геронтологийн үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2015	2015	31.4	31.4
ХҮИ.1.3.11	Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2015	2015	175.8	175.8
ХҮИ.1.3.12	Эмгэг судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2015	2016	609.6	304.8
ХҮИ.1.3.13	Зоонозын өвчин судлалын төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2015	2015	649.7	649.7
ХҮИ.1.3.14	Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2015	2016	1,050.0	525.0
ХҮИ.1.3.15	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2015	2016	700.0	350.0
ХҮИ.1.3.16	Эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашин /улсын хэмжээнд/	2015	2016	3,111.5	770.0
ХҮИ.1.3.17	Эмийн аюулгүй байдлын мэдээллийн системийг сайжруулах /улсын хэмжээнд/	2015	2016	980.0	490.0
ХҮИ.1.3.18	Зүрх судасны тусламж үйлчилгээний тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2015	2016	1,050.0	525.0
ХҮИ.1.3.19	Төв эмнэлгүүдийн эмчилгээний ор хэрэгсэл, багаж шинэчлэл /Улаанбаатар/	2015	2016	1,050.0	200.2
ХҮИ.2	Спорт			92,304.4	21,855.2
ХVII.2.1	I.Хөрөнгө оруулалт			92,304.4	21,855.2

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
	<i>Шилжих</i>			92,304.4	21,855.2
XVII.2.1.1	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2010	2016	9,019.9	1,804.9
XVII.2.1.2	Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2008	2016	3,368.0	540.0
XVII.2.1.3	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал/Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2010	2016	8,229.3	2,743.5
XVII.2.1.4	Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2010	2016	10,397.9	2,034.5
XVII.2.1.5	Спорт цогцолборын барилга /Завхан, Улиастай сум/	2012	2016	2,800.0	700.0
XVII.2.1.6	Спорт цогцолборын барилга, 700 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	2016	6,378.0	2,189.0
XVII.2.1.7	Спортын ордны барилга, 450 суудал /Өвөрхангай, Хархорин сум/	2014	2016	4,400.0	1,100.0
XVII.2.1.8	Усан бассейны барилга, 400 суудал /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2014	2016	3,955.0	977.5
XVII.2.1.9	Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул, Дархан сум/	2011	2016	21,443.0	2,000.0
XVII.2.1.10	Спорт цогцолборын барилга /Ховд, Манхан сум/	2012	2016	2,118.0	788.8
XVII.2.1.11	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2010	2016	7,377.4	1,844.3
XVII.2.1.12	Усан бассейны барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2012	2016	5,613.8	2,566.4
XVII.2.1.13	Спорт цогцолбор, 700 суудал /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2010	2015	1,602.6	402.6
XVII.2.1.14	Хүүхэд, залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах /Архангай, Эрдэнэбулган сум/	2013	2016	1,500.0	488.6
XVII.2.1.15	Спорт цогцолборын өргөтгөл, усан бассейн /Дорнод, Хэрлэн сум/	2011	2016	1,770.3	560.1
XVII.2.1.16	Спорт заалын барилга /Дорнод, Хэрлэн сум, 2 дугаар баг/	2012	2015	910.3	525.7
XVII.2.1.17	Спорт заалын барилга /Булган, Хангал сум, Хялганат тосгон/	2012	2016	1,420.9	589.3
XVIII	АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙД			10,931.4	2,101.5
XVIII.1.1	I.Хөрөнгө оруулалт			10,931.4	2,101.5
	<i>Шилжих</i>			<i>10,931.4</i>	<i>2,101.5</i>
XVIII.1.1.1	Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/	2012	2016	4,200.0	954.0
XVIII.1.1.2	Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2012	2016	3,000.0	375.0
XVIII.1.1.3	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв /Баянхонгор, Баянхонгор сум/	2011	2016	2,970.0	554.8
XVIII.1.1.4	Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/	2011	2015	761.4	217.7
XIX	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР			7,919.3	1,840.1
XIX.1	I.Хөрөнгө оруулалт			7,919.3	1,840.1
	<i>Шилжих</i>			<i>7,919.3</i>	<i>1,840.1</i>
XIX.1.1	Аймгийн прокурорын газрын конторын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	2013	2016	1,000.0	351.4
XIX.1.2	Улсын ерөнхий прокурорын газрын архивын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2012	2015	873.7	538.7

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
XIX.1.3	Сум дундын прокурорын конторын барилга /Өмнөговь, Ханбогд сум/	2013	2015	758.6	200.0
XIX.1.4	Улсын ерөнхий прокурорын газрын сургалтын төвийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/	2013	2016	5,287.0	750.0
НИЙТ				1,642,190.5	342,546.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН
2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХҮНИЙ ХӨГЖИЛ
САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот

1. ТӨСӨВТ ТОДОТГОЛ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

1.1. Төсөвт тодотгол хийх үндэслэл

Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас Монгол Улсын 2014 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 1.0 их наяд гаруй төгрөгөөр буурахаар байгаа бөгөөд ирэх 2015 онд ч эдийн засгийн нөхцөл байдал энэ оныхоос сайжрах төлөв байдал ажиглагдахгүй байгаа тул 2015 оны төсвийн орлогыг бодитойгоор тооцох, батлагдсан хэмжээг бууруулах зайлшгүй шаардлага бий болоод байна.

Иймд 2015 оны батлагдсан төсвийн орлогыг бодитойгоор дахин төлөвлөх, урсгал болон хөрөнгийн зардлыг орлоготойгоо уялдуулан дахин тооцож төсөвт тусгах зорилгоор 2015 оны төсвийн тодотголыг боловсрууллаа.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2014 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан.

Төсвийн тухай хуулийн 34.1.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх тохиолдолд тодотголын төслийг боловсруулна”, мөн хуулийн 6.2.3-т “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлнэ” гэж заасныг тус тус үндэслэн Засгийн газрын бүтцийн тухай хуулийн дагуу Монгол улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

1.2. Төсөвт тодотгол хийхэд баримталсан зарчим

Төсвийн орлогын 2015 оны батлагдсан төсөвт тодотгол хийхдээ дараах зарчим баримталлаа. Үүнд:

1. Монгол улсын 2015 оны эдийн засгийн төлөв байдал, төсвийн орлогын 2014 оны хүлээгдэж буй гүйцэтгэл зэрэгт үндэслэн 2015 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөх;
2. Орон нутгийн төсвийн орлогын бааз суурыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн орлогод төвлөрдөг зарим төрлийн татварын эрх зүйн орчныг бүрдүүлэх;

Төсвийн зарлагын төлөвлөгөөнд тодотгол хийхдээ дараах зарчим баримталлаа. Үүнд:

1. Төсвийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх, үр ашигтай, оновчтой бүтцийг бий болгох, хэмнэж тэвчих шаардлагатай зарим урсгал зардлыг бууруулан тооцох;
2. Засгийн газрын бүтэц УИХ-аар шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан зохих өөрчлөлтийг 2015 оны төсөвт тусгах;
3. Нийгмийн хамгааллын шинжтэй зарим хөтөлбөрүүдийг зорилтот бүлэгт чиглүүлэх;
4. Бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, чиг үүргийн давхардлыг арилгах чиглэлээр төсвөөс санхүүждэг зарим байгууллагууд, үндэсний хороо,

зөвлөлийн ажлын алба, Засгийн газрын тусгай сангуудыг өөрчлөн зохион байгуулах, нэгтгэх, татан буулгах;

5. Төсвөөс олгож буй зарим төрлийн татаас, урамшууллыг үр дүнтэй оновчтой байдлаар зохион байгуулах, хамрах хүрээг тодорхой болгох хэмжээг өөрчлөх;
6. Ирэх онд шинээр хэрэгжих зарим арга хэмжээг тэвчих, шаардлагатай бол хэрэгжилтийг хойшлуулах замаар урсгал зардлыг бууруулах.

Улсын төсвийн 2015 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийхдээ дараах зарчим баримталаа. Үүнд:

1. Ирэх 2015 онд шинээр тендер зарлан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, 75.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 52 төсөл арга хэмжээг төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулан төсөвт тусгахгүй тэвчих;
2. Төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулан 550.0 сая төгрөгөөс дээш санхүүжих дүн бүхий 252 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 50 хувиар бууруулж, нийт 267.7 тэрбум төгрөгийг 2016 оны төсөвт тусгахаар шилжүүлэх;
3. “Улсын чанартай авто замын засвар, арчлалт, шинэчлэлт” төсөл, арга хэмжээний хүрээнд хийгддэг улсын чанартай замын их болон дунд засвар, арчилгаа, замын шуурхай хэсэг, зам гэрээлэгчийн зардалд шаардагдах 25.0 тэрбум төгрөгийг төсөвт нэмж тусгах;

2. ТӨСВИЙН ТОДОТГОЛООР ХИЙГДЭХ ӨӨРЧЛӨЛТҮҮД

2.1. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТОДОТГОЛЫН ТУХАЙ

1. Буурах орлого

Ирэх 2015 онд эдийн засгийн нөхцөл байдлын улмаас төсвийн орлого **905.6** тэрбум төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс буурахаар байна.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 7,159.9 тэрбум төгрөг байхаар баталсан. Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа ДНБ-ий бодит өсөлт 10.2 хувь, нийт импорт 6.8 тэрбум ам.доллар, нийт экспорт 6.9 тэрбум ам.доллар байхаар тооцож байсан юм.

Хэдийгээр өнгөрсөн 10 жилийн хугацаанд төсвийн орлого жилд дунджаар 28.0 хувь өсөж байсан боловч 2014 онд орлогын өсөлт өмнөх оны түвшнээс буурч болзошгүй байна. Энэ онд экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, тоо хэмжээний бууралт, импортын бууралт, дотоодын эдийн засгийн хүндрэлтэй байдал зэрэг нь орлогын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна. Энэ нөхцөл байдал ирэх 2015 онд ч үргэлжлэх төлөвтэй байна.

Эдийн засгийн хүндрэлтэй байгаа энэ цаг үед төсвийн орлогыг өөдрөгөөр төсөөлж, санхүүжих боломжгүй аливаа зардал төсөвт суулгах нь төсвийн ачааллыг нэмэгдүүлж, аж ахуй нэгжүүдийг санхүүгийн хүндрэлд оруулах эрсдэлтэй юм.

Иймд 2015 онд төсвийн орлогыг бодитой төлөвлөх замаар төсвийн орлогын суурийг засах зайлшгүй шаардлагатай байна.

Ирэх 2015 онд манай улсын эдийн засагт тулгарч болзошгүй дараах эрсдлийг харгалзан үзэж, төсвийн орлогын батлагдсан төлөвлөгөөг **905.6** тэрбум төгрөгөөр бууруулахаар төсвийн тодотголд тусгалаа.

Нэг. Эрдэс бүтээгдэхүүний биет хэмжээ, үнийн бууралт

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого: Уул уурхайн яам, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төсөөлөлд тулгуурлан ирэх 2015 онд нийт 20 сая тонн нүүрсийг тонн тутам нь 50.0-70.0 орчим ам.долларт экспортлохоор төлөвлөсөн.

Гэвч дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ сэргэх хандлага ажиглагдахгүй байгаагаас гадна БНХАУ түүхий нүүрсний хэрэглээгээ бууруулах бодлогыг эрчимтэйгээр хэрэгжүүлсээр байна. Түүнчлэн 2014 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр БНХАУ, Австрали Улс хооронд байгуулсан “Чөлөөт худалдааны хэлэлцээр” нь манай улсын экспортын нүүрсний өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлөхөөр байгаа тул 2015 онд Монгол Улсын нүүрсний экспортын хэмжээ өнөөгийн түвшнээс нэмэгдэхгүй байх өндөр эрсдлийг дагуулж байна. Эдгээр бодит эрсдлийг харгалзан үзэж ирэх 2015 онд 15.0 сая тонн нүүрсийг тонн тутамд 30.0-60.0 ам.долларын үнээр экспортлохоор тооцож, төсвийн тодотголын төсөлд тусгалаа.

Дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ буурч байгаатай зэрэгцэн эдгээр бүтээгдэхүүний үнийн таамаглал гаргадаг олон улсад нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагууд ирэх 2015 оны үнийн төсөөллөө тогтмол шинэчилсээр байгаа тул төмрийн хүдрийн үнийг тонн тутам 72.9-80.6 ам.доллар байсныг 52.0-60.0 ам.доллар, цайрын үнийг тонн тутамд 2,364.4 ам.доллар байсныг 2,334.0 ам.доллар болгон бууруулан тодотголын төсөлд тусгалаа. Эрдэс бүтээгдэхүүний үнэ ийнхүү буурч байгаа нь манай улсын уул уурхайн үйлдвэрлэлийн биет хэмжээ буурах бодит эрсдлийг дагуулж байна.

Эдгээр хүчин зүйлсийг харгалзан 2015 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөсөн хэмжээнээс 224.9 тэрбум төгрөгөөр бууруулан нийт 426.9 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тодотголын төсөлд тусгалаа. Гол нэр төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэ, төсөвт төвлөрүүлэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна. Үүнд:


Хүснэгт. Голлох эрдэс бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэ, төсвийн орлого

Бүтээгдэхүүн	Тоо хэмжээ		Үнэ /ам.доллар/		АМНАТ /тэрбум төгрөг/	
	2015 төс	2015 год	2015 төс	2015 Год	2015 төс	2015 год
Зэсийн баяжмал /мянган тн/	1,409.2	1,250.0	6,354.7	6,354.7	351.3	253.9
Алт /тонн/ Оюу Толгойн алт орсон	31.3	29.5	1,248.9	1,248.9	87.8	68.9
Нүүрс /экспорт сая.тонн/	19.8	15.0	50.0-70.0	30.0-60.0	103.5	42.2
Төмрийн хүдэр /сая тонн/	5.0	3.4	72.9-80.6	52.0-60.0	76.2	39.0

Газрын тосны орлого: Сүүлийн жилүүдэд Монгол Улсад газрын тосны хайгуул судалгааны ажил эрчимжиж, олборлолтын хэмжээ ч жилээс жилд нэмэгдсээр байгаа бөгөөд олборлолт жилд дунджаар 34.0 хувиар өсөж байна. Үүнтэй уялдуулан

2015 онд газрын тосны экспортын хэмжээг 8.0 сая баррелаас доошгүй байхаар, 1 баррел газрын тосны үнийг дунджаар 101.0 ам.доллар байхаар тооцож, газрын тосны орлогоор 324.9 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тусгасан.

График. Газрын тосны үнэ, ам.доллар/баррел





Харин энэ оны 8 дугаар сараас эхлэн дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ тасралтгүй буурсаар байна. Нэг баррел түүхий тосны үнэ 2014 оны 8 дугаар сард 100.5 ам.долларт хэлбэлзсэн бол 2014 оны 11 дүгээр сард дунджаар 76.9 ам.долларт хэлбэлзэж, 3 сарын дотор 23.1 орчим хувиар буурсан ба үнийн уналт 12 дугаар сард ч үргэлжлэх төлөвтэй байна. Газрын тосны үнийн төсөөллийг хийдэг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын таамаглаж буйгаар энэхүү үнийн бууралт нь 2015 онд үргэлжлэх төлөвтэй байна.

Иймд 2015 онд газрын тосны орлого төлөвлөсөн хэмжээнээс 40 гаруй тэрбум төгрөгөөр буурч 284.9 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгав.

Гаалийн тэмдэгтийн хураамж, агаарын бохирдлын төлбөрийн орлого: Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал, жоншны экспорт төлөвлөсөн хэмжээнээс буурч болзошгүй байгаа тул гаалийн тэмдэгтийн хураамжийн орлогыг 10.7 тэрбум төгрөгөөр бууруулж 35.0 тэрбум, агаарын бохирдлын төлбөрийн орлогыг 4.8 тэрбум төгрөгөөр бууруулж 17.0 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.

Хоёр. Импортын бууралт

Импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар: 2014 онд импортын хэмжээг эдийн засгийн өсөлттэй уялдуулан 6.8 тэрбум ам.доллар байхаар тооцсон боловч энэ оны эхний 11 сарын гүйцэтгэлээр импортын хэмжээ дөнгөж 4.8 тэрбум ам.доллар байгаа нь өмнөх оны мөн үеэс 16.7 орчим хувиар буурсан байна. Тоног төхөөрөмж, хүнд машин, механизмын импорт буурсан, валютын ханш, инфляцын өсөлттэй холбогдуулан дотоодын хэрэглээ хумигдаж байгаа нь импорт буурахад нөлөөлсөн байна. Энэхүү бууралт нь 2015 онд үргэлжлэх хандлагатай байна.



Иймд 2015 онд нийт импорт төлөвлөсөн хэмжээнээс 23 орчим хувиар буурч, 5.7 тэрбум ам.долларт байхаар төсөөлж, импортын гаалийн албан татварын орлого 67.3 тэрбум төгрөгөөр, НӨАТ-ын орлого 142.7 тэрбум төгрөгөөр, нийт 210.0 тэрбум төгрөгөөр бууруулан тооцлоо. Ингэснээр гаалийн албан татварын орлогоор 376.3 тэрбум төгрөг, импортын НӨАТ-ын орлогоор 962.8 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлэхээр төсвийн тодотголд тусгалаа.

Гурав. Дотоод эдийн засгийн нөхцөл байдал

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар: Эдийн засгийн өсөлтийн хурд саарсан, гадаад валютын ханш өссөн, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан зэргээс шалтгаалан аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшин 2014 оны байдлаар сүүлийн 5 жилийн хамгийн доод түвшинд хүрээд байна.

Мөн нүүрс, төмрийн хүдэр зэрэг голлох эрдэс бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ ирэх онд өсөхөөргүй байгаа нь уул уурхайн томоохон аж ахуйн нэгжүүдийн борлуулалт буурахад нөлөөлөх төлөвтэй байна. Түүнчлэн, банкны системийн хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл, чанаргүй зээлийн хэмжээ өссөн нь аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадвар буурсан байгааг харуулж байгаа юм.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар аж ахуйн нэгжүүдийн алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцдог тул 2014 онд татварын тайлангаар тайлагнасан алдагдал ирэх онд шилжин тооцогдож, тус татварын орлого бүрдэлтэд сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Эдгээр хүчин зүйлсээс шалтгаалан аж

ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг төлөвлөсөн хэмжээнээс 21.7 тэрбум төгрөгөөр бууруулж, 591.7 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

Дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар: 2014 оны хувьд эдийн засгийн өсөлтийн хурд саарсны улмаас эдийн засаг дахь хувийн хэрэглээний өсөлт саарч байна. Түүнчлэн, Монголбанк бодлогын хүүг нэмэгдүүлж, төсвийн зарлагыг бууруулж, төсвийн хумих бодлого баримталж байгаагаас шалтгаалан ирэх 2015 онд Засгийн газрын болон хувийн хэрэглээ буурахаар байна.

Иймд хэрэглээний түвшинтэй уялдуулан, гадаад, дотоод зах зээлийн тулгарч болзошгүй бодит эрсдэл тооцсоны үндсэн дээр дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлогыг төлөвлөсөн хэмжээнээс 270.3 тэрбум төгрөгөөр бууруулж, 400.1 тэрбум төгрөг байхаар тооцож төсвийн тодотголд тусгалаа.

Хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого: Ирэх 2015 онд нэмэгдүүлэхээр төлөвлөж байсан цалингийн өсөлтийг бууруулан тооцсонтой холбогдуулан хувь хүний орлогын албан татвар төлөвлөсөн хэмжээнээс 23.5 тэрбум төгрөгөөр буурч 538.6 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төлөвлөсөн хэмжээнээс 59.3 тэрбум төгрөгөөр буурч 1,206.6 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

Хувьцааны ногдол ашиг: Зэсийн үнийн бууралтаас шалтгаалан “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ийн 2014 оны хуримтлагдах ашгийн хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс буурч болзошгүй байна. Түүнчлэн, тус үйлдвэр хуримтлагдсан ашгаасаа дахин хөрөнгө оруулалт хийх замаар эдийн засгийн хүндрэлтэй байдлыг даван туулах нь зүйтэй гэж үзлээ. Тус үйлдвэрээс төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг 30.0 тэрбум төгрөгөөр бууруулан тооцож, нэгдсэн төсвийн нийт хувьцааны ногдол ашгийн орлогыг 67.5 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

Бусад орлого: Улсын төсвийн орлого төвлөрүүлэгч зарим байгууллагуудыг аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилж байгаагай холбогдуулан төсөвт төвлөрүүлэх орлогыг батлагдсан төсвөөс 3.0 тэрбум төгрөгөөр бууруулан төсвийн тодотголын төсөлд тусгалаа.

Орон нутгийн татварын эрх зүйн орчныг бүрдүүлэх

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн дагуу хувь хүн, хуулийн этгээдийн өмчилж буй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөд 4 тусдаа хуулиар татвар ногдуулах, 4 өөр хугацаанд татвар төлөх, тайлагнахаар зохицуулсан нь хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдал үүсгэж байна. Иймд үл хөдлөх хөрөнгө, авто тээврийн хэрэгсэл, буу, малын тоо толгойд ногдуулдаг татварыг нэгдсэн байдлаар зохицуулахаар Хөрөнгийн албан татварын тухай хуулийн төслийг боловсрууллаа. Ингэснээр эдгээр хөрөнгөд ногдох татварыг нэг хугацаанд төлж тайлагнах бөгөөд татварын хуулийн энгийн ойлгомжтой байх зарчим хангагдаж, хуулийн хэрэгжилт улам хялбар болох, сайжрах үр дүнтэй байна.

Татварын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиудад нийслэл хотын албан татварын талаар хуульчилж заасан байдаг боловч өнөөг хүртэл нийслэл хотын албан татварын тухай хууль батлагдаагүй байна. Иймд эдгээр хуулийн хэрэгжилтийг хангах, орон нутаг төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх үүднээс Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Дээрх хуулийн төслүүд батлагдсанаар орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал иргэдийнхээ саналд үндэслэн татварын хувь хэмжээг тогтоох боломжтой болох юм.


Эдгээр татварын дээд болон доод хэмжээтэй байхаар хуулийн төсөлд тусгаснаар орон нутаг өөрсдийн хэрэгцээ шаардлагад үндэслэн одоогийн татварын нөхцөлийг цаашид хэвээр хадгалах, эсвэл тодорхой хязгаарын хүрээнд татвар нэмэгдүүлж ногдуулах эрхийг өгч байгаа юм.

Харин эдгээр татвараар Орон нутгийн төсвийн орлогын 2015 оны тодотголын төсөлд нэмж орлого төвлөрүүлэхээр тусгаагүй болно.

2.2. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН ТОДОТГОЛЫН ТУХАЙ

Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх чиглэлээр УИХ, Засгийн газраас тавьсан зорилтын хүрээнд төсвөөс санхүүжүүлж байгаа нийгмийн хамгааллын шинжтэй зарим арга хэмжээг зорилтот бүлэгт чиглүүлэх, татаас урамшууллыг зорилт, үр дүнтэй нь уялдуулж авч үзэх, төсвийн байгууллагуудын чиг үүргийн давхардлыг арилгаж бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, зарим хөтөлбөр, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхгүй байх, урсгал зардлыг нь тодорхой хэмжээгээр бууруулах зэргээр зардлын өсөлтийг хязгаарлах, үр ашгийг сайжруулах чиглэл баримталж урсгал зардлын 2015 оны тодотголын төслийг боловсрууллаа.

Хүснэгт. Төсвийн урсгал зарлагын хэмжээ, өсөлтийн хувь 2009-2015*



Монгол Улсын 2015 оны төсвийн тодотголоор нэгдсэн төсвийн урсгал зардлын хэмжээг анх батлагдсан түвшнээс 518.1 тэрбум төгрөгөөр буюу 8.6 хувиар бууруулж, 5,515.1 тэрбум төгрөг байхаар тооцон төсөвлөлөө.

Хүснэгт. Урсгал зардлын хэмжээ, өсөлт, эдийн засгийн ангиллаар

	2012	2013	2014	2015	2015	Зөрүү
	Гүйц	Гүйц	Тод	Төл	Тод	год-төл
УРСГАЛ ЗАРЛАГА	4,428.1	4,552.6	5,351.0	6,033.2	5,515.1	-518.1
өсөлтийн хувь	36.8%	2.8%	17.5%	12.8%	-8.6%	
1. Бараа, үйлчилгээний зардал	2,052.4	2,391.2	2,646.1	3,043.6	2,810.5	-233.1
өсөлтийн хувь	21.8%	16.5%	10.7%	15.2%	-7.7%	
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	125.9	270.4	509.2	696.9	696.9	0.0
өсөлтийн хувь	237.4%	114.8%	88.3%	36.9%	0.0%	
3. Татаас ба урсгал шилжүүлэг	2,249.8	1,891.0	2,195.7	2,292.7	2,007.6	-285.0
өсөлтийн хувь	35.1%	-16.0%	16.1%	4.4%	-12.4%	

Нэг. Засгийн газрын бүтэцтэй холбоотой гарсан өөрчлөлт

УИХ-аас 2014 оны 10 дугаар сарын 7-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд нийцүүлэн Монгол улсын 2015 оны төсвийн төслийг Засгийн газраас боловсруулж, УИХ-аар 2014 оны 11 дугаар сарын 14-ний өдөр баталсан.

Харин Улсын Их Хурал 2014 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Засгийн газрын бүтцийн тухай хуулийг шинэчлэн баталснаар бүтцийн өөрчлөлтөд хамрагдсан Төсвийн ерөнхийлөн захирагч, байгууллагын 2015 оны төсөвт тодотгол хийх зайлшгүй нөхцөл үүссэн байна.

УИХ-ын 2012 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн дагуу 16 яам, 30 агентлагтай байсан бол УИХ-ын 2014 оны 75 дугаар тогтоолоор 15 яам, 29 агентлагтайгаар үйл ажиллагаа явуулахаар бүтэц, чиг үүргийг өөрчлөн баталсан байна.

Хүснэгт. Яам, агентлагийн орон тооны дээд хязгаарын өөрчлөлт /нийт дүнгээр/

№	БАЙГУУЛЛАГУУД	ЗГ-аас тогтоосон орон тооны дээд хязгаар		Орон тооны дээд хязгаар буурсан дүн	
		Хуучин бүтэц	Шинэ бүтэц	орон тоо	хувиар
	1	2	3	4 = 3 - 2	5 = 4:3
1	Яамдын нийт дүн	1,722	1,484	-238	-14%
2	Агентлагийн нийт дүн	2,645	2,180	-465	-18%
3	НИЙТ ДҮН	4,367	3,664	-703	-15.9%

Дээрх өөрчлөлтийн дагуу Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар яам, агентлагуудын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоосноор, 2014 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад үндсэн ажиллагсдын нийт орон тоог дунджаар 15 хувиар бууруулахаар шийдвэрлэсэн тул холбогдох өөрчлөлтийг төсвийн төсөлд тусгалаа. Ингэснээр 2015 оны төсөвт яамдын зөвхөн цалин, хөлстэй холбоотой урсгал зардал(2014 оны суурь цалингаар буюу нэмэгдэл тооцоогүй дүн) 2014 оны батлагдсан түвшинтэй харьцуулбал 3.2 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

Хоёр. Төсвийн зарлагыг бууруулах чиглэлээр авах арга хэмжээнүүд

Ирэх 2015 оны төсвийн жилээс эхлэн төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлж төсвийн урсгал зардлын өсөлтийг хязгаарлаж, улмаар зохистой түвшинд бууруулах, төсвийн хөрөнгийн зарцуулалтад үр ашгийг сайжруулах зорилт тавьж байна. Энэ зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Оюутны үндэсний тэтгэлгийг оюутны сурлагын амжилттай уялдуулан олгох. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн дагуу 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үндэсний болон урамшууллын тэтгэлгийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр их дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа оюутнуудад олгож байна. Давхардсан тоогоор 2012 онд нийт 166.4 мянган оюутанд 102.3 тэрбум төгрөгийн, 2013 онд 166.6 мянган оюутанд 104.6 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон бөгөөд 2014 онд 159.0 мянган оюутанд 95.8 тэрбум төгрөгийн тэтгэлэг төсөвлөн олгож байна. Уг арга хэмжээг 3 жил хэрэгжүүлэхэд нийт **307.2** тэрбум төгрөг улсын төсвөөс зарцуулсан байна. Засгийн газрын 2014 оны 214 дүгээр тогтоолоор үндэсний

тэтгэлгийг 2.0-оос дээш голч дүнтэй суралцсан оюутанд олгохоор болсонтой уялдуулан 68.7 тэрбум төгрөг, урамшууллын тэтгэлэгт 9.0 тэрбум төгрөг, нийт 77.7 тэрбум төгрөгийг 2015 оны төсөвт тусгасан.

Бүх оюутнуудад хавтгайруулан олгож байгаа үндэсний тэтгэлгийг сурлагын амжилттай нь уялдуулах, харин сурлагын өндөр амжилт гаргасан суралцагчдад олгож байгаа урамшууллын тэтгэлгийг хэвээр үргэлжлүүлэн олгох нь зүйтэй гэж үзэж байна. Иймд үндэсний тэтгэлгийг сурлагын амжилттай нь буюу 3.0 голч дүнгээс дээш суралцсан оюутанд олгохоор тооцоход 2015 онд 33.7 тэрбум төгрөг хэмнэгдэхээр байна.

2. Нийгмийн хамгааллын зарим мөнгөн тэтгэмж, үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлнэ. Төрөөс иргэдэд олгож байгаа дараах тэтгэмж, үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлнэ. Үүнд:

2.1. Хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт олгоно: Хүний хөгжил сангаас Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд бүрд сар бүр 20 мянган төгрөгийг олгож байна. “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг зөвхөн орлого багатай өрхүүдийг хамруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Засгийн газрын 2013 оны 269 дугаар тогтоолын дагуу олон улсын жишигт нийцүүлж “Орлогыг орлуулан тооцох аргачлалаар” Монгол Улсын бүх өрхийг хамарсан өрхийн амьжиргааны судалгааг хийж “өрхийн мэдээллийн нэгдсэн сан”¹ үүсгэсэн. Өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгаанд хамрагдсан өрхүүдийг онооны системээр үнэлж тухайн өрхийн авсан онооны эрэмбээр 20 бүлэг болгон мэдээллийн санд байршуулсан. Нийт өрхийн 1-ээс 15 дугаар бүлэгт буюу нэн ядуугаас дундаж хэрэглээтэй өрхөд нийт судалгаанд хамрагдсан өрхийн 64.1 хувь буюу 421.8 мянган өрх, тэдгээрт 629.5 мянган хүүхэд байгаа нь 2015 онд хүүхдийн мөнгө авахаар тооцсон нийт хүүхдийн 60 гаруй хувь болохоор байна. Тэдгээр өрхийн хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохоор тооцож тусгалаа.

2.2. Эхийн одонгийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлнэ. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн дагуу зургаан хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг “Эхийн алдар” нэгдүгээр одонгоор, дөрвөн хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг “Эхийн алдар” хоёрдугаар одонгоор шагнадаг. УИХ-ын 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор Нэгдүгээр одонтой эхчүүдэд жил бүр 200.0 мянган төгрөг, Хоёрдугаар одонтой эхчүүдэд жил бүр 100.0 мянган төгрөгийн мөнгөн тусламж өгөхөөр заасан. Ирэх 2015 оны төсөвт нийт 211.0 мянган одонтой эхэд 29.9 тэрбум төгрөгийн мөнгөн тэтгэмж олгохоор төлөвлөсөн байсан.

Монгол Улсын 2015 оны төсвийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа Эхийн алдар одонтой эхчүүдийн тэтгэмжийг хүүхэд өсгөх үед нь буюу хамгийн бага хүүхэд нь 18 нас хүртэлх хугацаанд олгох нь зүйтэй гэж үзэж байна. Ингэснээр 2015 оны батлагдсан төсвөөс 19.5 тэрбум төгрөгөөр буурч, 10.5 тэрбум төгрөгийг зарцуулах боломжтой юм.

¹ Нийгмийн халамжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасныг үндэслэн ХАХНХЯ олон улсын жишигт нийцсэн “Орлогыг орлуулан тооцох аргачлалаар” 2013 онд Монгол Улсын бүх өрхийг хамарсан өрхийн амьжиргааны судалгааг хийж “өрхийн мэдээллийн нэгдсэн санг” үүсгэсэн.

2.3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардлыг бууруулна. Ахмад настны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцаж, эмчилгээ үйлчилгээнд үнэгүй хамрагдах боломжоор хангаж байгаатай уялдуулан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн зардлыг оновчтой тогтоох шаардлагатай байна. Үүний хүрээнд нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн, тэдгээрийг ядуурлаас гаргах зорилго бүхий үйлчилгээг хэвээр үргэлжлүүлж, харин сэргээн засах үйлчилгээний зардлыг цаашид санхүүжүүлэхгүй байхаар тооцлоо. Ингэснээр 2015 онд 3.7 тэрбум төгрөгийг орон нутгийн суурь зардлаас хэмнэх боломжтой гэж үзэж байна.

2.4. Зарим тэтгэмж, үйлчилгээнд зарцуулж байгаа хөрөнгийг амьжиргааны төвшин хамгийн бага зорилтод хэсэгт шилжүүлнэ.

2.4.а. Одоогийн хуулийн хүрээнд нийгмийн даатгалтай эхчүүд нийгмийн даатгалын сангаас төрөхийн өмнөх 2 сар, төрсний дараах 2 сар буюу нийт 4 сарын хугацаанд сүүлийн 12 сард авсан дундаж цалингийн 70-100 хувьтай тэнцэх тэтгэмжийг буюу дунджаар 1,071.0 мянган төгрөг, мөн дээрээс нь халамжийн сангаас жирэмсний 5 сараас эхлэн нийт 12 сарын хугацаанд сар бүр 40 мянган төгрөг буюу 480 мянган төгрөг, нийт 1551.0 мянган төгрөг авдаг байна. Харин НДС-д хамрагдаагүй эхчүүдийн хувьд зөвхөн халамжийн сангаас жирэмсний 5 сараас эхлэн нийт 12 сард нийт 480 мянган төгрөг авч байна.

Хүснэгт. Халамжийн сангаас олгох жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж

	Жирэмсэн болон нярай, хөхүүл эхчүүд	Хамрагдах эхчүүд	Сар бүр олгох тэтгэмж /мян.төг/	Халамжийн сан-одоогийнх		Халамжийн сан-өөрчлөгдөх		2015 оны тодотголоор буурах зөрүү /сая.төг/
				хамрах хугацаа /сар/	Нийт зардал /сая.төг/	хамрах хугацаа /сар/	Нийт зардал /сая.төг/	
1	НДС-аас тэтгэмж авах эрх үүссэн	45,700	40	12	21,936.0	7	12,796.0	(9,140.0)
2	Бусад /эрх үүсээгүй/	43,525	40	12	20,892.0	12	20,892.0	-
	НИЙТ	89,225			42,828.0		33,688.0	(9,140.0)

Иймээс нийгмийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн эхчүүдэд нийгмийн халамжийн сангаас олгох жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийг төрсөн сараас эхлэн 7 сарын хугацаанд олгодог болохоор тооцлоо.

2.4.б. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэнд олгох онцгой тохиолдлын тэтгэмжийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эхэд олгодог болгож өөрчилнө.

2.4.в. Түүнчлэн Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.3, 13.5.4-д заасан онцгой тохиолдлын тэтгэмжид хорихоос суллагдсан иргэн бүр санхүүгийн чадавхаас үл хамааран хамрагдах болж, хавтгайрч байгаа учраас энэхүү тэтгэмжийг олгохдоо амьжиргааны түвшинтэй уялдуулж өрхийн мэдээллийн нэгдсэн санд багтсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгодог болж хамрах хүрээг хумина.

2.4.г. Дээрх буюу 2.4.а.-2.4.б.-д дурдсан хэмнэлтээс бий болох эх үүсвэрээс нийт 7.6 тэрбум төгрөгийг зорилгод бүлгийн өрхийн гишүүн-иргэний хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт шилжүүлэхээр тооцон төсөвт тусгалаа.

3. Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг салбар бүрд тэгш хандах зарчимд үндэслэж олгоно. Төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг салбарын хуулиудаар харилцан адилгүй 12-36 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээгээр тогтоож байна. Мөн тэтгэмж тооцоход баримтлах цалинг хамгийн сүүлд авч байсан сарын цалингаас тооцдог нь жил бүр төсвийн зардлыг нэмэгдүүлж байна. Энэ хэвээр үргэлжилбэл тэтгэмжид зарцуулах хөрөнгө хүүхдийн мөнгө хөтөлбөрийн хагастай тэнцэхүйц болж өсөхөөр байна. Иймээс цаашид тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн хэмжээг салбар үл харгалзан иргэний сүүлийн 5 жилийн цалингийн дунджийг баримтлан тэтгэмжийн хэмжээ, тэтгэмж олгох шалгуур, нөхцөлийг Засгийн газар тогтоодог байхаар холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах төслийг 2015 оны төсвийн тодотголын хамтаар УИХ-д өргөн мэдүүлж байна.

4. Үнэ тогтворжуулах, үйлдвэрлэл нэмэгдүүлэх хөтөлбөрийн зарим арга хэмжээг эдийн засгийн үр ашигтай нь уялдуулна. Төсвөөс хөдөө аж ахуй, эрчим хүчний салбарт олгож буй зарим татаас, урамшууллын хэрэгжилт, үр дүнг харгалзан үзэж, урамшууллын хэмжээг зохистой түвшинд бууруулахаар тооцон нийт 27.9 тэрбум төгрөгөөр зардал бууруулахаар төсөлд тусгав. Үүнд:

4.1. Малчид, үндэсний үйлдвэрлэгчийг дэмжих зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоолоор малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан хоршооны малчин, мал бүхий этгээдийн үндэсний үйлдвэрт тушаасан бог малын арьс тутамд 3000 төгрөг, адуу, үхрийн шир тутамд 15000 төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн бөгөөд уг арга хэмжээг 2014 онд хэрэгжүүлэхэд нийт 18.0 тэрбум төгрөг тусгасан. Гэвч анх удаа хэрэгжиж байгаа тул зохион байгуулалт жигдрээгүй, мөн үйлдвэрүүд төлөвлөсөн хэмжээнээс бага арьс, шир үйлдвэрлэлд авсан зэрэг шалтгааны улмаас оны эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2.4 тэрбум төгрөг зарцуулагдахаар байна.

Мөн УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоолоор дотоодын арьс, ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчид хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход 140.4 тэрбум төгрөгийн Засгийн газрын бонд гаргахаар шийдвэрлэсэн.

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэх, мөн татаас олгох нөхцөл шалгуурыг сайжруулж үр дүнтэй нь уялдуулах замаар хамрах хүрээг оновчтой болгох чиглэлээр холбогдох журамд өөрчлөлт оруулж 2015 оны төсвийн тодотголоор арьс, ширний урамшуулалд төлөвлөсөн зардлыг 9.0 орчим тэрбум төгрөгийг бууруулахаар тооцов.

4.2. Хаврын улиралд хүн ам төвлөрсөн суурин газарт махны нийлүүлэлтийн хомсдолоос шалтгаалсан үнийн өсөлтийг бууруулах зорилгоор мах нөөцөлж буй хувийн хэвшлийн зарим аж ахуйн нэгжүүдэд урамшуулал, санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулж төсвөөс 2010-2013 онд жил бүр 2.4-11.4 хүртэл тэрбум төгрөг зарцуулсан, 2014 онд 14 тэрбум төгрөг төсөвлөсөн байна. Цаашид махны нөөц бэлтгэх үйл ажиллагааг мах бэлтгэн нийлүүлэх дэд бүтэц(зам, агуулах сав, төрөлжсөн аж ахуйн нэгжүүд г.м) харьцангуй сайжирсан гэж үзэж байгаа тул 2015 онд төсвөөс махны нөөц бэлтгэх урамшууллын зардлыг 14.0 тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцов.

4.3. Эрчим хүчний татаас (агаарын чанарыг сайжруулахад айл өрхөд олгодог татаас)-ыг 5.0 тэрбум төгрөгөөр бууруулах. Агаарын тухай хууль, УИХ-ын 2011 оны 11 дүгээр тогтоолын дагуу нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын цахилгаан эрчим хүчний шөнийн хэрэглээнд тодорхой нөхцөл шалгуурыг хангасан айл өрхөд цахилгааны үнийг 50 хувиар бууруулж, зөрүүг улсын төсвөөс санхүүжүүлэхээр зохицуулсан байна. Хэрэглэгчид олгож байгаа цахилгааны үнийн урамшуулалд 2011-2014 онуудад нийт 7.7 тэрбум төгрөгийг олгосон бол 2015 оны төсөвт нийт 5.0 тэрбум төгрөг тусгасан байна.

Сүүлийн жилүүдэд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр цогц үйл ажиллагааг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын(хуучин нэрээр) багц дахь цэвэр, агаар сангаар дамжуулан санхүүжүүлж байгаа, мөн уг арга хэмжээнүүдийг орон нутгийн хөгжлийн сан, хандивлагч бусад талуудыг татан оролцуулах замаар хэрэгжүүлэх боломжтой тул агаарын чанарыг сайжруулах бүсийн айл, өрхөд олгодог цахилгааны үнийн хөнгөлөлтөд зориулж Эрчим, хүчний сайдын багцад туссан татаас-урамшууллын зардлыг 5.0 тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцов.

5. Төрийн зарим байгууллагуудыг нэгтгэх, татан буулгах, аж ахуйн тооцоонд шилжүүлж төсвөөс гаргах, яам, агентлагийн орон тоог 15 хувиар бууруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж төсвийн урсгал зардлыг бууруулна. Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийснээр 2015 оны батлагдсан төсвийн урсгал зардлыг 18.5 тэрбум төгрөгөөр, төсвөөс санхүүждэг байгууллагын тоог 56-аар, төрийн албан хаагчдын орон тоог 1,669 хүнээр бууруулна.

Хүснэгт. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт

Бүтцийн өөрчлөлтөд хамруулах чиглэл	Өөрчлөлтийн өмнө	Өөрчлөлтийн дараа	2015 онд буурах цэвэр дүн
Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийг нэгтгэх, төсвөөс гаргах			
Байгууллагын тоо	49	19	30
Орон тоо	1,982	1,723.0	259
Зарим төсөвт байгууллагуудыг нэгтгэх			
Байгууллагын тоо	17	6	11
Орон тоо	641	559	82
Зарим төсөвт байгууллагыг татан буулгах			
Байгууллагын тоо	3	0	3
Орон тоо	14	1	13
Зарим төсөвт байгууллагыг аж ахуйн тооцоонд шилжүүлж төсвөөс гаргах			
Байгууллагын тоо	7	0	7
Орон тоо	592	0	592
Засгийн газрын тусгай сангийн ажлын албадыг татан буулгах			
Байгууллагын тоо	4	1	3
Орон тоо	25	5	20
ЗГ-ын шинэ бүтэцтэй холбоотой яам, агентлагийн орон тоог бууруулах			
Байгууллагын тоо	46	44	2
Орон тоо	4,367	3,664	703.0
НИЙТ			
Байгууллагын тоо	126	70	56
Орон тоо	7,621	5,952	1,669

5.1. Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийг өөрчлөн зохион байгуулна.

Шинжлэх ухааны академи, их сургуулиуд болон зарим яамдын харьяа төсвөөс санхүүждэг эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүд, шинжлэх ухаан үйлдвэрлэлийн төвүүдийн харьяалал, төсвөөс санхүүжүүлэх зарчим, хэлбэрийг өөрчилснөөр захиргаа, санхүү зэрэг нийтлэг чиг үүргийн нийт 259 орон тоог цомхотгож, урсгал зардлыг 1,476.2 сая төгрөгөөр бууруулна.

Тухайлбал, ижил болон ойролцоо чиг үүрэгтэй суурь судалгааны болон шинжлэх ухаан үйлдвэрлэлийн чиглэлийн 39 хүрээлэн, мөн газар хөдлөлийн станцуудыг нэгтгэн 19 болгон зохион байгуулж зохих байгууллагуудад харьяалуулснаар орон тоог 175-р бууруулж урсгал зардлыг 676.0 сая төгрөгөөр, харин их дээд сургуулиудын дэргэдэх болон харьяанд байгуулагдсан 6 хүрээлэн, төвүүдийг төсвөөс гаргаж орон тоог 72-р, урсгал зардлыг 782.8 сая төгрөгөөр, 4 хүрээлэн, төвийг татан буулгаж, төсвөөс гаргах хүрээнд орон тоог 12-р, урсгал зардлыг 17.3 сая төгрөгөөр тус тус бууруулахаар төсөвт тусгав.

Хүснэгт. Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн бүтцийн өөрчлөлтийн санал (мян.төг)

#	Эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийг бүтцийн өөрчлөлтөд оруулах чиглэл	Бүтцийн өөрчлөлтийн өмнөх төсвөөс санхүүжиж буй байгууллагын тоо	Бүтцийн өөрчлөлтийн дараах төсвөөс санхүүжих байгууллагын тоо	2015 оны	ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ			
					орон тоо	Буурах орон тоо	Буурах төсөв	Тэтгэмж
1	Нэгтгэн зохион байгуулах хүрээлэн, төвүүд	39	19	1,873	175	1,361,700.0	685,650.0	676,050.0
2	Их сургуулийн харьяалалд нь шилжүүлж төсвөөс гаргах	6	0	72	72	782,861.3	-	782,861.3
3	Татан буулгах, төсвөөс гаргах	4	0	12	12	56,895.7	39,600.0	17,295.7
	Дүн	49	19	1957	259	2,201,457.0	725,250.0	1,476,207.0

5.2. Төсвийн зарим байгууллагуудыг нэгтгэн зохион байгуулна. Ойролцоо чиг үүрэгтэй, нэг төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгуулагдсан төсвийн зарим байгууллагуудыг нэгтгэх, төсвөөс цалинждаг үндэсний хороо, зөвлөлийн ажлын албадыг татан буулгах зэргээр төрийн албан хаагчийн орон тоог 95-аар, захиргаа, удирдлагын зардлыг 646.3 сая төгрөгөөр бууруулна.

Хүснэгт. Нэгтгэн зохион байгуулах төсөвт байгууллагын жагсаалт

Байгууллагын нэр	2015	Бүтцийн өөрчлөлтөд оруулах санал	ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ /сая төг/		
	орон тоо		санал	Буурах орон тоо	6 сарын тэтгэмж
Хөдөлмөрийн сайд	135		23	137.8	167.2
Хөдөлмөрийн төв бирж	67	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний төвд Нэгтгэх	23	137.8	167.2
Хөдөлмөрийн судалгааны институт	19				
Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв	49				
МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар/ҮАБЗНБД	63		10	53.9	65.8
Үндэсний хөгжлийн хүрээлэн	28	Стратеги судалгааны хүрээлэнд нэгтгэж ҮАБЗ-ын харьяалалд шилжүүлэх	10	53.9	65.8
Стратеги судлалын хүрээлэн	35				
Хүнс, хөдөө аж ахуйн сайд	88		10	32.8	39.9
Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори	57	Нэгтгэх	10	32.8	39.9

Малын эм, эмнэлгийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори	31				
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	142		15	85.0	101.0
Багшийн мэргэжил дээшлүүлэх институт	70	Нэгтгэх	7	39.6	-47.1
Насан туршийн боловсролын үндэсний төв	13				
Боловсролын хүрээлэн	59	Боловсролын шинжлэх ухааны их сургуульд нэгтгэх. 2016 оноос үе шаттайгаар төсвөөс гаргах	8	45.3	-53.9
Эрүүл мэнд, спортын сайд	25		3	13.6	17.3
Эмийн сорилын лаборатори	9	Нэгтгэж Мэргэжлийн хяналтын лабораторид шилжүүлэх	3	13.6	17.3
Шим тэжээл хоол судлалын үндэсний лаборатори	6				
Хор судлалын лаборатори	10				
Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн сайд	170	-	15	73.8	92.1
Цаг уур, орчны шинжилгээний хүрээлэн	74	Нэгтгэх	15	73.8	92.1
Байгаль орчны мэдээлэл, тооцооллын төв	55				
Байгаль орчны шинжилгээний төв лаборатори	41				
Шадар сайд	18		6	16.1	21.8
ОБЕГ-ын харьяа "Аврагч" биеийн тамир спортын хороо	18	ОБЕГ-т нэгтгэх	6	16.1	21.8
ДҮН	641		82	413.0	504.9

Хүснэгт. Татан буугдах төсөвт байгууллагын жагсаалт

Байгууллагын нэр	2015 оны төсөв			Бүтцийн өөрчлөлтөд оруулах санал		ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ /сая төг/		
	орон тоо	урсгал	цалингийн сан	Санал	Үндэслэл, тайлбар	Буурах орон тоо	Тэтгэмж	Цэвэр нөлөөлөл
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	10	159.7	147.5	-	-	9	60.2	83.2
Химийн хорт болон аюултай бодисын асуудал хариуцсан үндэсний хороо	2	36.9	32.3	Татан буулгах	ажлын алба байх шаардлагагүй	2	14.5	22.4
Уур амьсгалын өөрчлөлтийн зөвлөл	7	102.5	96.8	Татан буулгах		6	37.4	48.9
Био аюулгүй байдлыг хангах үндэсний хороо	1	20.3	18.4	Татан буулгах		1	8.3	11.9
Шадар сайд	4	82.5	46.3			4	23.2	58.2
УИХ-ын ордон барих төслийг хэрэгжүүлэх нэгж	4	82.5	46.3	Татан буулгах	Чиг үүргийг нь ЗГХЭГ-т шилжүүлэх	4	23.2	58.2
ДҮН	14	242.3	193.8	-	-	13	83.3	141.4

5.3. Зарим байгууллагыг аж ахуйн тооцоонд шилжүүлэх: Өөрийн гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлогоор зардлаа бүрэн санхүүжүүлэх боломжтой 7 төсөвт байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газруудыг аж ахуйн тооцоонд шилжүүлэх боломжтой гэж үзэж, нийт 10.9 тэрбум төгрөгийг урсгал зардлаас хэмнэж, төсвөөс цалинждаг албан хаагчдын тоо 592 хүнээр буурахаар тооцов.

Хүснэгт. Аж ахуйн тооцоонд шилжүүлэх, удирдлагын үйл ажиллагааг нь хувьчлах боломжтой байгууллагын жагсаалт /сая төгрөгөөр/

БАЙГУУЛЛАГА	2015 ОНЫ ТӨСӨВ			Нэмэлт тайлбар
	Урсгал зардал	Үүнээс төсвөөс санхүүжих	Орон тоо	
Удирдлагын академи	4,132.8	1,244.6	147.0	Зөвхөн тогтмол зардлыг төсвөөс санхүүжүүлнэ
Хууль зүйн үндэсний хүрээлэн	1,076.0	976.0	60.0	ААТТӨҮГ болгох боломжтой

Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төв УТҮГ	861.3	861.3	15.0	ААТТӨҮГ болгох боломжтой
Тээвэр, авто замын газар	3,051.2	3,051.2	260.0	Ижил чиг үүрэг хэрэгжүүлж байгаа "Автогээврийн үндэсний төв" ААТТӨҮГ-г нэгтгэх
Буянт-Ухаа биеийн тамир, спортын ордон	1,046.9	682.6	61.0	ААТТӨҮГ болгох боломжтой
Техник спортын клубууд	377.7	363.0	35.0	ААТТӨҮГ болгох боломжтой
Олимпын бэлтгэлийн төв	378.2	268.0	14.0	ААТТӨҮГ болгох боломжтой
Дүн	10,924.1	7,446.8	592	

5.4. Засгийн газрын шинэ бүтцийн дагуу зарим агентлагуудын урсгал зардлыг бууруулав. Засгийн газрын шинэчилсэн бүтцийн дагуу татан буугдсан Цөмийн энергийн газрын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой 25 орон тоог Цөмийн энергийн комисст, цацраг идэвхт ашигт малтмал ашиглах, цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих, цацраг идэвхт хаягдал, цацрагийн үүсгүүрийг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэхтэй холбоотой 35 орон тоог мэргэжлийн хяналтын байгууллагуудад, бодлогын асуудал хариуцсан 2 орон тоог Уул уурхайн яаманд, тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой 6 орон тоог Ашигт малтмалын газарт шилжүүлж, орон тоог 28-аар, урсгал зардлыг 1.1 тэрбум төгрөгөөр тус тус бууруулсан.

Мөн Засгийн газрын шинэ бүтцийн дагуу татан буугдсан Хилийн боомтын нэгдсэн захиргааг татан буулгаж, боомтын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий үйлчилгээний 128 орон тоог гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагуудад шилжүүлж, орон тоог 70-аар, урсгал зардлыг 0.6 тэрбум төгрөгөөр тус тус бууруулсан.

6. Засгийн газрын зарим тусгай сангуудыг татан буулгаж, чиг үүргийг нь холбогдох яам, агентлагт хариуцуулна. Төсвөөс бүрэн санхүүждэг болон санхүүжилтийн зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлдэг тусгай санг татан буулгаж 2015 онд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгийн зарим хэсгийг холбогдох байгууллагын төсөвт шилжүүлж үлдэх урсгал зардлыг төсвөөс бууруулна. Ингэснээр 10.9 тэрбум төгрөгөөр урсгал төсөв сайжрах боломжтой. Мөн Соёл, урлаг хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, Монгол судлалын сангийн ажлын албадыг татан буулгаж орон тоог 20-оор цомхотгоно.

Хүснэгт. Татан буулгаж харьяалах ТЕЗ-д шилжүүлэх болон үлдэх Засгийн газрын зарим тусгай сангийн жагсаалт /сая төгрөгөөр/

#	ЗГ-ын тусгай сангийн нэр	2015 онд батлагдсан	Зарим хэсгийг харьяалах ТЕЗ-д шилжүүлэх болон үлдэх	Буурах орон тоо	6 сарын тэтгэмж	Цэвэр бууруулах	Чиг үүргийг шилжүүлэн авах төсвийн захирагчид
1	Соёл, урлаг хөгжүүлэх сан	10,330.3	4,105.0	9	50.5	-6,275.8	БСШУЯ (Сангийн хуулийг өөрчлөхгүй боловч ажлын албыг татан буулгасан)
2	Эрүүл мэндийг дэмжих сан	3.1			3.1	0.0	ЭМСЯ
3	Байгаль хамгаалах сан	2,678.2	2,678.2	5	29.5	29.5	БОАЖНХЯ (Сангийн хуулийг өөрчлөхгүй боловч ажлын албыг татан буулгасан)
4	Аялал жуулчлалын сан	5,460.8	5,460.8			0.0	БОАЖНХЯ
5	Хүүхдийн төлөө сан	235.0	188.0			-47.0	Хүүхдийн төлөө газар

6	Цэвэр агаарын сан	20,163.9	16,160.7			-4,003.3	
7	Архидан согтуурахтай тэмцэх сан	1,083.3	866.7			-216.7	ХЗЯ
8	Монгол судлалын сан	1,102.9	716.9	6	34.0	-420.6	БСШУЯ (Сангийн хуулийг өөрчлөхгүй боловч ажлын албыг татан буулгасан)
9	Цагдаагийн хөгжлийн сан						Үйл ажиллагаа явуулаагүй сангууд
10	Орон сууц хөгжүүлэх сан						
11	Олон улсын гэрээний дагуу байгуулагдсан сан						
12	Инновацын сан						
13	Орон сууц хөгжүүлэх сан						
14	Сэргээгдэх эрчим хүчний сан						
15	Газрын тосны сан						
Дүн		41,057.5	30,176.2	20	117.1	-10,933.8	-

7. Зарим салбарын дүрэмт хувцасны зардлыг хасах. Татвар, нийгмийн даатгал, мэргэжлийн хяналт, нийгмийн халамж, улсын бүртгэлийн албан хаагчид дүрэмт хувцас өмсөх шаардлагагүй гэж үзэн нийт 228.8 сая төгрөгийг 2015 оны батлагдсан төсвөөс хасаж тооцлоо.

9. Цалин, тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээг 2015 оны төсвийн жилд тэвчинэ. Засгийн газраас эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй нөхцөлд иргэдийн ажлын байрыг хадгалах, иргэдийн орлогын одоогийн байгаа түвшнийг хадгалах чиглэлийг баримталж байна.

Иймд 2015 онд яамд, агентлагаас бусад төрийн албан хаагчийн орон тоог бууруулалгүй хэвээр үлдээж харин цалин, тэтгэврийг нэмэгдүүлэхгүй байхаар тооцлоо. Уг арга хэмжээтэй холбогдуулан цалин нэмэх эх үүсвэр 234.3 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлэх эх үүсвэр 94.6 тэрбум төгрөгийг 2015 оны төсвийн тодотголоос тус тус бууруулж тооцлоо.

10. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцаас бууруулах бусад арга хэмжээнүүд

Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвөөс 2015 онд тэвчиж болох нийт 32.4 тэрбум төгрөгийг төсвийн тодотголоор бууруулахаар тооцлоо(дэлгэрэнгүйг доорх хүснэгтэд харуулав).

Хүснэгт. Урсгал зардал бууруулж буй зарим арга хэмжээ, сая төгрөг

Арга хэмжээ	2015 төсөв	Бууруулах дүн
Нийт	389,529.9	-32,478.5
1. Зэвсэгт хүчний хөгжлийн сан. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний нормын хувцас, хичээл үйлдвэрийн дадлага хийх зардлыг Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас санхүүжүүлэх, үүнтэй холбогдуулан зохих хуульд өөрчлөлт оруулах.	5,039.3	-5,039.3
2. Сургалтын төрийн сангийн зарим урсгал зардлыг бууруулах	23,865.4	-1,400.0
3. Ойжуулалтын арга хэмжээний хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	116.5	-116.5
4. Зарим байгууллагын сургалт семинар, мэдээлэл сурталчилгаа, хичээл үйлдвэрийн дадлагын зардал. Үүнд: Мэдээлэл, шуудан, харилцаа, холбооны газар-40 сая төгрөг, Нийгмийн халамжийн газар-55.4 сая төгрөг, ХАХНХЯ-30.0 сая төг	175.4	-125.4
5. АСЕМ-ын хурлыг 2016 онд зохион байгуулах бэлтгэл хангах урсгал зардлыг 2015 оны төсөвт туссан дүнг 50 хувь бууруулж, хөрөнгийн зардалд шилжүүлэх	5,000.0	-2,500.0
6. Статистикийн судалгааны зардлуудыг 20 хувиар бууруулах	2,967.6	-441.6

7. Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт. Хэрэгжилт нь салбар бүрд харилцан адилгүй тул 2015 онд бууруулах.	390.3	-387.7
8. Эдийн засгийн хорооны олон улсын хурал зөвлөгөөн зохион байгуулах зардал	185.0	-185.0
9. Газрын тосны газрын сургалтын төлбөрийн тэтгэлгийн зардлыг өөрийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулж бууруулах	2,121.9	-707.3
10. Улсын төсвөөс тэтгэврийн санд олгох татаасыг бууруулах	320,131.3	-11,487.4
11. Газар ашигласны төлбөр, ус ашигласны төлбөрөөс байгаль орчны нөхөн сэргээх арга хэмжээнд зориулалт зааж хуваарилдаг хувь хэмжээг бууруулах	29,537.2	-10,088.3

Байгалийн нөөц ашигласны зарим төлбөр, хураамжийн орлогыг зориулалт зааж байгаль орчны нөхөн сэргээх арга хэмжээний зардалд хуваарилж байгаа нь орон нутгийн зарлагыг тэлэх хандлага бий болгох, тухайн орон нутгийн онцлог, төвлөрлөөс хамааран харилцан адилгүй зардлын хуваарилалтыг үүсгэх, орон нутгийн хөгжлийн сан зэрэг бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжтой зарим арга хэмжээтэй давхцах нөхцөл үүсэж байгаа зэргийг үндэслэн зардлыг үе шаттай бууруулах чиглэлээр Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулж, нийт 10.0 тэрбум төгрөгөөр орон нутгийн урсгал зардлыг бууруулахаар тооцов.

Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний нормын хувцас, хичээл үйлдвэрийн дадлага хийх зардалд нийт 5.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр тооцон тусгаж, холбогдох хуульд өөрчлөлт оруулах саналыг 2015 оны тодотголын төслийн хамт боловсруулав.

Улсын төсвөөс Нийгмийн даатгалын санд өгөх өглөгийг 2015 онд 11.5 тэрбум төгрөгөөр төлж барагдуулахаар тусгасныг төсвийн тодотголоор бууруулж тооцлоо.

Бусад тэвчиж болох арга хэмжээнд нийт 5.9 тэрбум төгрөгийг тооцож төсвийн тодотголд тусгав.

Гурав. Төсвийн зарлагад хийх зохицуулалтууд

1. Монгол Улсын 2015 оны төсөвт төрийн өмчийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авах эм, урвалж, эмнэлгийн хэрэгслийн зардлыг төвлөрүүлэн нэгдсэн худалдан авалт хийхээр төлөвлөсөн. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын зардлыг буцаан хуваарилахад хүндрэл гарахаар байгаа тул Эрүүл мэнд, спортын яамны саналын дагуу нийт 2.5 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг сумын эрүүл мэндийн төвүүдийн төсөвт буцаан тусгахаар тооцон зохих өөрчлөлтийг орон нутгийн тусгай зориулалтын шилжүүлгийн зардалд тусгав.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг үндэслэн Хавдар судлалын үндэсний төвийн төлбөртэй тусламж үйлчилгээний орлогыг 350 сая төгрөгөөр нэмэгдүүлж, байгууллагын хөтөлбөр төслийн дотоод урсгал зардлыг нэмж санхүүжүүлэхээр тусгав.

3. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг үндэслэн хуульд заасны дагуу өөрийн орлого төвлөрүүлсний үндсэн дээр зарлагаа санхүүжүүлдэг зарим сангууд, тухайлбал, Зэвсэгт хүчний хөгжлийн сан 5.0 тэрбум төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 5.0 тэрбум төгрөгөөр тус тус орлого, зарлагыг нэмэгдүүлж төсөлд тусгав.

4. Хууль зүйн яамны саналыг үндэслэн иргэний цахим үнэмлэх болон үндэсний энгийн гадаад паспортын бэлдэц бэлтгэхтэй холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын мэдээллийн маягт хэвлэх зардлыг 666.6 сая

төгрөгөөр, мөн хэмжээгээр төсөвт төвлөрүүлэх орлогыг тус тус нэмэгдүүлэхээр тооцов.

Урсгал зардлыг бууруулах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх чиглэлээр дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, нэгдсэн төсвийн 2015 оны урсгал зардалд тодотгол хийхтэй холбогдуулан нийт 25 хууль, УИХ-ын 3 тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тооцож хуулийн төслүүдийг боловсруулав.

2.3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТУХАЙ

Орон нутгийн төсвийн хувь хүний орлогын албан татварын орлогыг 23.6 тэрбум төгрөгөөр бууруулан тооцлоо.

Засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор аймгийн байгаль хамгаалах газар болон аймаг, нийслэлийн халамжийн сангийн зардал орон нутгийн суурь зардалд туссанаар 15.1 тэрбум төгрөгөөр буурч байна. Дээрх өөрчлөлтүүдээс хамааран орон нутагт олгох санхүүгийн дэмжлэг 5.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж нийт 166.3 тэрбум төгрөг болж, аймгуудын суурь орлого, суурь зарлагын зөрүүгээс орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан (ОНХНС)-д төвлөрүүлэх орлого 6.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 21.6 тэрбум төгрөг боллоо.

Мөн бүтцийн өөрчлөлт болон зарим зохицуулалттай холбоотойгоор орон нутагт олгох тусгай зориулалтын шилжүүлэг 2.1 тэрбум төгрөгөөр буурч нийт 937.6 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

Аймгуудын ОНХНС-д төвлөрүүлэх орлого нэмэгдсэн боловч ОНХНС-ийн эх үүсвэр болох дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ батлагдсанаас 67.6 тэрбум төгрөгөөр буурч 72.8 тэрбум төгрөг болсон, газрын тосны НӨАТ 2.3 тэрбум төгрөгөөр буурч 11.3 тэрбум төгрөг болсон, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 11.2 тэрбум төгрөгөөр буурч 21.3 тэрбум төгрөг болсон зэргээс шалтгаалан ОНХНС-аас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг нийт 74.9 тэрбум төгрөгөөр буурч 127.0 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

2.4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТУХАЙ

Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуулиар сангийн орлогыг 1,452.6 тэрбум төгрөгөөр баталсныг 72.6 тэрбум төгрөгөөр бууруулан 1,380.0 тэрбум төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа. Үүнд:

1. Нийгмийн даатгалын 2014 оны орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлтэй уялдуулан аж ахуйн нэгж байгууллага, даатгуулагчаас төлөх шимтгэлийг 59.3 тэрбум төгрөгөөр бууруулсан;
2. Засгийн газраас боловсруулсан бүтцийн өөрчлөлтөөр болон 2015 онд төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхгүй байх чиглэлийг баримтлан цалингийн сангийн зардлыг бууруулж буйтай холбогдуулан төсөвт байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг 13.3 тэрбум төгрөгөөр;
3. Төсвийн орлогын төлөвлөгөө их хэмжээгээр тасарч буйтай холбогдуулан улсын төсвөөс нийгмийн даатгалын санд олгох татаасыг 11.5 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж тооцов.

Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагыг 1,485.0 тэрбум төгрөгөөр баталсныг 94.9 тэрбум төгрөгөөр бууруулан 1,390.1 тэрбум төгрөгөөр төсвийн тодотголд тусгаж байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны, цэргийн, тэжээгчээ алдсаны, тахир дугуугийн болон ҮОМШӨ-ний тэтгэврийг 2015 онд индексжүүлэн нэмэгдүүлэхээр тооцож 94.7 тэрбум төгрөг тусгаад байсныг 2015 онд цалин, тэтгэвэр нэмэгдүүлэхгүй байх чиглэл баримтлан 2015 оны төсвийн тодотголд дээрх дүнгээр бууруулан тооцов.
2. Засгийн газрын тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг 85 байсныг 72 болгон шинэчлэн баталсантай холбоотойгоор 13 орон тоог бууруулж цалингийн санг 121.6 сая төгрөгөөр бууруулан, тэтгэмжийн зардалд 50.3 сая төгрөгийг нэмж тусгалаа.
3. Нийгмийн даатгалын байцаагчийг тусгайлан дүрэмт хувцас өмсөх шаардлагагүй гэж үзэн Нийгмийн даатгалын тухай хуульд холбогдох өөрчлөлтийг оруулах замаар сангийн үйл ажиллагааны зардлыг 96.0 сая төгрөгөөр бууруулж байна.

2.5. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТУХАЙ

Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тодотголоор дараах асуудлуудыг шийдвэрлүүлэхээр холбогдох хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төслүүдийг боловсрууллаа. Үүнд:

1. Хүний хөгжил сангийн орлого буурч, тус сангийн өр, төлбөр, зээлийн үйлчилгээний төлбөр нэмэгдэж байгаатай холбоотойгоор сангийн төсвийн тэнцлийг хангахын тулд хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлэх замаар зарлагыг 94.9 тэрбум төгрөгөөр бууруулах;
2. Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн орлогын бүрэлдэхүүн болох Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 70 хувиар Хүний хөгжил санд орох орлогыг 157.4 тэрбум төгрөгөөр бууруулах;
3. Хүний хөгжил санд төвлөрөхөөр тооцсон ногдол ашгийн орлогыг 30 тэрбум төгрөгөөр бууруулах;
4. “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2014 оны 65 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлэх нөхцөл бүрдүүлэх;
5. Тус сангийн орлого 2014, 2015 онд батлагдсан хэмжээнээс буурч байгаа тул Хүний хөгжил сангийн 2015 оны төсөвт 391.7 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас гаргах эрх авсны үндсэн дээр Хүний хөгжил сангийн төсөвт гаргасан 404.9 тэрбум төгрөгийн бондын үндсэн төлбөрийн зарим хэсгийг дахин санхүүжүүлэх.

2.6. ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ТӨСӨВТ ТУСГАХ ТАЛААР

Засгийн газраас 2010 оны 7 дугаар сард хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэгтэй, ашгийн төлөө, төрийн өмчит хуулийн этгээд болох Хөгжлийн банкнийг байгуулахаар шийдвэрлэснээс хойш тус банкны нийт актив хөрөнгө 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 5,169.52 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны эцсээс 1,903.38 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Засгийн газраас Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэхээр баталсан тогтоолын хүрээнд 2014 онд Чингис бондын эх үүсвэрээс авто зам, гудамж төсөл, УБ хотын суурь дэд бүтэц, Таван толгойн цахилгаан станц, Эгийн голын цахилгаан станц, шинэ төмөр зам төслүүдийг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлсэн бол Чингис хаан Боинг-767 онгоц, Дотоод арматур, төмрийн хүдрийн нойтон, Төрийн орон сууцны корпорацийн төсөл, ХАА, хөнгөн үйлдвэрийн 6 төсөл, Байшин үйлдвэрлэх комбинатын төсөл, Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төсөл зэрэг төслүүдийг төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлээр санхүүжүүлсэн байна.

Харин Хөгжлийн банкны өөрийн эх үүсвэрээс энэ онд авто зам, суурь дэд бүтэц, 6% орон сууцны зээл, ТЭЦ-3, ТЭЦ-4 өргөжүүлэх төсөл, шинэ төмөр зам, ЖДҮ хөгжүүлэх сан, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төслүүдийг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн. Таван толгой-гашуунсухайтын нүүрсний экспортын авто зам, Багануур ХК, геологийн төв лаборатори, Кью Эс Си ХХК-ий төсөл зэрэг төслүүдийг төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн.

Хүснэгт. Нийт олгосон зээл /сая төгрөгөөр/

Төслийн нэр	2012	2013	2014
Чингис бонд	-	1,211,004.5	637,052.6
Улсын төсвөөс эргэн төлөгдөх		736,393.4	405,468.9
Төслийн орлогоос эргэн төлөгдөх		474,611.1	231,583.7
Хөгжлийн банкны өөрийн эх үүсвэр	488,357.1	456,281.4	703,466.97
Улсын төсвөөс эргэн төлөгдөх	257,774.0	291,931.1	209,289.28
Төслийн орлогоос эргэн төлөгдөх	230,583.1	164,287.3	494,177.68
Нийт	488,357.1	1,667,222.9	1,340,519.6

2014 оны нийт зээлийн багцын 46 хувь буюу 615.7 тэрбум төгрөгийн зээл нь улсын төсвийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй, 54 хувь буюу 725.7 тэрбум төгрөгийн зээл төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй байна.

Хүснэгт. Хөгжлийн банкны өөрийн эх үүсвэр

Эх үүсвэр	Гадаад валютаарх эх үүсвэрийн хэмжээ	Төгрөгийн эх үүсвэрийн хэмжээ
Дүрмийн сан		143.8 тэрбум төгрөг
Дотоодод гаргасан үнэт цаас		170.6 тэрбум төгрөг
Дунд хугацааны евро өрийн бичиг	580.0 сая ам.доллар	
Самурай өрийн бичиг	290 сая ам.доллар	
Комерц банкны эх үүсвэр	13.5 сая евро	
Хятадын хөгжлийн банкны эх үүсвэр	162.0 сая ам.доллар	

Кредит свисс банкны эх үүсвэр	320.0 сая ам.доллар	
Нийт	1,368.5 сая ам доллар	~2,640.8 тэрбум төгрөг

Төсвөөс гадуурх зарцуулалтыг төсөвт бүрэн тусгах асуудлыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын 2012 оны 28/20 дугаар зөвлөмж, 2014 оны 19/10 дугаар зөвлөмж, Олон улсын валютын сан болон Дэлхийн банкнаас өгсөн зөвлөмжүүд, манай улсын зээлжих зэрэглэлийг тогтоодог Мүүдийс, Стандарт Пүүрс, Фитч агентлагуудын тайланд удаа дараа хөндөж тавьсан. Энэ хүрээнд төсвийн тодотголын хуулийн төслийн хамт Хөгжлийн банк болон бусад эх үүсвэрээс төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн төслийн зарцуулалтыг нэгдсэн төсөвт тусган тооцох шилжилтийн хуулийн төслийг боловсруулаад байна.

Хөгжлийн банк болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийн санхүүжилтийг нэгдсэн төсөвт оруулан тооцоход Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг түр хугацаанд өөрчлөн мөрдүүлэх шаардлага бий болж байна. Үүний дагуу хуулийн төслийг боловсруулахдаа төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Хөгжлийн банк болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хязгаар 2015 онд ДНБ-ний 3 хувь, 2016 онд ДНБ-ний 2 хувь, 2017 онд ДНБ-ний 1 хувьтай тэнцэж байхаар хуулийн төсөлд тусгасан. Нэгдсэн төсвийн алдагдал ДНБ-ий 2 хувиас хэтрэхгүй байх хуулийн зохицуулалт Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд бий. Ингэснээр төсвийн гадуурх зарцуулалтыг нэгдсэн төсөвт оруулан тооцсон нийт алдагдал нь ДНБ-ий 2015 онд 5 хувь, 2016 онд 4 хувь, 2017 онд 3 хувь, 2018 оноос эхлэн 2 хувь тус тус байхаар байна.

Төсвөөс гадуурх нийт зарцуулалт буюу Хөгжлийн банк өөрийн эх үүсвэрийн улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлд болон Чингис бондын эх үүсвэрээс санхүүжүүлэх дээд хязгаар 2015 онд 719.6 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Энэ нь макро эдийн засаг болон төлбөрийн тэнцлийн зохистой харьцааг хадгалах чиглэлээр хийсэн тооцоо, судалгааны үндсэн дээр боловсруулсан дүн болно. Засгийн газраас Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэхээр 1,008.7 тэрбум төгрөг болон 450 сая ам.долларын тогтоол баталснаас Хөгжлийн банк 1,008.7 тэрбум төгрөг болон 423 сая ам.долларын гэрээ байгуулаад байна. Иймд Засгийн газар 2015 онд Хөгжлийн банкаар санхүүжүүлэхээр нэмж тогтоол гаргахгүй юм.

Хөгжлийн банк 2017 онд Чингис бондын 500 сая ам.долларыг Засгийн газарт, 2018 онд 580 сая ам.долларыг гадаад талд төлөх үүрэг хүлээж байгаа тул 2015-2017 оны хооронд гаднаас татах эх үүсвэрийг жил бүр 600 сая ам.доллараас буулгахгүй байх чиглэл баримталж байна.

Хөгжлийн банк 2014 оны 12 дугаар сарын байдлаар 1,692.6 тэрбум төгрөгийн үлдэгдэл эх үүсвэртэй байгаа бөгөөд 2015 онд 719.6 тэрбум хүртэлх төгрөгийг төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлд зарцуулна гэж тооцвол дээрх хэмжээ нь одоо байгаа эх үүсвэр болон ирэх онд орж ирэх эх үүсвэрийн 26 хувийг эзлэхээр байна.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулиар Хөгжлийн банкаар санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээг 195.6 тэрбум төгрөгөөр баталсан. Иймд дээрх дүнгээс гадна 524.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Чингис бонд болон Хөгжлийн банкны өөрийн эх үүсвэрээс улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгалаа.

2.7. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО, СТРАТЕГИЙН ТУХАЙ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тодорхойлолтын дагуу улсын өрийн үлдэгдлийг өнөөгийн үнэ цэнээр тооцоход 2014 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 11,483.5 тэрбум төгрөгтэй тэнцэхээр байгаа нь ДНБ-ий 53.0 хувьтай дүйцэж байгаа ба Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан 40 хувийн өрийн хязгаарын түвшнээс хэтрэхээр байна.

Улсын өрийн хэмжээ ийнхүү хэтэрсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Засгийн газар томоохон хэмжээний гадаад бонд гаргах замаар хөгжлийн томоохон төслийг санхүүжүүлэх бодлогын дагуу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд улсын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг 2012 онд 60 хувь, 2013 онд 50 хувь байхаар тусган баталсан. Гэвч энэхүү санхүүжилтийг хэрэглэх хугацаа хойшилсон нь улсын өрийн үзүүлэлтийг хуульд заасан хэмжээнд барихгүй байхад нөлөөлсөн.
2. 2012 оноос эхэлсэн дотоод болон гадаад эдийн засгийн хүндрэлийн улмаас төсвийн орлого их хэмжээгээр тасалдаж, төсвийн зарлагыг дотоод бонд гаргах замаар санхүүжүүлж ирсэн байна. Үүний улмаас эдгээр дотоод бондын эргэн төлөлт нь ирэх онуудын төсөвт нэмэлт дарамт болохоор байна. Тухайлбал, урьд онуудад төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор гаргасан дотоод үнэт цаасны эргэн төлөлт болон 2015 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулж улсын төсөвт 2.1 их наяд төгрөгийн, Хүний хөгжил санд 0.4 их наяд төгрөгийн, нийт 2.5 их наяд төгрөгийн үнэт цаас гаргах хэрэгцээ байна. 2015 онд үндсэн төлбөрт 1.9 их наяд, хүүгийн төлбөрт 385.4 тэрбум төгрөг, 2016 онд үндсэн төлбөрт 2.1 их наяд, хүүгийн төлбөрт 407.7 тэрбум төгрөг тус тус төлөгдөхөөр байгаа юм. Өөрөөр хэлбэл, ирэх хоёр жилд төлөх өрийн үйлчилгээний төлбөрийг дахин санхүүжүүлэхэд их хэмжээний төгрөгийн эх үүсвэр шаардлагатай бол 2017, 2018, 2022 онуудад гадаад төлөх гадаад бондуудад ам.долларын хэрэгцээ их хэмжээгээр шаардагдахаар байна.
3. Валютын ханшны тогтворгүй байдал үүсэж, төгрөгийн ам.доллартай харьцах ханш эрчимтэй суларснаас шалтгаалж гадаад валютаарх өрийн үлдэгдлийн төгрөгөөр тооцсон хэмжээ эрс нэмэгдсэн.

Өнөөгийн байдлаар Улсын өрийн удирдлагад тулгамдсан дараах асуудлуудыг шийдвэрлэх бодлого, арга замыг нэн яаралтай тодорхой болгох шаардлага тулгараад байна. Үүнд:

- 1) ТТБТХ-аар тогтоосон улсын өрийн хязгаар зөрчигдсөн байгааг хуульд нийцүүлэх, арга зам, бодлогыг тодорхойлох;
- 2) 2017, 2018, 2022 онуудад төлөгдөх их хэмжээний гадаад бондын үндсэн төлбөрийг санхүүжүүлэх арга зам, хэрэгслийг тодорхой болгох, шаардагдах арга хэмжээг авч эхлэх;
- 3) Төсвийн орлого, зарлагын тэнцвэртэй байдлыг хангах замаар Засгийн газрын дотоод үнэт цаасны хэрэгцээг бууруулах;
- 4) Улсын хөгжлийн хэрэгцээг хангах, хөгжлийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх бодлого, арга замыг тодорхойлох, Засгийн газрын оролцоо болон дэмжлэгийн бодлогыг тодорхой болгох;
- 5) Төлбөрийн тэнцэл, валютын нөөцийн байдлыг сайжруулах бүтцийн шинж чанартай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэхдээ дараах хүчин зүйлсийг давхар харгалзан үзэх нь зүйтэй байна. Үүнд:

- 1) **Төсвийн бодлогод хийх бүтцийн тохируулгын сөрөг нөлөөг боломжит доод түвшинд байлгах.** Өөрөөр хэлбэл, төсвийн зарлагыг бууруулах арга хэмжээг хэт хурдацтай хийж эдийн засгийг ширгээж, агшаах хэмжээнд хийхгүй байх нь зүйтэй байна. Тухайлбал, Монгол Улсын 2015 оны төсвийг анх баталсан түвшинд бүрэн хэрэгжүүлбэл нийт 3.5 их наяд төгрөгийн дотоод бонд гаргах (нэгдсэн төсвийн орлогын дутагдалд 1.0 их наяд төгрөг, Хүний хөгжил сангийн өрийн дахин санхүүжилтэд 0.4 их наяд төгрөг, улсын төсвийн өрийн дахин санхүүжилт болон бусад санхүүжилтийн хэрэгцээнд 2.1 их наяд төгрөг) хэрэгцээ гарахаар байсан. Улсын өрийн хэмжээг ТТБТХ-д заасан хэмжээнд хүргэх зорилгоор энэ хэмжээний үнэт цаасыг гаргахгүй баривал төсвийн нийт зарлагыг нэг жилийн дотор 50 хувиар бууруулах шаардлага бий болно. Энэ нь эдийн засаг, нийгэмд маш сөрөг нөлөө үзүүлэх тул төсөвт хийх тохируулгыг боломжит түвшинд хийх зорилгоор 2015-2017 онд төсвийн алдагдлын тодорхой хэсгийг үнэт цаас гаргах замаар санхүүжүүлэх нь зүйтэй байна.
- 2) **Засгийн газрын дотоод бондын нийт үлдэгдлийг зохистой хэмжээнд хүртэл бууруулах.** Засгийн газрын дотоод үнэт цаасны хөрөнгө оруулагчийн дийлэнх хувийг дотоодын арилжааны банкнууд эзэлдэг. Тухайлбал, 2014 онд арилжаалсан нийт үнэт цаасны 84.6 хувийг арилжааны банкнууд худалдан авсан бол 2013 онд 96.6 хувийг эзэлж байжээ. Цаашид санхүү, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, Монголбанкны баримталж буй мөнгөний бодлогоос шалтгаалж ирэх онуудад төсвийн алдагдлыг санхүүжүүлэх ЗГҮЦ-ны арилжаалагдах боломжит хэмжээ нь төсвийн батлагдсан хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй байна. Нөгөө талаас хувийн хэвшилд олгох зээлийг шахах үзэгдлийг багасгах үүднээс Засгийн газрын бондын хэмжээг хязгаарлах зайлшгүй шаардлага бий болж байна.
- 3) Гадаад валютаар хийх төлбөрийн эрсдлийг бууруулах зорилгоор валютын нөөцийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох бодлогыг хэрэгжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг багасгахад дэмжлэг болох төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэх шаардлагын улмаас нэмж гадаад валютын зээллэг үүсгэхээс сэргийлэх.
- 4) Макро эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах, зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэх.

Цаашид Улсын өрийн хэмжээг зохистой түвшинд хүргэх, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан хэмжээнд хүргэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Засгийн газар хөрөнгө оруулалтын зориулалтаар арилжааны нөхцөлтэй гадаад зээллэг хийхгүй байх;
2. Гадаад орон, олон улсын байгууллагаас авах боломжтой хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг тэргүүн ээлжид авч ашиглах, төслийн хэрэгжилтийг түргэсгэх, боломжит эх үүсвэрийг бүрэн ашиглах, эдгээр эх үүсвэрийг аль болох эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн төслүүдэд чиглүүлэх;
3. Засгийн газрын дотоод бондын үлдэгдлийг тогтмол бууруулж зохистой хэмжээнд хүргэх, төсвийн төлөвлөлтийг бодитой болгох замаар төсвийн алдагдлыг санхүүжүүлэх дотоод бондын хэрэгцээг багасгах;

4. Зөвхөн ойрын жилүүдэд төлөгдөх гадаад бондуудын төлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд шаардагдаж болзошгүй хэмжээнд арилжааны гадаад зээллэг хийх, энэ хэрэгцээг хамгийн бага түвшинд байлгах;
5. Улсын хөгжлийг дэмжих арилжааны томоохон төслүүдийг дэмжих зохистой механизмыг бий болгож, Засгийн газрын санхүүжилт, шууд оролцоог хязгаарлах;
6. Шинээр өр үүсгэхдээ Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрийн төсвийн орлого, зарлагад эзлэх хувь хэмжээг зохистой түвшинд барих, санхүүжилтийн хэрэгцээг боломжит эрсдлийн түвшинд, хамгийн бага зардлаар санхүүжүүлэх, үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацааны хувьд жигд тарааж нэг жилд ирэх ачааллыг бага байлгах.

2017, 2018, 2022 онуудад төлөгдөх их хэмжээний гадаад бондын үндсэн төлбөрийг санхүүжүүлэх арга зам, хэрэгслийг тодорхой болгох, шаардагдах арга хэмжээг авч эхлэх хүрээнд:

1. Нэг жилд их хэмжээний төлбөр ногдож байгааг тархаах, хүүгийн дарамтыг багасгах зорилгоор зарим төслүүдийг хөнгөлөлттэй зээлээр дахин санхүүжүүлэх;
2. Бондын төлбөрийг хийх зориулалттай сан /sinking fund/ байгуулах;
3. Тодорхой хэсгийг дахин арилжааны зээл авч санхүүжүүлж болзошгүйг харгалзан макро нөхцөл байдал, зээлжих зэрэглэлийг сайжруулах, бэлтгэл ажлыг хангах;
4. Валютын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

Дээр дурдсан нөхцөл байдал, хүчин зүйлс, бодлого чиглэлийг харгалзан үзэж “ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН ДУНД ХУГАЦАА /2015-2018/-НЫ СТРАТЕГИ, ӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”-г дараах бүрэлдэхүүн хэсэгтэйгээр боловсруулан танилцуулж, батлуулахаар ажиллаж байна. Үүнд:

1. Улсын өрийн өнөөгийн нөхцөл байдал;
2. Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратеги дахь өрийн багцын зардал, эрсдлийн шинжилгээ;
3. Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн бодлогын хувилбар, харьцуулсан шинжилгээ, симуляци;
4. Засгийн газрын өрийн удирдлагын бодлогын сонголт;
5. Засгийн газрын өрийн үйлчилгээний цогц төлөвлөгөө /2015-2022 оныг хамрах/.

Эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, улсын болон хувийн хэвшлийн гадаад өрийн үйлчилгээний цаашдын төлөв, төлбөрийн тэнцлийн байдал зэргийг харгалзан үзэхэд дан ганц Засгийн газрын өрийн удирдлагын стратегийг боловсруулах нь хангалттай биш юм. Иймд Монголбанкттай хамтран Монгол улсын өрийн удирдлагын нэгдсэн стратегийг боловсруулан ажиллаж, “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн тухай УИХ-ын 2014 оны 69 дүгээр тогтоолд заасны дагуу Засгийн газрын өрийн удирдлагын стратеги, өрийн үйлчилгээний цогц төлөвлөгөөг боловсруулж, 2015 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна.

Түүнчлэн, Засгийн газрын өрийн удирдлагын нэгдсэн тогтолцоог бий болгох үүднээс өр үүсгэхээс эргэн төлөгдөх хүртэлх бүх харилцааг нарийвчлан зохицуулсан, өрийн төлөвлөлт, хяналт, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сайжруулах Өрийн

удирдлагын тухай хуулийг ойрын хугацаанд Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулах нь зүйтэй байна.

2.8. ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

Монгол Улсын 2015 оны төсвийн тодотголын дээр дурдсан өөрчлөлтүүдийг тусгахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 905.6 тэрбум төгрөгөөр буурч 6,254.3 тэрбум төгрөг болж, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төсөл, арга хэмжээний нийт дүнг төсөвт тусгасантай холбоотойгоор нэгдсэн төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүн 186.0 тэрбум төгрөгөөр бууран 7,413.2 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн нийт алдагдал 1,158.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 4.8 хувьтай тэнцэж байна.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН 2015 ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ ДАГАЛДАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“30.2.Энэ хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчид үндсэн цалингийн дунджаас нь тооцож нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.”

2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “түүний орлогч,” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.13 дахь хэсгийн “Төрийн албаны төв байгууллага нь дэргэдээ сургалт, судалгааны болон зөвлөх үйлчилгээний нэгжтэй байж болно” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.Агентлаг нэгээс илүүгүй орлогч даргатай байна. Агентлагийн орлогч даргыг Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг харгалзан Монгол Улсын сайд томилж, чөлөөлнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "өөрийн ажлын хэсэг," гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ,
ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг:

“20.3.Хурлын Тэргүүлэгчид ажлын албатай байх бөгөөд түүний орон тоо, цалингийн санг Төсвийн тухай хуулийн 10.1.2-т заасан тухайн жилийн төсвийн хязгаарт багтаан Тэргүүлэгчид өөрөө тогтооно.”

2/30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт:

“30.1.2.аймгийн Засаг дарга нь нэгээс илүүгүй, нийслэлийн Засаг дарга нь хоёроос илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх;”

3/31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт:

“31.1.2.сум, дүүргийн Засаг дарга нь нэгээс илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх; ”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цагдаагийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.2.Цагдаагийн төв байгууллага нь дэмжлэг үзүүлэх асуудал эрхэлсэн дэд даргатай байна.”

2 дугаар зүйл. Цагдаагийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 18.2, 18.3-т заасан тэргүүн дэд дарга, дэд даргыг” гэснийг “Цагдаагийн төв байгууллагын дэд даргыг” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Цагдаагийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтын “тэргүүн дэд комиссар,” гэснийг, мөн зүйлийн 34.2 дахь хэсгийн “тэргүүн дэд комиссар цолыг цагдаагийн төв байгууллагын тэргүүн дэд даргад,” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Цагдаагийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАХАРЫН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тахарын албаны тухай хуулийн зарим хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг:

“25.1.Тахарын албаны төв байгууллага нь дарга, дэд даргатай байна.”

2/25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг:

“25.3.Тахарын албаны төв байгууллагын дарга нь тэргүүн тахар, дэд дарга нь шадар тахар, тойргийн тахарын албаны дарга нь тойргийн тахар, нэгжийн дарга нь тахар цолтой байна.”

2/25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэг:

“25.5.Тэргүүн тахар, шадар тахар цолыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тойргийн тахар, тахар цолыг тэргүүн тахар тус тус олгоно.”

3/27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг:

“27.2.Шадар тахарыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тойргийн тахар, тахарыг тэргүүн тахар томилж чөлөөлнө.”

4/27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг:

“27.3.Тэргүүн тахар, шадар тахар, тойргийн тахар, тахард нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна:”

2 дугаар зүйл. Тахарын албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.2 дахь заалтын “Тэргүүн шадар тахар,” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэг, 27.3.3 дахь заалтын “Тойргийн шадар тахар,” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Тахарын албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.Үндэсний статистикийн хороо Дэд даргатай байна. Дэд даргыг Үндэсний статистикийн хорооны дарга томилно.”

2 дугаар зүйл. Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Тэргүүн дэд болон” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.5.5 дахь заалт:

“6.5.5.Олон улсын хамтын ажиллагааны сан.”

2/9¹ дүгээр зүйлийн 9¹.3.3 дахь заалт:

“9¹.3.3.төсвийн гол нэр төрлийн эрдэс баялгийн зах зээлийн үнэ төсөвт тусгагдсан тэнцвэржүүлсэн үнээс буурсан болон гол нэр төрлийн эрдэс баялгийн экспортын биет хэмжээ төсөвт тусгагдсан биет хэмжээнээс 20 хувиар буурсан тохиолдолд тэрхүү үнэ болон биет хэмжээ нь төлөвлөснөөс буурсан гол нэр төрлийн эрдэс баялгийн төсвийн тогтворжуулалтын санд өмнө хуримтлагдсан хөрөнгөөс зөвхөн тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүссэн төсвийн орлогын тасалдлыг.”

3/25¹ дүгээр зүйлийн 25¹.2.9 дэх заалт:

“25¹.2.9.зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний нормын хувцас, хэрэгсэл, сургалт, дадлагын зардлыг санхүүжүүлэх.”

2 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9¹ дүгээр зүйлийн 9¹.3.1 дэх заалт:

“9¹.3.1.урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурч төсвийн алдагдал батлагдсан хэмжээнээс дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувиар нэмж буурсан тохиолдолд үнэ болон биет хэмжээ нь төлөвлөснөөс буурсан гол нэр төрлийн эрдэс баялгийн төсвийн тогтворжуулалтын санд өмнө

хуримтлагдсан хөрөнгөөс зөвхөн тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүссэн төсвийн орлогын тасалдлыг;

2/17¹ дугаар зүйлийн 17¹.1 дэх хэсэг:

“17¹.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь өмнөх онд төвлөрүүлсэн орлого, санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл болон жилийн эцсийн үлдэгдлийг харгалзан Олон улсын хамтын ажиллагааны сангийн хөрөнгийн хэмжээг тооцож төлөвлөнө.”

3/26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг:

“26.3.Энэ хуулийн 6.4-т заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргах бөгөөд энэ хуулийн 6.4.6, 6.4.10-т зааснаас бусад тусгай санд зориулан ажлын алба байгуулж, санхүүжүүлэхийг хориглоно.”

4/26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг:

“26.6.Энэ хуулийн 5.4.3-т заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах журмыг Засгийн газар батална.”

5/29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалт:

“29.1.1.энэ хуулийн 5.4.2, 5.4.4, 5.4.6, 5.4.8, 5.4.12-5.4.14, 5.4.16, 5.4.20, 5.4.25, 5.4.29, 5.4.30, 5.4.32, 5.4.33-т заасан тусгай сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг мөн хуулийн 26.3-т заасан этгээдийн шийдвэрээр;”

3 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1, 5.4.5, 5.4.17, 5.4.19, 5.4.21-5.4.23, 5.4.26, 5.4.31, 5.4.34, 5.4.35 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2.9, 6.4.1, 6.4.3, 6.4.8, 6.4.9, 6.4.11, 6.4.14, 6.4.17, 6.4.18, 6.4.20, 6.5.4 дэх заалт, 11-13, 15, 18, 19, 21, 21¹, 21², 21⁴, 21⁵, 21⁶, 25, 25² дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.2, 30.7 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИННОВАЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Инновацийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10.3 дахь заалтын “Инновацийн санд” гэснийг “улсын төсөвт” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Инновацийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2, 17.1.9, 17.1.10 дахь заалтын “Инновацийн сангаас” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Инновацийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орон сууцны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Орон сууц хөгжүүлэх сан,” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Орон сууцны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16 дахь заалт, 11.2, 11.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2 дахь заалтын “Сэргээгдэх эрчим хүчний сангаас” гэснийг “Засгийн газраас” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтын “газрын тосны салбарыг хөгжүүлэх сан” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.2.Энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан одон бүхий 18 хүртэлх насны хүүхэдтэй эхэд хуульд заасны дагуу мөнгөн тэтгэмж олгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйлийн 13.5.3 дахь заалт:

“13.5.3.хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;”

2/13 дугаар зүйлийн 13.5.4 дэх заалт:

“13.5.4.нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх;”

3/13 дугаар зүйлийн 13.5.9 дэх заалт:

“13.5.9.”Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одон, эсхүл “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одон бүхий 18 хүртлэх насны хүүхэдтэй эхэд мөнгөн тусламж давхардуулахгүйгээр.”

4/13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг:

“13.7.Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн эхэд хүүхдээ төрүүлсэн сараас эхлэн 7 сарын хугацаанд, бусад эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд тус тус сар бүр олгоно.”

5/29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг:

“29.2.Энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журмыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 43.7 дахь хэсэг нэмсүгэй:

“43.7.Энэ хуулийн 43.1.4, 43.5-д заасан нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан журмыг баримтлан тогтооно.”

2 дугаар зүйл. Боловсролын тухай хуулийн зарим хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/43 дугаар зүйлийн 43.1.4 дэх заалт:

“43.1.4.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 43.1.2-т заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил, үүнээс сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход түүний үндсэн цалингаас нь тооцож нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох; ”

2/43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсэг:

“43.5.Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 3.1.15-д заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил, сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход түүний үндсэн цалингийн дунджаас нь тооцож нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас олгох бөгөөд шаардагдах зардлыг нь тухайн жилийн төсөвт тусгана.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.1.4.байгаль орчин, хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь хянан шалгах үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хөдөлмөр хамгааллын хувцас болон техник хэрэгслээр хангагдах;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ
ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 26¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.1.6.энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан нөхцөл, шалгуурын аль нэгийг хангасан агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд үзүүлэх урамшууллын хэлбэр, хувь хэмжээг тогтоох, урамшууллыг улсын төсвөөс санхүүжүүлэх;”

2 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

Тогтоолын заалт хүчингүй болгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1 дүгээр зүйл. “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 1 дэх дэд заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ тогтоолыг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “30 хувь” гэснийг “15 хувь” гэж, “55 хувь” гэснийг “35 хувь” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ
ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ
ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Прокурорын байгууллагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зарим хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Цэргийн албан хаагч эрэгтэй 25-аас доошгүй, эмэгтэй 20-оос доошгүй жил алба хаагаад цэргийн алба хаасны тэтгэвэрт гарахад түүнд үндсэн цалингаас нь тооцож нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийг Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан журмын дагуу олгоно.”

2/19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Цэргийн албан хаагчийн нэг удаагийн тэтгэмжийн 50 хүртэл хувьтай тэнцэх хэсгийг цэргийн алба хаасны тэтгэвэр авах эрх үүссэнээс хойш үргэлжлүүлэн алба хааж байгаа офицер, ахлагчид өөрийн нь хүссэнээр цэргийн албанаас чөлөөлөгдөхөөс өмнө урьдчилан олгож болно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 279 дүгээр зүйлийн 279.5 дахь хэсгийн “харьяа газрын орлогч дарга,” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 282 дугаар зүйлийн 282.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“29.2.Төрийн өмчийн эрүүл мэндийн болон боловсролын байгууллагад 25 ба түүнээс дээш жил, өрхийн эрүүл мэндийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтан тэтгэвэрт гарахад нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндсэн цалингийн дунджаас тооцуулан ажиллаж байгаа байгууллагаасаа авах эрхтэй. Нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан журмыг баримтлан тогтооно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот


**ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Өрсөлдөөний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ**



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсантай холбоотойгоор төсвийн зарим байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн орлого буурахаар байна.

Төсвийн тухай хуулийн 6.2.3-т “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлнэ” гэж, 34.1.4-т Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх тохиолдолд тодотголын төслийг боловсруулна гэж заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хууль зүйн шаардлагыг бий болгож байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь нийт 2 зүйлтэй байна.

Нэгдүгээр зүйлд: Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан орлогын хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарлагын хэмжээг тус тус өөрчилнө.

Хоёрдугаар зүйлд: Хууль дагаж мөрдөх хугацааг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар 2015 оны Нийгмийн даатгалын санд мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хуваарилж, зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох хуулийн талаархи санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр хууль, тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... сарын ...ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн 3, 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/3 дугаар зүйл:

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын санд 2015 оны төсвийн жилд Төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	1,380,010.7
	1.1 Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	558,449.0
	1.2 Ажиллагсдаас төлөх шимтгэл	577,122.2
	1.3 Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	161,418.7
	1.4 Нөхөн олговор авагчийн нийгмийн даатгалын шимтгэл	0.6
	1.5 Хүний хөгжил сангаас төлөх иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэл	12,040.2
	1.6 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	37,570.3
	1.7 Эрүүл мэндийн даатгалын бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	4,654.1
	1.8 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	1,800.0
	1.9 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	1,101.7
	1.10 Бусад орлого	25,853.9
2	Сангийн сайд	308,643.8
	2.1 Улсын төсвөөс олгох санхүүгий дэмжлэг	308,643.8
Нийт орлого		1,688,654.6

2/4 дүгээр зүйл:

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд 1.1 Тэтгэврийн даатгалын сан 1.2 Тэтгэмжийн даатгалын сан 1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан 1.4 Ажилгүйдлийн даатгалын сан 1.5 Эрүүл мэндийн даатгалын сан 1.6 Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны төлбөр 1.7 Үйл ажиллагааны урсгал зардал 1.8 Хөрөнгийн зардал	1,006,098.9 78,477.4 32,946.1 19,109.9 219,390.0 118.8 20,530.9 13,429.3
Нийт зарлага		1,390,101.3

2 дугаар зүйл: Энэ хуулийг 2015 оны ... дугаар сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуулиар сангийн орлогыг 1,452.6 тэрбум төгрөгөөр баталсныг 72.6 тэрбум төгрөгөөр бууруулан 1,380.0 тэрбум төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа. Үүнд:


1. Нийгмийн даатгалын 2014 оны орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлтэй уялдуулан аж ахуйн нэгж байгууллага, даатгуулагчаас төлөх шимтгэлийг 59.3 тэрбум төгрөгөөр бууруулсан;
2. Засгийн газраас боловсруулсан бүтцийн өөрчлөлтөөр болон 2015 онд төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхгүй байх чиглэлийг баримтлан цалингийн сангийн зардлыг бууруулж буйтай холбогдуулан төсөвт байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг 13.3 тэрбум төгрөгөөр;
3. Төсвийн орлогын төлөвлөгөө их хэмжээгээр тасарч буйтай холбогдуулан улсын төсвөөс нийгмийн даатгалын санд олгох татаасыг 11.5 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж тооцов.

Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагыг 1,485.0 тэрбум төгрөгөөр баталсныг 94.9 тэрбум төгрөгөөр бууруулан 1,390.1 тэрбум төгрөгөөр төсвийн тодотголд тусгаж байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны, цэргийн, тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн болон ҮОМШӨ-ний тэтгэврийг 2015 онд индексжүүлэн нэмэгдүүлэхээр тооцож 94.7 тэрбум төгрөг тусгаад байсныг 2015 онд цалин, тэтгэвэр нэмэгдүүлэхгүй байх чиглэл баримтлан 2015 оны төсвийн тодотголд дээрх дүнгээр бууруулан тооцов.
2. Засгийн газрын тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг 85 байсныг 72 болгон шинэчлэн баталсантай холбоотойгоор 13 орон тоог бууруулж цалингийн санг 121.6 сая төгрөгөөр бууруулан, тэтгэмжийн зардалд 50.3 сая төгрөгийг нэмж тусгалаа.
3. Нийгмийн даатгалын байцаагчийг тусгайлан дүрэмт хувцас өмсөх шаардлагагүй гэж үзэн Нийгмийн даатгалын тухай хуульд холбогдох өөрчлөлтийг оруулах замаар сангийн үйл ажиллагааны зардлыг 96.0 сая төгрөгөөр бууруулж байна.

--- о О о ---

**ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН
2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ**



**ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Засгийн газрын бүтцэд өөрчлөлт оруулсан нь Төсвийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтад төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх тохиолдолд төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их хуралд өргөн мэдүүлнэ гэж, 6.2.3-т урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлнэ гэж заасан нь Хүний хөгжил сангийн 2015 оны төсөвт тодотгол хийх хууль зүйн үндэслэл болж байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйлтэй байна.

1 дүгээр зүйлд: Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн 3, 4 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах тухай.

2 дугаар зүйлд: Хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөх хугацааг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хууль батлагдснаар Хүний хөгжил сангаас олгож байгаа Хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлэх замаар тус сангийн зарлагыг бууруулж, тус сангийн төсвийн тэнцлийг хангах, 2015 онд шинээр үүсгэх өрийн хэмжээг бууруулах боломж бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох хуулийн талаархи санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль, Монгол Улсын Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбоотойгоор Засгийн газрын үнэт цаас гаргах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож Улсын Их Хурлын тогтоолыг шинээр батлах шаардлагатай.

oOo

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... сар ... өдөр

Улаанбаатар хот

**ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн 3, 4 дүгээр зүйлийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйл:

“3 дугаар зүйл.Хүний хөгжил сангийн төсөвт 2015 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 338,864.6 сая төгрөгөөр, төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	298,864.6
	1.1.Татварын ерөнхий газар	298,864.6
	1.1.1.Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.2-т заасан орлого	298,864.6
2	Монгол Улсын Ерөнхий сайд	40,000.0
	2.1.Төрийн өмчийн хороо	40,000.0
	2.1.1.Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-д заасан орлого	40,000.0

2/ 4 дүгээр зүйл:

“4 дүгээр зүйл. Хүний хөгжил сангийн төсвөөс 2015 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 247,410.4 сая төгрөгөөр баталж, төсвийн ерөнхийлөн захирагч нарт дор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	168,130.9
	1.1.Төр хариуцан төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэл	12,040.2
	1.2.Хүүхдийн мөнгө	151,085.0
	1.3.Хөрөнгө оруулалт	5,005.7
2	Сангийн сайд	562,439,5
	2.1.Засгийн газрын бонд болон урьдчилгаа төлбөрийн хүүгийн зардал	79,279.5

2.2.Урьдчилгаа мөнгө, зээлийн үндсэн төлбөрт төлөгдөх цэвэр дүн	78,260.0
2.2.1.Нийт төлөх	167,800.0
2.2.2.Улсын төсвийн орлогод хаагдсан урьдчилгаа төлбөрийн дүнгээр улсын төсөвт өгөх өглөг	89,540.0
2.3.Засгийн газрын бондын үндсэн төлбөрт	404,900.0
2.4.Эрсдэлийн нөөц хөрөнгө	0.0

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Улсын Их Хурлаас ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор Хүний хөгжил сангийн тухай хуулийг баталсан.

Эдийн засгийн гадаад, дотоод нөхцөл байдлаас үүдэн Хүний хөгжил сангийн төсвийн орлого буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 70 хувиар ордог орлого 2013 оноос буурч 2015 онд сангийн нийт орлого 338.8 тэрбум төгрөг болохоор байгаагаас тус санд үүссэн өр, төлбөрүүдийг 2014, 2015 онд дахин санхүүжүүлэх шаардлага үүсэж байна. Тухайлбал зөвхөн 2015 онд Хүний хөгжил сангаас Засгийн газрын бондын төлбөр 404.9 тэрбум төгрөг, хүүгийн төлбөр 79.3 тэрбум төгрөгийг бэлэн мөнгөөр төлөхөөр байгаа нь тус сангийн төсөвт дарамт үзүүлэхээр байна.

Иймд Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тодотголоор дараах асуудлуудыг шийдвэрлүүлэхээр холбогдох хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төслүүдийг боловсрууллаа. Үүнд:

- Хүний хөгжил сангийн орлого буурч, тус сангийн өр, төлбөр, зээлийн үйлчилгээний төлбөр нэмэгдэж байгаатай холбоотойгоор сангийн төсвийн тэнцлийг хангахын тулд хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлэх замаар зарлагыг 94,915.0 сая төгрөгөөр бууруулах;

- Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн орлогын бүрэлдэхүүн болох Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 70 хувиар Хүний хөгжил санд орох орлогыг 157,429.9 сая төгрөгөөр бууруулах;

- Хүний хөгжил санд төвлөрөхөөр тооцсон ногдол ашгийн орлогыг 30 тэрбум төгрөгөөр бууруулах;

- “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2014 оны 65 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлэх нөхцөл бүрдүүлэх;

- Тус сангийн орлого 2014, 2015 онд батлагдсан хэмжээнээс буурч байгаа тул Хүний хөгжил сангийн 2015 оны төсөвт 391,705.8 сая төгрөгийн Засгийн газрын үнэт цаас гаргах эрх авсны үндсэн дээр Хүний хөгжил сангийн төсөвт гаргасан 404,900.0 сая төгрөгийн бондын үндсэн төлбөрийн зарим хэсгийг дахин санхүүжүүлэх зэрэг болно.

ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ ДАГАЛДАХ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

1. Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулга
2. Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулга

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2014 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг,
хувийн хэмжээг тогтоох тухай**

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Хүн ам, өрхийн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй, зорилтот бүлгийн хүүхэд бүрд 2015 онд сар бүр 20 000 /хорин мянга/ төгрөгийн хүүхдийн мөнгө олгохоор тогтоосугай.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан зорилтот бүлэгт хамрагдах Монгол Улсын иргэдийн жагсаалтыг холбогдох тооцоо, судалгаанд үндэслэн тогтоох эрхийг Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т олгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2014 оны 65 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолыг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

**ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГААС МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД 2015 ОНД ХҮРТЭЭХ ХИШИГ,
ХУВИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Энэ хуулийн 15.1-д зааснаар сангаас хишиг, хувь хүртээх хөрөнгийн хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална” гэж, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т Монгол Улсын иргэн хүүхдийн мөнгө хэлбэрээр хишиг, хувь хүртэж болохоор тус тус заасан.

Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тодотголоор 0-18 насны Монгол Улсын иргэн бүрд сар бүр олгодог 20 мянган төгрөгт зарцуулагдах хөрөнгийг нийгмийн халамж болон зарим нийгмийн шинжтэй хөтөлбөрүүдийг зорилтот бүлэгт чиглүүлэх бодлогын хүрээнд 94,915.0 сая төгрөгөөр бууруулахаар тусгасан. Үүнтэй холбогдуулан Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг шинэчлэн боловсруулж зорилтот бүлэгт хамрагдах иргэдийн жагсаалтыг холбогдох тооцоо, судалгаанд үндэслэн тогтоох эрхийг Засгийн газарт олгохоор тогтоолын төсөлд тусгалаа.

-----oO-----

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2014 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Засгийн газрын үнэт цаас
гаргахыг зөвшөөрөх тухай

Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах заалт, Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хүний хөгжил сангийн төсвийн цаг зуурын хүндрэлийг даван туулахад зориулан 391,705.8 сая төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг 2015 оны төсвийн жилд гаргаж, арилжаалахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

**ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХЫГ
ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Эдийн засгийн гадаад, дотоод нөхцөл байдлаас үүдэн Хүний хөгжил сангийн төсвийн орлого буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 70 хувиар ордог орлого 2013 оноос буурч 2015 онд сангийн нийт орлого 338.8 тэрбум төгрөг болохоор байгаагаас тус санд үүссэн өр, төлбөрүүдийг 2014, 2015 онд дахин санхүүжүүлэх шаардлага үүсэж байна. Тухайлбал зөвхөн 2015 онд Хүний хөгжил сангаас Засгийн газрын бондын төлбөр 404.9 тэрбум төгрөг, хүүгийн төлбөр 79.3 тэрбум төгрөгийг бэлэн мөнгөөр төлөхөөр байгаа нь тус сангийн төсөвт дарамт үзүүлэхээр байна.

Иймд Төсвийн тухай хууль болон Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу Засгийн газрын бонд гаргах замаар санхүүжилтийн эх үүсвэр төвлөрүүлснээр Хүний хөгжил санд өмнөх онуудад авсан өр, төлбөрийг гэрээний хугацаанд нь барагдуулж, сангийн цаашдын хэвийн үйл ажиллагааг хангах боломж бүрдэнэ.

-----oOo-----

**ТАВ. МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ
НЭГДСЭН ТӨСВИЙН ТООЦООЛЛЫН
ХАВСРАЛТУУД**

12/31/2014 10:52

/сая төгрөг/

	2015 төс									
	НЭГДСЭН ТӨСӨВ	УЛСЫН ТӨСӨВ				НДС	ХХС	ОРОН НУТАГ		
		НИЙТ	Төсвөөс санхүүжих	Төсвөөс эргэн төлөгдөх	Гадаадын зээл, тусламжаас санхүүжих			НИЙТ	Төсвөөс санхүүжих	Гадаадын зээл, тусламжаас санхүүжих
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,284,189.6	4,109,254.8								
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	29,858.5	29,858.5								
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,254,331.2	4,079,396.3	1,688,654.6	338,864.6	2,030,558.4	0.0	0.0			
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	6,190,443.1	3,851,637.7	1,380,010.7	338,864.6	793,389.5					
1. Татварын орлого	5,075,047.2	2,856,698.7	1,380,010.7	298,864.6	712,932.7					
1.1. Орлогын албан татвар	1,083,216.8	591,725.5	0.0	0.0	491,491.3					
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	491,491.3	0.0	0.0	0.0	491,491.3					
1.1.2 Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	591,725.5	591,725.5	0.0	0.0	0.0					
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1,206,551.2	0.0	1,380,010.7	0.0	0.0					
1.3. Өмчийн татвар	49,704.5	0.0	0.0	0.0	49,704.5					
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,253,975.4	1,253,975.4	0.0	0.0	0.0					
1.5. Онцгой албан татвар	393,160.5	393,160.5	0.0	0.0	0.0					
1.6. Тусгай зориулалтын орлого	44,630.0	11,591.3	0.0	0.0	33,038.7					
1.7. Гаалийн албан татвар	376,511.1	376,511.1	0.0	0.0	0.0					
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	667,297.6	229,734.9	0.0	298,864.6	138,698.1					
2. Татварын бус орлого	1,115,395.9	994,939.0	0.0	40,000.0	80,456.9					
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	1,638.5	0.0	0.0	0.0	1,638.5					
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	62,249.6	227,758.6	308,643.8	0.0	1,235,530.4					
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,413,171.3	5,612,054.6	4,557,337.6	719,655.0	335,062.0	1,390,101.3	247,410.4	2,046,747.8	2,025,910.2	
А. УРСГАЛ ЗАРЛАГА	5,515,082.9	4,212,506.2	4,148,710.1	0.0	63,796.1	1,376,672.0	242,404.7	1,566,642.8	1,563,668.0	
1. Бараа, үйлчилгээний зардал	2,810,532.6	1,755,347.1	1,691,550.9	0.0	63,796.1	20,015.8	0.0	1,196,588.5	1,193,613.7	
1.1. Цалин, хөлс	1,724,058.6	955,032.7	955,032.7	0.0	0.0	14,583.1	0.0	754,442.9	754,442.9	
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	0.0	76,796.8	76,796.8	0.0	0.0	1,603.4	0.0	83,018.4	83,018.4	
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	1,086,474.0	723,517.6	659,721.4	0.0	63,796.1	3,829.3	0.0	359,127.2	356,152.4	
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	696,937.4	617,613.8	617,613.8	0.0	0.0	0.0	79,279.5	44.0	44.0	
3. Татаас ба урсгал шилжүүлэг	2,007,612.9	1,839,545.3	1,839,545.3	0.0	0.0	1,356,656.2	163,125.2	370,010.3	370,010.3	
3.1. Татаас	99,759.6	384,443.4	384,443.4	0.0	0.0	167,520.7	0.0	5,046.7	5,046.7	
3.2. Урсгал шилжүүлэг	1,907,853.4	1,455,101.9	1,455,101.9	0.0	0.0	1,189,135.5	163,125.2	364,963.6	364,963.6	
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,898,247.2	1,410,682.4	456,128.2	719,655.0	234,899.3	13,429.3	5,005.7	469,129.8	462,242.2	
1. Барилга байгууламж	496,808.6	443,828.3	294,099.8	0.0	149,728.5	13,429.3	5,005.7	34,545.4	31,924.8	
2. Их засвар	36,777.3	36,777.3	32,867.0	0.0	3,910.3	0.0	0.0	0.0	0.0	
3. Тонг төхөөрөмж	101,106.8	96,839.7	15,579.2	0.0	81,260.4	0.0	0.0	4,267.1	0.0	
4. Бусад хөрөнгө	516,069.7	85,752.4	85,752.4	0.0	0.0	0.0	0.0	430,317.4	430,317.4	
5. Стратегийн нөөц хөрөнгө	27,829.7	27,829.7	27,829.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	719,655.0	719,655.0	0.0	719,655.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	-158.8	-11,134.0	-47,500.6	0.0	36,366.5	0.0	0.0	10,975.2	0.0	
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-47,500.6	-47,500.6	-47,500.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	47,341.8	36,366.5	0.0	0.0	36,366.5	0.0	0.0	10,975.2	0.0	
ТӨСВИЙН - Урсгал	675,360.2	-360,868.5			3,338.8	96,459.9	-773,253.2			
ТЭНЦЭЛ: - Нийт	-1,158,840.1	-4.8%	-1,532,658.3		298,553.3	91,454.2	-16,189.4			
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,158,840.1	1,532,658.3			-298,553.3	-91,454.2	16,189.4			
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	100,802.1	399,355.4			-298,553.3	0.0	0.0			
2. ЗГ-ын үнэт цаас	359,257.0	372,451.2			0.0	-13,194.2	0.0			
2.1. Урт хугацаат	359,257.0	372,451.2			0.0	-13,194.2	0.0			
2.1.1. Дотоод	359,257.0	372,451.2			0.0	-13,194.2	0.0			
2.1.1.1. Шинээр гаргах	2,491,705.8	2,100,000.0			0.0	391,705.8	0.0			
2.1.1.2. Үндсэн төлбөр	-2,132,448.8	-1,727,548.8			0.0	-404,900.0	0.0			
3. ЗГ-ын зээл	777,041.1	760,851.7			0.0	0.0	16,189.4			
3.1. Дотоод	624,791.7	624,791.7			0.0	0.0	0.0			
3.1.1. Зээл	-5,323.3	-5,323.3			0.0	0.0	0.0			
3.1.1.2. Үндсэн төлбөр	-5,323.3	-5,323.3			0.0	0.0	0.0			
3.1.2. Авлага	-89,540.0	-89,540.0			0.0	0.0	0.0			
3.1.2.2. Үндсэн төлбөр	-89,540.0	-89,540.0			0.0	0.0	0.0			
3.1.3. Төсвөөс эргэн төлөгдөх	719,655.0	719,655.0	719,655.0							
3.1.3.1. Авах	719,655.0	719,655.0	719,655.0							
3.2. Гадаад	152,249.4	136,060.0			0.0	0.0	16,189.4			
3.2.1. Төслийн зээл	152,249.4	136,060.0			0.0	0.0	16,189.4			
3.2.1.1. Шинээр авах	293,650.0	277,460.6			277,460.6	0.0	16,189.4		16,189.4	
3.2.1.2. Үндсэн төлбөр	-141,400.6	-141,400.6			0.0	0.0	0.0			
4. Урьдчилгаа төлбөр	-78,260.0	0.0			0.0	-78,260.0	0.0			
4.1. Суутган тооцоолт	-78,260.0	0.0			0.0	-78,260.0	0.0			
4.1.1. Оюутолгой	-105,000.0	0.0			0.0	-105,000.0	0.0			
4.1.2. Эрдэнэс МГЛ	-62,800.0	0.0			0.0	-62,800.0	0.0			
4.1.3. Улсын төсөвт үзүүс өглөг	89,540.0	0.0			0.0	89,540.0	0.0			
ДНБ	23,988,500.0	23,988,500.0			23,988,500.0	23,988,500.0	23,988,500.0			

	НЭГДСЭН ТӨСӨВ	УЛСЫН ТӨСӨВ	НДС	ХХС	ОРОН НУТАГ
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	26.2	17.1			
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	0.1	0.1			
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	26.1	17.0	7.0	1.4	8.5
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	25.8	16.1	5.8	1.4	3.3
1. Татварын орлого	21.2	11.9	5.8	1.2	3.0
1.1. Орлогын албан татвар	4.5	2.5	0.0	0.0	2.0
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	2.0	0.0	0.0	0.0	2.0
1.1.2 Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	2.5	2.5	0.0	0.0	0.0
1.1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	5.0	0.0	5.8	0.0	0.0
1.3. Өмчийн татвар	0.2	0.0	0.0	0.0	0.2
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	5.2	5.2	0.0	0.0	0.0
1.5. Онцгой албан татвар	1.6	1.6	0.0	0.0	0.0
1.6. Тусгай зориулалтын орлого	0.2	0.0	0.0	0.0	0.1
1.7. Гаалийн албан татвар	1.6	1.6	0.0	0.0	0.0
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	2.8	1.0	0.0	1.2	0.6
2. Татварын бус орлого	4.6	4.1	0.0	0.2	0.3
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.0	0.0	0.0	0.0	0.0
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	0.3	0.9	1.3	0.0	5.2
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30.9	23.4	5.8	1.0	8.5
А. УРСГАЛ ЗАРЛАГА	23.0	17.6	5.7	1.0	6.5
1. Бараа, үйлчилгээний зардал	11.7	7.3	0.1	0.0	5.0
1.1. Цалин, хөлс	7.2	4.0	0.1	0.0	3.1
1.3. Нийгмийн даатгалын шимтгэл	0.0	0.3	0.0	0.0	0.3
1.2. Бараа, үйлчилгээний бусад зардал	4.5	3.0	0.0	0.0	1.5
	0.0	0.0	0.0	0.0	0.0
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	2.9	2.6	0.0	0.3	0.0
3. Татаас ба урсгал шилжүүлэг	8.4	7.7	5.7	0.7	1.5
3.1. Татаас	0.4	1.6	0.7	0.0	0.0
3.2. Урсгал шилжүүлэг	8.0	6.1	5.0	0.7	1.5
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7.9	5.9	0.1	0.0	2.0
1. Барилга байгууламж	2.1	1.9	0.1	0.0	0.1
2. Их засвар	0.2	0.2	0.0	0.0	0.0
3. Тоног төхөөрөмж	0.4	0.4	0.0	0.0	0.0
4. Бусад хөрөнгө	2.2	0.4	0.0	0.0	1.8
5. Стратегийн нөөц хөрөнгө	0.1	0.1	0.0	0.0	0.0
6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	3.0	3.0	0.0	0.0	0.0
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0	0.0	0.0	0.0
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-0.2	-0.2	0.0	0.0	0.0
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	0.2	0.2	0.0	0.0	0.0
	0.0	0.0	0.0	0.0	0.0
ТӨСВИЙН - Урсгал	2.8	-1.5	0.0	0.4	-3.2
ТЭНЦЭЛ : - Нийт	-4.8	-6.4	1.2	0.4	-0.1

МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН БАТЛАГДСАН БОЛОН ТОДОТГОЛЫН ХАРЬЦУУЛАЛТ

	Өөрчлөлт				
	Нэгдсэн	Улсын	НДС	ХХС	Орон нутаг
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-905,640.1	-629,113.7	0.0	0.0	0.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН					
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-905,640.1	-629,113.7	-84,108.7	-187,429.9	-94,757.9
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	-905,640.1	-635,253.1	-72,621.3	-187,429.9	-23,630.0
1. Татварын орлого	-825,409.3	-585,022.3	-72,621.3	-157,429.9	-23,630.0
1.1. Орлогын албан татвар	-45,206.2	-21,686.2	0.0	0.0	-23,520.0
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	-23,520.0	0.0	0.0	0.0	-23,520.0
1.1.2 Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	-21,686.2	-21,686.2	0.0	0.0	0.0
1.1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	-59,327.0	0.0	-72,621.3	0.0	0.0
1.3. Өмчийн татвар	-110.0	0.0	0.0	0.0	-110.0
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	-413,077.7	-413,077.7	0.0	0.0	0.0
1.5. Онцгой албан татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.6. Тусгай зориулалтын орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.7. Гаалийн албан татвар	-67,290.9	-67,290.9	0.0	0.0	0.0
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	-240,397.4	-82,967.5	0.0	-157,429.9	0.0
2. Татварын бус орлого	-80,230.8	-50,230.8	0.0	-30,000.0	0.0
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.0	0.0	0.0	0.0	0.0
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	0.0	6,139.4	-11,487.4	0.0	-71,127.9
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГОД НИЙЦҮҮЛСЭН)	-185,985.1	8,777.2	-94,859.6	-94,915.0	-94,757.9
А. УРСГАЛ ЗАРЛАГА	-518,136.6	-407,006.3	-94,859.7	-94,915.0	-11,125.7
1. Бараа, үйлчилгээний зардал	-233,080.1	-234,124.8	-217.7	0.0	-12,031.9
1.1. Цалин, хөлс	-238,817.9	-234,677.7	-109.5	0.0	-4,030.7
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	-12,838.8	-12.0	0.0	-443.4
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	5,737.8	13,391.8	-96.1	0.0	-7,557.8
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	0.0	0.0
3. Татаас ба урсгал шилжүүлэг	-285,056.4	-172,881.5	-94,642.0	-94,915.0	906.1
3.1. Татаас	-43,846.4	-55,333.9	0.0	0.0	0.0
3.2. Урсгал шилжүүлэг	-241,210.0	-117,547.6	-94,642.0	-94,915.0	906.1
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	333,151.5	416,783.5	0.1	0.0	-83,632.1
1. Барилга байгууламж	-317,135.2	-317,135.3	0.0	0.0	0.0
2. Их засвар	16,982.9	16,982.9	0.0	0.0	0.0
3. Тоног төхөөрөмж	-12,719.1	-12,719.1	0.0	0.0	0.0
4. Бусад хөрөнгө	-73,632.1	10,000.0	0.0	0.0	-83,632.1
5. Стратегийн нөөц хөрөнгө	0.0	0.0	0.0	0.0	0.0
6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	719,655.0	719,655.0	0.0	0.0	0.0
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	-1,000.0	-1,000.0	0.0	0.0	0.0
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-1,000.0	-1,000.0	0.0	0.0	0.0
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	0.0	0.0	0.0	0.0	0.0
	0.0	0.0	0.0	0.0	0.0
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)					
- Урсгал	-387,503.5	-228,246.8	22,238.4	-92,514.9	-12,504.3
- Нийт	-719,655.0	-637,890.9	10,750.9	-92,514.9	0.0

	/сая төгрөг/										ДНБ-нд эзлэх хувь																												
	2010		2011		2012		2013		2014		2015		2010		2011		2012		2013		2014		2015																
	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл															
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.	10.	ЗӨРҮҮ	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.	10.	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.	10.								
ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,122,464.2	4,468,198.0	4,975,828.4	7,258,092.4	6,338,060.1	5,986,925.2	6,913,888.6	6,933,649.4	7,194,357.1	6,284,189.6	-910,167.4	43.5	33.9	29.8	38.0	33.2	31.3	31.9	32.0	30.0	26.2																		
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,122,464.2	4,227,178.1	4,881,171.9	7,088,333.7	6,289,094.9	5,940,066.7	6,883,889.0	6,903,849.8	7,159,971.2	6,254,331.2	-905,640.1	43.5	32.1	29.2	37.1	32.9	31.1	31.8	31.9	29.8	26.1																		
A. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	3,078,290.0	4,213,674.3	4,846,063.9	7,087,518.1	6,288,116.8	5,936,672.9	6,883,413.0	6,903,373.8	7,096,083.1	6,190,443.1	-905,640.1	42.9	32.0	29.0	37.1	32.9	31.1	31.8	31.9	29.6	25.8																		
1. Татварын орлого	2,688,236.3	3,668,307.8	4,203,321.5	6,461,531.6	5,601,220.9	5,072,793.3	6,227,154.1	6,227,154.1	5,900,456.4	5,075,047.2	-825,409.3	37.5	27.8	25.2	33.8	29.3	26.5	28.7	28.7	24.6	21.2																		
1.1. Орлогын албан татвар	974,970.8	833,738.9	871,401.5	1,261,481.6	1,268,530.9	1,109,204.9	1,283,655.1	1,283,655.1	1,128,423.0	1,083,216.8	-45,206.2	13.6	6.3	5.2	6.6	6.6	5.8	5.9	5.9	4.7	4.5																		
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	160,944.5	232,257.3	347,019.7	397,727.5	404,776.8	472,589.8	501,621.6	501,621.6	515,011.3	491,491.3	-23,520.0	2.2	1.8	2.1	2.1	2.1	2.5	2.3	2.3	2.1	2.0																		
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	390,854.5	545,631.1	524,325.9	863,754.0	863,754.0	660,159.0	782,033.5	782,033.5	613,411.7	591,725.5	-21,686.2	5.5	4.1	3.1	4.5	4.5	3.5	3.6	3.6	2.6	2.5																		
1.1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	423,171.8	55,850.6	55.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	5.9	0.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0																		
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	331,309.0	473,351.3	674,240.2	732,018.1	826,106.9	874,229.2	1,085,959.0	1,085,959.0	1,265,878.2	1,206,551.2	-59,327.0	4.6	3.6	4.0	3.8	4.3	4.6	5.0	5.0	5.3	5.0																		
1.3. Өмчийн татвар	13,812.1	17,152.2	21,929.9	23,765.5	24,306.3	43,975.4	33,284.6	33,284.6	49,814.5	49,704.5	-110.0	0.2	0.1	0.1	0.1	0.1	0.2	0.2	0.2	0.2	0.2																		
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	579,119.6	1,114,382.5	1,296,450.9	1,940,163.9	1,764,832.0	1,435,091.6	1,702,449.6	1,702,449.6	1,667,053.2	1,253,975.4	-413,077.7	8.1	8.5	7.8	10.1	9.2	7.5	7.9	7.9	6.9	5.2																		
1.5. Өнцгой албан татвар	268,526.7	293,967.0	312,384.2	595,227.5	455,775.8	449,410.3	597,712.5	597,712.5	393,160.5	393,160.5		3.7	2.2	1.9	3.1	2.4	2.4	2.8	2.8	1.6	1.6																		
1.6. Таусгай зориулалтын орлого	17,679.5	26,379.9	33,977.5	37,264.4	34,281.1	36,688.4	45,981.2	45,981.2	44,630.0	44,630.0	0.0	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2																		
1.7. Гаалийн албан татвар	193,321.7	337,422.6	327,369.8	575,299.6	516,606.5	381,427.0	426,243.2	426,243.2	443,802.0	376,511.1	-67,290.9	2.7	2.6	2.0	3.0	2.7	2.0	2.0	2.0	1.9	1.6																		
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	309,497.0	571,913.8	665,567.4	1,296,310.9	710,781.4	742,766.6	1,051,868.8	1,051,868.8	907,695.0	667,297.6	-240,397.4	4.3	4.3	4.0	6.8	3.7	3.9	4.9	4.9	3.8	2.8																		
2. Татварын бус орлого	390,053.6	545,366.5	642,742.4	625,986.5	686,895.9	863,879.6	656,258.9	676,219.7	1,195,626.7	1,115,395.9	-80,230.8	5.4	4.1	3.9	3.3	3.6	4.5	3.0	3.1	5.0	4.6																		
B. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	5,686.6	11,962.0	10,426.4	815.6	978.1	3,393.7	476.0	476.0	1,638.5	1,638.5	0.0	0.1	0.1	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0																		
B. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	38,487.6	1,541.8	24,681.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	62,249.6	62,249.6	0.0	0.5	0.0	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.3																		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,080,685.1	4,997,039.9	6,017,800.5	7,444,625.0	6,629,850.9	6,164,685.3	7,293,848.6	7,312,399.6	7,599,156.4	7,413,171.3	-185,985.1	43.0	37.9	36.1	38.9	34.7	32.2	33.7	33.8	31.7	30.9																		
Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, аж ахуйн нэгжийн өмчлөлийн хөрөнгөд ногдуулдаг татварын харилцааг нэгдсэн байдлаар зохицуулна.

Хөрөнгийн албан татварын тухай хуулийн төслөөр татварын хувь хэмжээг тогтоох орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх бөгөөд татварын орлогод өөрчлөлт оруулахгүй юм.

Мөн таван хошуу мал өмчилж байгаа иргэн, аж ахуйн нэгжид малын тоо толгойноос хамаарч татвар ногдуулах бөгөөд энэ нь 1 хонин толгойд ногдох албан татварыг жилд 0-1000 төгрөгний хооронд байхаар тооцож тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоох юм.

Иргэний өмчлөлийн мал нь хөрөнгө гэдэг утгаараа малчин, мал бүхий этгээдүүдийн хувьд татварын зорилгоор малаа албан ёсоор бүртгүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах томоохон боломж болох юм.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэдийн хувийн өмчлөлийн зүйлд ногддог татварын харилцааг нэгдсэн нэг хуулиар зохицуулах, улмаар уг татваруудыг өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөлтэй уялдуулах замаар хувь хэмжээг шинэчлэн тогтоох нь татварын тэгш шударга байх зарчмыг хангах ач холбогдолтой байна.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох хуулийн талаархи санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиудтай нийцүүлэн боловсруулах бөгөөд тэдгээртэй зөрчилдөхгүй. Хуулийн төсөл батлагдсанаар Татварын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж, Бууны албан татварын тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай, Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийг тус тус хүчингүй болгоно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа хувь хүн, хуулийн этгээдийн хөрөнгөд хөрөнгийн албан татвар /цаашид “албан татвар” гэх/ ногдуулах, уг албан татварыг төсөвт төвлөрүүлэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хөрөнгийн албан татварын тухай хууль тогтоомж

2.1.Хөрөнгийн албан татварын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулийн 5.1-д заасан этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө, автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл, таван хошуу мал болон буунд албан татвар ногдуулахад энэ хууль үйлчилнэ.

4 дүгээр зүйл. Нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."үл хөдлөх эд хөрөнгө" гэж Иргэний хуулийн 84.3-т заасныг;

4.1.2.“орон сууц” гэж Орон сууцны тухай хуулийн 3.1.1-д заасныг;

4.1.3."автотээврийн хэрэгсэл" гэж Автотээврийн тухай хуулийн 3.1.1-д заасныг;

4.1.4.“таван хошуу мал” гэж адуу, үхэр, тэмээ, хонь, ямааг;

4.1.5.“буу” гэж Галт зэвсгийн тухай хуульд тодорхойлсон галт зэвсгийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Албан татвар төлөгч

5 дугаар зүйл. Албан татвар төлөгч, албан татвар төлөгчийг бүртгэх

5.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт дор дурдсан хөрөнгө өмчилж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, оршин суугч бус этгээд, өмчийн бүх төрөлд хамаарах аж ахуйн нэгж, байгууллага албан татвар төлөгч байна:

5.1.1.үл хөдлөх эд хөрөнгө;

5.1.2.автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл;

5.1.3.таван хошуу мал;

5.1.4.буу.

5.2.Энэ хуулийн 5.1-д заасан этгээд нь автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл, буу болон таван хошуу мал өмчилж байгаа бол өөрийн харьяалах татварын албанд, үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байвал тухайн үл хөдлөх эд хөрөнгө байрлаж байгаа нутаг дэвсгэрийн татварын албанд тухайн хөрөнгийг өмчлөгч болсноос хойш нэг сарын дотор бүртгүүлнэ.

5.3.Татварын алба нь бүртгүүлсэн албан татвар төлөгчид гэрчилгээ олгох бөгөөд гэрчилгээний загварыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

5.4.Албан татвар төлөгч нь тухайн хөрөнгийн өмчлөлд орсон өөрчлөлтийн талаар энэ хуулийн 5.2-д заасан харьяалах татварын албанд нэг сарын дотор мэдэгдэнэ.

5.5.Татварын алба нь албан татвар төлөгчийн хөрөнгийн өмчлөлд орсон өөрчлөлтийг эрх бүхий байгууллагын албан ёсны баримт, мэдээллийг үндэслэн бүртгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Албан татвар ногдох хөрөнгө

6 дугаар зүйл. Албан татвар ногдох хөрөнгө

6.1.Албан татвар төлөгчийн дараах хөрөнгөд албан татвар ногдуулна:

6.1.1.бүх төрлийн үл хөдлөх эд хөрөнгө, хуулиар гэрчилгээ олгох шаардлагагүй, ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа 15 сая төгрөгөөс дээш үнэлгээтэй объект;

6.1.2.Монгол Улсад бүртгэлтэй автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл;

6.1.3.Монгол Улсад тоологдсон таван хошуу мал;

6.1.4.Монгол Улсад бүртгэлтэй бүх төрлийн буу.

7 дугаар зүйл. Албан татвар тооцох үзүүлэлт

7.1.Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг дор дурдсан журмаар тодорхойлно:

7.1.1.албан татвар ногдуулах үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний аргачлалын дагуу тодорхойлно.

7.1.2.энэ хуулийн 7.1.1-д заасан аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.1.3.энэ хуулийн 7.1.1-д заасан үнэлгээний зардлыг албан татвар төлөгч өөрөө хариуцна.

7.2.Иргэнд өмчлүүлэх газарт үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасныг үндэслэн тогтооно.

7.3.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн хувьд түүний төрөл, хөдөлгүүрийн багтаамж, даацыг үндэслэн албан татвар ногдуулна.

7.4.Улсын бүртгэлд байгаа автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд тэдгээрийг ашиглаж байгаа эсэхийг үл харгалзан албан татвар ногдуулна.

7.5.Таван хошуу малын хувьд хонин толгойд шилжүүлсэн тоонд үндэслэн албан татвар ногдуулах бөгөөд үхэр, адуу тус бүрийг 5, тэмээ, ямааг 2 хонин толгойд шилжүүлэн тооцно.

7.6.Албан татвар ногдуулах таван хошуу малын тоог тодорхойлохдоо өмнөх жилийн эцэст тоологдсон малын тоог үндэс болгоно. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-т заасан гамшгийн улмаас тухайн жилд албан татвар ногдуулах мал хорогдсон бол нотлох баримтыг үндэслэн албан татвар ногдуулах нийт малын тооноос хасна.

7.7.Бууны хувьд бууны төрөл, калибраас хамааруулан албан татвар ногдуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ **Албан татварын хувь хэмжээ**

8 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ

8.1.Үл хөдлөх эд хөрөнгөд албан татварыг энэ хуулийн 7.1-т заасан үнэлгээнээс тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 0.6-3.0 хувийн хязгаарт багтаан тогтооно.

8.2.Иргэнд өмчлүүлэх газрын үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 7.2-т заасан үнэлгээнээс энэ хуулийн 8.1-д заасан хувиар ногдуулна.

8.3.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг дараах хэмжээгээр ногдуулна:

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл		Жилд ногдуулах албан татварын дээд, доод хязгаар /төгрөгөөр/		
		Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумд	Бусад сумд	
1	Мотоцикл (цилиндрийн багтаамжаар)			
	1	400 см3 хүртэл	10,000-15,000	5,000-10,000
	2	400 см3-ээс дээш	20,000-30,000	15,000-25,000
2	Суудлын автомашин		/Цилиндрийн багтаамжийн нэг см3 тутамд төгрөгөөр/	
	1	2001 см3 хүртэл	16-72	14-21
	2	2001-3001 см3 хүртэл	18-81	16-24
	3	3001 см3 болон түүнээс дээш	22-99	20-30
3	Автобус түүнтэй адилтгах тээврийн хэрэгсэл			
	1	15 хүртэл хүний суудалтай	35,000-52,500	28,000-42,000
	2	15 аас дээш хүний суудалтай	52,000-78,000	40,000-60,000
4	Ачааны автомашин			
	1	1 хүртэл тн-ны даацтай	25,000-37,500	20,000-30,000
	2	1-2 тн-ны даацтай	35,000-52,500	28,000-42,000
	3	2-3 тн-ны даацтай	45,000-67,500	36,000-54,000
	4	3-5 тн-ны даацтай	55,000-82,500	44,000-66,000
	5	5-8 тн-ны даацтай	80,000-120,000	64,000-96,000
	6	8-10 тн-ны даацтай	90,000-135,000	72,000-108,000
	7	10-20 тн-ны даацтай	100,000-150,000	80,000-120,000
	8	20-30 тн-ны даацтай	140,000-210,000	120,000-180,000
	9	30-40 тн-ны даацтай	180,000-270,000	160,000-240,000
	10	40-50 тн-ны даацтай	220,000-330,000	200,000-300,000
	11	50-60 тн-ны даацтай	280,000-420,000	240,000-360,000
	12	60-70 тн-ны даацтай	320,000-480,000	280,000-420,000
	13	70-80 тн-ны даацтай	360,000-540,000	320,000-480,000
	14	80-90 тн-ны даацтай	400,000-600,000	380,000-570,000
	15	90-100 тн-ны даацтай	440,000-660,000	420,000-630,000
16	100 тн-оос дээш даацтай	480,000-720,000	440,000-660,000	

5	Тусгай зориулалтын автомашин, өөрөө явагч бусад хэрэгсэл, /трактор, бусад механизм/		100,000-150,000	80,000-120,000
6	Бага оврын трактор /30 хүртэл морины хүчтэй/		10,000-15,000	5,600-10,000
7	Чиргүүл /даацын 1 тонн тутамд/		5,500-8,250	5,500-8,250
8	Хагас чиргүүл /чиргүүлийн гол тутамд/		200,000-250,000	130,000-180,000
9	Аяны чиргүүл (өөрийн жингээр)			
	1	3 тн хүртэл	70,000-120,000	50,000-100,000
	2	3 тн-оос дээш	100,000-150,000	80,000-130,000
10	Эмээлт зүтгүүр		200,000-250,000	180,000-230,000

8.4.Суудлын ба ачааны хосолсон зориулалт бүхий автотээврийн хэрэгслийг суудлын автомашины төрөлд хамааруулна.

8.5.Ачааны болон тусгай зориулалтын хосолсон зориулалт бүхий автотээврийн хэрэгслийг ачааны автомашины төрөлд хамааруулна.

8.6.Энэ хуулийн 8.3.4-т заасан ачааны автомашины даацын хэмжээ хоёр ангилалд давхацсан тохиолдолд түүнийг өмнөх ангилалаар нь тооцож албан татвар ногдуулна.

8.7.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээг энэ хуулийн 8.3-т заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

8.8.Энэ хуулийн 7.5-д заасны дагуу тодорхойлсон хонин толгой тутамд ногдох албан татварыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 0-1000 төгрөгийн хязгаарт багтаан тогтооно.

8.9.Албан татвар ногдох буу бүрт албан татварыг дараах хэмжээгээр ногдуулна:

№	Бууны төрөл	Жилийн албан татварын хэмжээ /төгрөгөөр/
1	Үрлэн сумтай буу	50,000
2	6.4 мм хүртэлх калибрийн бүх төрлийн буу	50,000
3	6.5 ба түүнээс дээш мм-ийн калибрийн бүх төрлийн буу	100,000

9 дүгээр зүйл. Албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх

9.1.Дараах хөрөнгийг албан татвараас чөлөөлнө:

9.1.1.улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө;

9.1.2.албан татвар төлөгчийн өмчилж буй хоёр хүртэл орон сууц;

9.1.3.нийтийн эзэмшлийн барилга байгууламж;

9.1.4.газар тариалангийн тусгай зориулалттай үр тарианы комбайн, гинжит трактор;

9.1.5.улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах цэрэг, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон тахарын албаны үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл;

9.1.6.таван хошуу мал өмчлөгч этгээдийн 50 хүртэлх хонин толгой;

9.1.7.музейн үзмэр, урлагийн тоглолтод ашиглаж байгаа болон ангийн зориулалтаар ашиглах боломжгүй болохыг цагдаагийн байгууллага тогтоож үнэмлэх олгосон буу;

9.1.8.байгаль хамгаалагчийн эзэмшилд байгаа албаны буу;

9.1.9.спорт, сургалтын зориулалтаар дагнан ашиглаж байгаа буу;

9.1.10.улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон тахарын албаны бие бүрэлдэхүүний зэвсэглэлийн зориулалтаар ашиглаж байгаа бүх төрлийн буу.

9.2.Дараах хөрөнгийг албан татвараас хөнгөлнө:

9.2.1.газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг дараах байдлаар хөнгөлнө:

а/гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд өмчлүүлсэн газар:

- нийслэлд 100 хувиар;
- аймгийн төвд 100 хувиар;
- сумын төв, тосгонд 100 хувиар.

б/газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар иргэнд өмчлүүлсэн газар:

- нийслэлд 30 хувиар;
- аймгийн төвд 70 хувиар;
- сумын төв, тосгонд 85 хувиар.

9.2.2.газар тариалангийн зориулалтаар иргэнд өмчлүүлсэн газрыг 90 хувиар.

ТАВДУГААР БҮЛЭГ
Албан татвар ногдуулах, төсөвт
төлөх, тайлагнах

10 дугаар зүйл. Албан татвар ногдуулах, төсөвт төлөх, тайлагнах

10.1.Албан татвар төлөгч нь тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар бүртгэлтэй байгаа хөрөнгөд тухайн жилд ногдох албан татварыг төлөх бөгөөд жилийн дундуур шинээр нэмэгдсэн, эсхүл албан татвар төлөгдөөгүй хөрөнгийн албан татварыг тухайн хөрөнгийн өмчлөгч болсон хугацаагаар ногдуулж төлнө.

10.2.Тухайн хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй нь албан татвар төлөхгүй байх үндэслэл болохгүй.

10.3.Албан татвар төлөгч хувь хүн, оршин суугч бус этгээд нь тухайн жилд татвар ногдох буу, үл хөдлөх эд хөрөнгө болон таван хошуу малын албан татварыг энэ хуульд заасны дагуу 2 дугаар сарын 15-ны дотор жилд нэг удаа төлнө.

10.4.Албан татвар төлөгч хуулийн этгээд нь тухайн жилд татвар ногдох буу, үл хөдлөх эд хөрөнгийн болон таван хошуу малын албан татварыг энэ хуульд заасны дагуу 2 дугаар сарын 10-ны дотор жилд нэг удаа харьяалагдах төсөвт төлнө.

10.5.Албан татвар төлөгчийн тухайн жилд ногдох автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын төлөх хугацааг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

10.6.Албан татвар төлөгчийн тухайн жилд ногдох хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 10.3-10.5-д заасан хугацааны дотор төлөх бөгөөд татвар төлсөн хугацаанаас хойш албан татвар ногдох хөрөнгө шинээр нэмэгдсэн бол тухайн улиралдаа багтаан үлдсэн хугацаанд ногдох татварыг төлнө.

10.7.Албан татвар төлөгч жилд ногдох албан албан татварыг урьдчилан төлж болно.

10.8.Албан татвар төлөгчийн харьяалах татварын алба нь тухайн жилд ногдох албан татвараа төлснийг нь баталгаажуулж албан татвар төлөгчийн гэрчилгээнд бичилт хийнэ.

10.9.Газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ногдуулан хурааж, орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

10.10.Албан татвар төлөгч хуулийн этгээд нь хөрөнгийн албан татварын тайланг батлагдсан маягтын дагуу дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд ирүүлж, албан татварын жилийн эцсийн тооцоо хийнэ.

10.11.Албан татвар төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах, албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах аргачлал болон мөн хуулийн 10.10, 11.4-т заасан татварын тайлангийн маягтын загварыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг

11 дүгээр зүйл. Албан татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхтэй холбогдуулан төрийн байгууллагуудын гүйцэтгэх чиг үүрэг

11.1.Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлсөн тэмдэглэгээг үндэслэн тухайн тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, хасалт, үзлэг оношлогоог бүртгэх бөгөөд бүртгэл, шилжилт хөдөлгөөний болон техникийн хяналтын үзлэг, оношлогоонд хамрагдсан автотээврийн хэрэгслийн бүртгэлийн сар бүрийн мэдээг дараа сарын 10-ны дотор татварын албанд хүргүүлнэ.

11.2.Замын хөдөлгөөн зохицуулах байгууллага нь автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар ногдуулалт болон төлөлтөд татварын албатай хамтран хяналт тавьж, албан татвар хураах ажилд туслалцаа үзүүлнэ.

11.3.Цагдаагийн байгууллага нь бууны албан татвар төлсөн тэмдэглэгээг үндэслэн тухайн бууны шилжилт хөдөлгөөн болон хасалтыг бүртгэх бөгөөд бууны бүртгэл, шилжилт хөдөлгөөний сар бүрийн мэдээг дараа улирлын эхний сарын 10-ны дотор татварын албанд хүргүүлнэ.

11.4.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын жилийн тайланг нэгтгэж, нэг хувийг харьяалах татварын албанд дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор тушаана.

11.5.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үл хөдлөх эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хийхдээ татвар төлсөн баримтыг үндэслэх бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг улирал бүр татварын албанд хүргүүлнэ.

11.6.Үндэсний статистикийн газар нь жил бүрийн мал тооллогын дэлгэрэнгүй мэдээллийг Татварын ерөнхий газарт дараа жилийн 1 дүгээр сарын 20-ны дотор хүргүүлж байна.

12 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

12.1.Хөрөнгийн албан татварын тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд Татварын ерөнхий хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

13.1.Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ТАНИЛЦУУЛГА

Хөрөнгийн албан татварын тухай хуулийн төсөл

Одоогийн мөрдөж буй хуулиар Монгол Улсын иргэн хуулийн этгээдийн өмчилж буй үл хөдлөх хөрөнгө, автотээврийн хэрэгсэл, буунд тус тусын хуулиар татвар ногдуулж байна. Мөн малын тоо толгойд ногдуулах албан татварын харилцааг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар зохицуулж байна. Энэ нь дээрх хөрөнгүүдийг өмчилж буй татвар төлөгч нэг төрлийн татварыг харилцан адилгүй зарчмаар ногдуулж, 4 өөр хугацаанд төлж, тайлагнах, татварын албатай олон дахин харилцах зэрэг хүндрэлийг бий болгож байна.

Иймд татварын хуулийг төрөлжүүлэх, түүний хэрэгжилтийг хялбаршуулах зорилгоор иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгө болох үл хөдлөх эд хөрөнгө, буу, мал болон автотээвэр, өөрөөр явагч хэрэгсэлд ногдуулдаг татварыг нэгдсэн байдлаар зохицуулахаар Хөрөнгийн албан татварын тухай хуулийг боловсруулах нь зүйтэй гэж үзлээ.

Хөрөнгийн албан татварын тухай хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан одоо үйлчилж буй үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, автотээвэр, өөрөөр явагч хэрэгслийн албан татвар болон бууны албан татвартай холбоотой хуулиудыг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл, татварын хувь хэмжээг судлан үзвэл:

1. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас орон сууцыг чөлөөлж ирсэн нь иргэний амьдран суух орон сууцыг татвараас чөлөөлөх зорилготой юм. Гэвч зарим иргэдийн хувьд орон сууцыг амьдран суух зориулалтаар бус ашиг олох зорилгоор өмчилж, түрээсийн хөлсний байрууд ихэсч үүнд зөвхөн амьдран суух бус бизнесийн зорилгоор байр түрээслэх нь нэмэгдэж байна. Иймд иргэний хувийн өмчлөл дэх 2 орон сууцыг албан татвараас чөлөөлж, 3 буюу түүнээс дээш хэсэгт нь татвар ногдуулах нь хуулийн үндсэн зорилгоос гажихгүй юм.

Татварын албанаас 2014 онд зохион байгуулсан Үл хөдлөх эд хөрөнгийн улсын хэмжээний тооллогын дүнгээс харахад Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ бодитой бус, улсын хэмжээнд хөрөнгө үнэлэх нэгдсэн аргачлал байхгүйгээс өөр өөрөөр үнэлдэг, татвар ногдох хөрөнгийн ангилал, нэр төрөл тодорхой бус байгаа зэрэг нь хуулийн зохицуулалтыг сайжруулах шаардлагыг бий болгож байна. Тухайлбал, хөрөнгийг банкны зээл авах, бусдад худалдах болон татварын зорилгоор олон янзаар үнэлдэг, сэндвичэн барилга, түр барилга байгууламжуудад татвар ногдуулах эсэх асуудал тодорхой бус байгаа зэрэг болно. Мөн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилж буй газарт ногдох үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 97-98 хувиар хөнгөлж байгаа нь татвар хураах зардлыг нэмэгдүүлж татварын үр ашигтай байх зарчмыг алдагдуулж байна. Иймд эдгээр асуудлуудыг шийдвэрлэх, мөн үл хөдлөх эд хөрөнгийн

албан татварын хувь хэмжээг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь иргэдтэйгээ зөвшилцөх замаар тогтоох эрх мэдлийг нэмэгдүүлэх өөрчлөлтийг төсөлд тусгана.

2. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийг 1992 онд баталсан бөгөөд тухайн үед ашиглагдаж байсан автотээврийн хэрэгслийн төрөл, ангилал, хүчин чадлаар тооцон албан татвар ногдуулж байгаа нь өнөөгийн эдийн засаг тэлсэн, техник, технологийн өндөр өсөлтийн үетэй нийцэхгүй байна. Тухайлбал, мотоциклд дугуйны тооноос хамаарч 2000-4500 төгрөгийн албан татвар ногдуулж байгаа нь өндөр цилиндр бүхий нүүрс хүчлийн хий ихээр ялгаруулдаг мотоциклуудын хувьд татварын хэмжээ харьцангуй бага байгааг харуулж байна. Түүнчлэн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэрээр өндөр цилиндр, үнэ бүхий тансаг хэрэглээний автомашинууд шинээр орж ирэх болсон нь 1992 оны хуулийн үндсэн зарчмаас ихээхэн зөрүүтэй хэрэгжиж байна. Иймд тансаг хэрэглээний шинжтэй бөгөөд нүүрсхүчлийн хий ихээр ялгаруулдаг, өндөр цилиндр бүхий автотээврийн хэрэгслийн ангиллыг тодорхой болгох нь зүйтэй байна.

Түүнчлэн Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумдын суудлын автомашинд ногдуулах татварын хэмжээг тогтоох орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх болон автотээврийн хэрэгслийн татвар төлөх хугацааг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэх эрхтэй байхаар төсөлд тусгана.

3. 1993 онд батлагдсан Бууны албан татварын тухай хуулийн зохицуулалт өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн сайжруулах шаардлагатай байна. Одоогийн мөрдөж буй хуулиар буунд ногдох жилийн албан татвар 4,000-6,000 төгрөг байгаа юм. Энэхүү татварын хувь хэмжээнд 1997 оноос хойш өөрчлөлт ороогүй тул улс орны эдийн засгийн өөрчлөлт, инфляцын түвшин зэрэгтэй уялдуулан татварын хувь хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагатай байна. Түүнчлэн галт зэвсэг нь хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, хөнөөх чадвар бүхий тусгай хэрэгсэл учир бууг эзэмшиж буй этгээдийн хариуцлагыг өндөржүүлэх үүднээс бууны татварын хэмжээг өөрчлөх нь зүйтэй юм.

Дээрх 3 төрлийн татвараас гадна малын тоо толгойд ногдуулах татварыг түүний шинж чанарыг харгалзан Хөрөнгийн албан татварын төрөлд оруулах шаардлагатай байна. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу малчин өрх, мал бүхий этгээдэд малын тоо толгойд татвар ногдуулж байсныг малчдыг татварын бодлогоор дэмжих зорилгоор 2009 оноос эхлэн чөлөөлсөн. Гэвч мал тооллогын судалгаагаар малчин өрхөөс гадна, аж ахуйн нэгжүүд, гадаадын иргэд мал өмчилж, түүний ашиг шимийг хүртэж байгаа нь малчин өрхийг татварын бодлогоор дэмжиж байсан хуулийн зорилт өөрчлөгдсөн байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, иргэн аж ахуйн нэгжийн хөрөнгө болох мал аж ахуйн бүртгэл нь хөрөнгийн татвараас тусдаа байгаа нь нийгмийн

баялгийг жигд хуваарилах үндсэн зорилтоос зөрүүтэй болж байна.

Иймд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх, нийгмийн баялгийг дахин хуваарилах, татварын хуулийг төрөлжүүлэх, хялбаршуулах зорилгоор иргэд, аж ахуйн нэгжийн өмчлөлд байгаа таван хошуу малыг хөрөнгийн татварт хамруулах нь зүйтэй байх тул уг харилцааг Хөрөнгийн албан татварын тухай хуульд тусгах замаар холбогдох хуулийн төслийг боловсруулна.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, аж ахуйн нэгжийн өмчлөлийн хөрөнгөд ногдуулдаг татварын харилцааг нэгдсэн байдлаар зохицуулна.

Хөрөнгийн албан татварын тухай хуулийн төслөөр татварын хувь хэмжээг тогтоох орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх бөгөөд татварын орлогод өөрчлөлт оруулахгүй юм.

Мөн таван хошуу мал өмчилж байгаа иргэн, аж ахуйн нэгжид малын тоо толгойноос хамаарч татвар ногдуулах бөгөөд энэ нь 1 хонин толгойд ногдох албан татварыг жилд 0-1000 төгрөгийн хооронд байхаар тооцож тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоох юм.

Үндэсний статистикийн газраас хийсэн тооллогын дагуу 2013 оны байдлаар манай улс нийт 45 сая малтай гэж тоологдсоноос хонин толгойд шилжүүлж үзэхэд нийт 86.8 сая хонин толгой, үүнээс малын хорогдол болон чөлөөлөгдөх малын тоог хасвал 64.2 сая хонин толгой байна. Жилд 1 хонин толгойд ногдох татварыг 100 төгрөг байхаар тооцож үзвэл 6.4 тэрбум төгрөгийн орлого орон нутагт төвлөрөх боломжтой хэдий ч татварын доод хязгаарыг “0” байхаар тооцсон тул нэмж орлого орохоор төлөвлөхгүй. Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэхдээ Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар тодорхойлж байсан итгэлцүүрийг ашигласан.

Иргэний өмчлөлийн мал нь хөрөнгө гэдэг утгаараа малчин, мал бүхий этгээдүүдийн хувьд татварын зорилгоор малаа албан ёсоор бүртгүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах томоохон боломж болох юм.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэдийн хувийн өмчлөлийн зүйлд ногдог татварын харилцааг нэгдсэн нэг хуулиар зохицуулах, улмаар уг татваруудыг өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөлтэй уялдуулах замаар хувь хэмжээг шинэчлэн тогтоох нь татварын тэгш шударга байх зарчмыг хангах ач холбогдолтой байна.

ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

1. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
2. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
3. Бууны албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай
4. Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийг хүчингүй болсонд тооцох тухай
5. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай
6. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай
7. Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.4.19 дэх заалт нэмсүгэй:

“7.4.19.хөрөнгийн албан татвар.”

2 дугаар зүйл. Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.5.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 7.4.2, 7.4.14, 7.4.16, 7.4.19-д заасан болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.3-т заасан татварын хувь, хэмжээг Улсын Их Хурлаас баталсан хязгаарт багтаан тогтооно.”

3 дугаар зүйл. Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.3, 7.4.6, 7.4.13 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хөрөнгийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.8.14 дэх заалт нэмсүгэй:

“23.8.14.Хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6.1.3-т заасан албан татвар;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БУУНЫ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙГ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 1993 оны 05 дугаар сарын 11-ний өдөр баталсан Бууны албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**МОНГОЛ УЛСЫН АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН
АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 1992 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4.1.2, 4.1.3, 16.1.13 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ


1 дүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Бэлчээрийн газраас авах газрын төлбөрийг хонин толгойд шилжүүлсэн малын толгойн тоонд ногдуулахдаа Хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7.5 болон 7.6 дахь хэсгийг үндэслэн тооцно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**ДОЛОО. НИЙСЛЭЛ ХОТЫН АЛБАН
ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**



НИЙСЛЭЛ ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.1 дэх заалт, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.14 заалт, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17, 19 дүгээр зүйлд тус тус нийслэл хотын албан татвартай байхыг хуульчилсан байна.

Жилээс жилд орон нутгаас нийслэлд шилжин ирэх иргэдийн тоо ихээр нэмэгдэж, нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн идэвхжиж, хотын хүн амын өсөлт, төвлөрөл, шинээр байгуулагдаж байгаа болон өргөжин тэлж буй аж ахуйн үйл ажиллагаатай холбогдуулан нийслэлийн иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц хүрэлцэхгүй, хог хаягдал, агаарын бохирдол нэмэгдэж, нэн яаралтай шийдвэрлэх асуудал, тухайлбал гэрэлтүүлэг, камержуулалт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон эрчим хүч, цэвэрлэх байгууламжуудыг өргөтгөх, дулааны асуудлыг бүрэн шийдвэрлэхэд төсөв хөрөнгө хүрэлцэхгүй байна.

Иймд Нийслэл хотод тулгараад байгаа дээрх хүндрэл бэрхшээлийг тодорхой хэмжээгээр бууруулах, даван туулахад уг хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэн батлуулах шаардлага үүсч байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Нийслэл хотын албан татварын тухай хууль нь 13 зүйлтэй байна.

1, 2, 3, 4 дүгээр зүйлд: Хуулийн зорилт, зохицуулах харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт зэрэг багтана.

5, 6 дугаар зүйлд: Нийслэл хотын албан татвар төлөгч, суутгагч, түүнийг бүртгэх, бүртгэлээс хасах талаар зохицуулна.

7 дугаар зүйлд: Нийслэл хотын албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээний тодорхойлолтыг тусгана.

8, 9, 10 дугаар зүйлд: Нийслэл хотын албан татварыг тооцох үнэлгээ, хувь хэмжээ, уг татвараас чөлөөлөх нөхцлүүдийг тусгана.

11 дүгээр зүйлд: Нийслэл хотын албан татварыг төсөвт төлөх, тайлагнах талаар зохицуулна.

12, 13 дугаар зүйлд: Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага болон хууль хүчин төгөлдөр болох хугацааг тогтооно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ямар нэгэн хүндрэл үүсэхгүй бөгөөд нийслэлд тулгарч буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх санхүү, төсөв хөрөнгийн эх үүсвэр тодорхой болж, нэмэгдэнэ. Мөн энэхүү татвараас бий болох орлогын эх үүсвэрийг нийслэл хот төсвийн хувьд бие дааж хуулиар тогтоосон хязгаарын дотор шийдвэр гаргах, төсвөө үр ашигтай удирдах боломж бүрдэх юм.

Нөгөөтэйгүүр нийслэлд тулгараад буй дээрх асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломж бүрдсэнээр цаашид нийслэлийн эдийн засгийн өсөлт, хөгжилд нөлөөлөхүйц тодорхой түлхэц үзүүлэх юм.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох хуулийн талаархи санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиудтай нийцэх байгаа бөгөөд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙСЛЭЛ ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийслэл хотын албан татвар ногдуулах, уг татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Нийслэлийн хотын албан татварын тухай хууль тогтоомж

2.1.Нийслэл хотын албан татварын тухай хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Нийслэлийн нутаг дэвсгэрт албан татвар төлөгчөөс төлөх энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан суутгагчийн борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд нийслэл хотын албан татвар ногдуулахад энэ хууль үйлчилнэ.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."борлуулалт" гэж Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.1-д заасныг;

4.1.2."бараа" гэж Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.2-т заасныг;

4.1.3."ажил гүйцэтгэх" гэж Иргэний хуулийн 343.1-д заасныг;

4.1.4."үйлчилгээ" гэж Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.8-д заасныг;

4.1.5."хуулийн этгээд" гэж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3.1.1-д заасан этгээдийг;

4.1.6.“нийслэл” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг;

4.1.7. “эрүүл мэндийн үйлчилгээ” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасныг;

4.1.8.“боловсролын үйлчилгээ” гэж Боловсролын тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасны дагуу байгуулагдсан боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг;

4.1.9.“төрийн байгууллагын үйлчилгээ” гэж төрийн нэрийн өмнөөс үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын үйлчилгээг. Үүнд: Засгийн газар, түүний агентлагууд, төсөвт байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ хамаарна.

5 дугаар зүйл. Нийслэл хотын албан татвар төлөгч, суутгагч

5.1.Нийслэл хотын нутаг дэвсгэрт бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн хувь хүн, хуулийн этгээд нь нийслэл хотын албан татвар суутгагч (цаашид “суутгагч” гэх) байна.

5.2.Суутгагчаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авч буй хувь хүн, хуулийн этгээд нийслэл хотын албан татвар төлөгч байна.

6 дугаар зүйл. Суутгагчийг бүртгэх, бүртгэлээс хасах

6.1.Энэ хуулийн 5.1-д заасан хувь хүн, хуулийн этгээдийг харьяалах татварын алба нь татвар суутгагчаар бүртгэнэ.

6.2.Татвар суутгагч нь тухайн үйл ажиллагааг нэг жилээс дээш хугацаагаар эрхлэхгүй болсон нь орлогын албан татварын тайлангаар нотлогдсон тохиолдолд татвар суутгагчийн бүртгэлээс харьяалах татварын алба нь хасна.

7 дугаар зүйл. Нийслэл хотын албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээ

7.1.Энэ хуулийн 5.1-д заасан суутгагчийн тухайн нийслэлийн нутаг дэвсгэрт борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд нийслэл хотын албан татвар ногдуулна.

8 дугаар зүйл. Албан татвар тооцох үнэлгээ

8.1.Албан татвар тооцох үнэлгээг борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнийн дүнд үндэслэн тооцно.

8.2.Дараах тохиолдолд албан татвар тооцох үнэлгээг харьяалах татварын алба нь тухайн үеийн зах зээлийн бодит үнэд үндэслэн тодорхойлно:

8.2.1.борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнэ тодорхойгүй;

8.2.2.бараа, ажил, үйлчилгээг харилцан солилцсон буюу арилжсан;

8.2.3.харилцан хамаарал бүхий этгээдүүд үнэгүй, эсхүл бодит үнээс хямд буюу өндөр үнээр хоорондоо бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн;

8.6.4.өр төлбөрийг бараа шилжүүлэх, ажил үйлчилгээ үзүүлэх замаар хаасан.

8.3.Албан татвар тооцох үнэлгээг гадаад валютаар хийсэн бол гүйлгээ хийгдсэн өдрийн Монголбанкны ханшийг үндэслэн төгрөгт шилжүүлнэ.

9 дүгээр зүйл. Нийслэл хотын албан татварын хувь хэмжээ

9.1.Тухайн борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнийн дүнгийн 0-1.0 хувиар тооцож гийслэл хотын албан татварыг ногдуулна.

9.2.Нийслэл хотын албан татварын хувь, хэмжээг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 9.1-д заасан хязгаарт багтаан батална.

10 дугаар зүйл. Нийслэл хотын албан татвараас чөлөөлөх

10.1.Эрүүл мэнд, боловсрол болон төрийн байгууллагын үзүүлж байгаа үйлчилгээг нийслэл хотын албан татвараас чөлөөлнө.

11 дүгээр зүйл. Нийслэл хотын албан татвар ногдуулах, төсөвт төлөх, тайлагнах

11.1.Суутгагч нь нийслэл хотын албан татварыг бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд суутган авч, төлбөрийн баримт дээр нийслэл хотын албан татварын хувь, хэмжээг тусгана.

11.2.Суутгагч нь тухайн сард борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд ногдох албан татварыг дараа сарын 10-ны өдрийн дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, батлагдсан маягтын дагуу тайлангаа дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд, нийслэлд бүртгэлгүй суутгагч бол нийслэлийн татварын албанд тус тус тушаана.

11.3.Энэ хуулийн дагуу татвар суутгагчийг бүртгэх, бүртгэлээс хасах, албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах аргачлал, тайлангийн маягтыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

12 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

12.1.Нийслэл хотын албан татварын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Татварын ерөнхий хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

13.1.Энэ хуулийг 2015 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төсөл

Улсын Их Хурлаас 1994 онд анх Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталснаар олон жилийн түүхтэй нийслэл хотын эрх зүйн үндэс шинэчлэгдсэн. Уг хуулийн 17 дугаар зүйлд “Нийслэл хот бие даасан төсөвтэй байна”, 19 дүгээр зүйлд “Нийслэл хот татвартай байна, татварыг хуулиар тогтооно” гэж заасан байдаг. Мөн Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.14-д Нийслэл хотын албан татвар нь орон нутгийн татварт хамаарахаар тус тус заасан боловч нийслэл хотын албан татварын тухай хууль өнөөг хүртэл батлагдаагүй байна.

Дэлхийн ихэнх улс орнууд, тэр дундаа АНУ, Япон, Солонгос зэрэг улсуудын хувьд хотын татварыг төрөлжүүлэн авдаг болоод багагүй хугацаа өнгөрчээ. Эдгээр улсуудын хотын татвар нь худалдааны, оршин суугчийн, хот төлөвлөлтийн албан татвар гэсэн төрөлтэй байдаг бөгөөд зарим тохиолдолд хотын албан татварын тусгайлсан хуулиар зохицуулагддаг.

Татварыг орлогод, хөрөнгөд болон хэрэглээнд гэсэн 3 үндсэн зүйлд ногдуулдаг. Эдгээрээс хотын татварыг ногдуулах хамгийн зохистой зүйл бол хэрэглээ буюу хотын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ юм. Хэрэглээний татвар нутаг дэвсгэрийн зарчимд тулгуурладаг бөгөөд уг зарчимд суурилсан татварын хувьд давхар татварын асуудал гардаггүй. Иймд олон улсын практикаар хот, мужийн татварыг бараа, ажил, үйлчилгээнд ногдуулж авах нь түгээмэл байна. Тухайлбал АНУ, Канад, Энэтхэг зэрэг улсын Холбооны Засгийн газраас тогтоосон НӨАТ дээр зарим мужууд нь 5, 7, 8 хувийн мужийн борлуулалтын татварыг нэмж авдаг. Ингэснээр ялгаатай хувь хэмжээтэй НӨАТ-ыг муж тус бүр мөрдөж байна.

Эдгээр орнуудын туршлагад үндэслэн төвлөрлийг сааруулах, орон нутгийг хөгжүүлэх, эрүүл мэнд, боловсролын салбарын үйлчилгээний чанарыг сайжруулах гэх мэт хотын өдөр тутмын амьдралд тулгарч буй олон асуудлыг эдийн засгийн аргаар шийдвэрлэх зорилгоор нийслэл хотод бизнес эрхэлсэн бол энэ төрлийн татварыг ногдуулдаг байхаар хуулийн төслийг боловсруулж байна. Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төсөл нь 13 зүйлээс бүрдэнэ. Үүнд:

Хуулийн төслийн **1, 2, 3 дугаар зүйлд** уг хуулийн зорилт, хууль тогтоомж, үйлчлэх хүрээг тогтоож өгсөн бөгөөд нийслэл хотын албан татварыг албан татвар суутгагчийн борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд ногдуулахаар заасан.

Хуулийн нэр томъёоны тодорхойлолт гэсэн **4 дүгээр зүйлээр** уг хуулийн төсөлд хэрэглэсэн “борлуулалт”, “бараа”, “ажил гүйцэтгэх”, “үйлчилгээ”, “хуулийн этгээд”, “нийслэл”, “эрүүл мэндийн үйлчилгээ”, “боловсролын үйлчилгээ”, “төрийн байгууллагын үйлчилгээ” гэсэн нэр томъёоны утгыг тодорхойлсон.

Хуулийн төслийн **5 дугаар зүйлд** албан татвар суутгагч нь нийслэл хотын нутаг дэвсгэрт бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн хувь хүн, хуулийн этгээд байх ба суутгагчаас бараа, ажил, үйлчилгээг худалдан авч буй хувь хүн, хуулийн

этгээд хотын албан татвар төлөгч байхаар заасан. Хуулийн төслийн **6 дугаар зүйлд** суутгагчийг бүртгэх, бүртгэлээс хасах асуудлыг тусгаж өгсөн.

Хуулийн төслийн **7 дугаар зүйлд** албан татвар суутгагчийн нийслэл хотын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд хотын албан татвар ногдуулахаар заасан. Хуулийн төслийн **8 дугаар зүйлд** албан татвар тооцох үнэлгээг тооцохдоо борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнийн дүнг үндэслэхээр тусгасан. Харин үнийн дүнг тодорхойлох боломжгүй, бараа, ажил, үйлчилгээг харилцан солилцсон буюу арилжсан, мөн харилцан хамаарал бүхий этгээдүүд үнэгүй, эсхүл бодит үнээс хямд буюу өндөр үнээр хоорондоо бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тохиолдлуудад албан татвар тооцох үнэлгээг харьяалах татварын алба нь тухайн зах зээлийн бодит үнэд үндэслэн үнэлгээг тооцохоор заасан.

Нийслэл хотын албан татварын хувь хэмжээ гэсэн хуулийн төслийн **9 дүгээр зүйлд** Нийслэл хотын албан татварын хувь, хэмжээг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 0-1.0 хувийн хязгаарт багтаан батлахаар тусгаж өгсөн.

Хуулийн төслийн **10 дугаар зүйлд** Нийслэл хотын албан татвараас эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ болон төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг чөлөөлөхөөр тусгасан.

Нийслэл хотын албан татвар төсөвт төлөх, тайлагнах гэсэн хуулийн төслийн **11 дүгээр зүйлд** албан татвар суутгагч нь тухайн сард борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг дараа сарын 10-ны дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, тайлангаа дараа улирлын эхний сарын 20-ны дотор харьяалах татварын албанд тушаахаар заасан.

Хуулийн төслийн **12 дугаар зүйлд** Нийслэл хотын албан татварын тухай хууль, тогтоомж зөрчсөн этгээдэд Татварын ерөнхий хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан.

Хуулийн төслийн **13 дугаар зүйлд** Нийслэл хотын албан татварын тухай хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан.

Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төсөл батлагдан гарч эдийн засгийн зохицуулалт хийж эхэлснээр иргэдэд татвар багатай газар амьдрах эрмэлзэл төрж хотоос гадагшлах, дагуул хот тосгонд шинэ суурьшил бий болон хөгжих зэрэг чухал ач холбогдолтой. Мөн энэхүү татвараас бий болох орлогын эх үүсвэрийг тухайн орон нутаг өөрийн төсөвт төвлөрүүлэн, орон нутаг төсвийн хувьд бие дааж, шийдвэр гаргах, төсвөө үр ашигтай удирдах, төвлөрлийг сааруулахад чиглэгдэж байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Нийслэл хотын албан татварын хувь хэмжээг “0” байхаар тогтоох бүрэн эрхтэй учир төсөвт орлого нэмж төвлөрүүлэхээр тооцоогүй.